

6236-1-1

ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

ШИХИХУТУГ



ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ 2007/1

Сэтгүүлийн зөвлөл:

Д.Лүндээжанцан	(эрхлэгч)
О.Амархүү	(ерөнхий редактор)

Гишүүд: Ж.Болдбаатар
 Ч.Энхбаатар
 Н.Лүндэндорж
 Б.Мандахбилэг
 Н.Батболд (нарийн бичгийн дарга)

РЕДАКЦИЙН ХАЯГ: Сүхбаатар дүүрэг 6 дугаар хороо,
 Их сургуулийн гудамж, Шихихутуг ХЗДС-ийн
 хичээлийн I байр.

Web site: www.shikhihutug.edu.mn
 E-mail: shikhi_setguul@yahoo.com
 Утас: 314977
 91181909
 99150269



ЭНЭ ДУГААРТ

ОНОЛ ЯРГА ЗҮҮ, ТҮҮН, УЛАМЖЛАЛ, СОЁЛ ИРГЭНШИЛ:

Ж.Болдбаатар © МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЯЗГУУР ЭРХ АШИГ БА УЛС ТӨРИЙН НАМУУД	3
Ш.Сүхбаатар © НЭР ТӨР, ААДАР ХҮНДИЙН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛААТ Ц.Цэлмэг	10
© АШИГТ МААТМААЛЫН ХАЙГУУА ХИЙХ, ОЛБОРЛОХ ЖУРАМ ЗӨРЧИХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОН КРИМИНОЛОГИЙН ЗАРИМ АСУУДАА	22
М.Батсуурь © ТЭГШ ЭРХИЙН ЗАРЧИМД ЭРХ ЧӨЛӨӨ, ЭРХ ЗҮЙТ ЁСНЫ ҮҮДНЭЭС ХАНДАХ НЬ	28
Ч.Өнөрбаяр © ҮНДСЭН ЭРХ, СУУРЬ ОЙЛГОАЛТ, ТУЛАМДСАН АСУУДАА, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	38

ҮЗЭЛ БОДОЛ, ЧӨЛӨӨТ ХУУДАС:

Д.Батсайхан © ЦАГДААГИЙН БАЙГУУЛААГИЙН ҮЙЛ АЖЛААГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛААЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДААД	54
----------------------------------------------------------------------------------------------------------------------	----

ГЯДААД ОРНЫ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮҮ:

Ж.Хулан © ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛААТ	75
--------------------------------------------------------------------------	----

КУУЛЬЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

М.Алтан-Өлзий © АDR БУЮУ МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧААХ АЖЛААГАА	83
Миха, Изка © ШИНХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ЭЧНЭЭ АНГИД ХИЙХ ЛЕКЦИЙН АГУУЛАГА	86

ШИНХИХУТУГ СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЭЛ

ШИНХИХУТУГААР ОВОГЛОСОН ЭРДМИЙН ОРГОО 15 ЖИЛИЙН ОЙН БАЯРАА ЁСЛОЛ ТОГОЛДОР ТЭМДЭГЛЭВ	92
О.АМАРХҮҮ ХҮНДЭТТЭЛИЙН ЛЕКЦ УНШИВ	94-103

ШИНЭ НОМ

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЯЗГУУР ЭРХ АШИГ БА УЛС ТӨРИЙН НАМУУД

Академик Ж.Болдбаатар

Монгол Улсын Их Хурлаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д: “Монгол улсын үндэсний язгуур эрх ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил тогтнох, Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл байна” (1.3) гэж заасан байна. Үүнээс үндэслэн, манай улс төрийн ном, зохиол, хэвлэлүүдэд: “улс төрийн хэрэгцээ”, “улс төрийн сонирхол”, “улс төрийн үнэлэмж”, “үндэсний эрх ашиг сонирхол”, “үндэсний язгуур эрх ашиг” гэх мэтийн хоорондоо нягт холбоотой олон томъёололыг өргөн хэрэглэж байна. Ялангуяа “үндэсний язгуур эрх ашиг”, “үндэсний ашиг сонирхол” гэсэн нэгэн адил утгаар хэрэглэж байгааг эргэцүүлж үзмээр санагдана. Учир нь сонирхол нь хувьсамтгай, хөдөлгөөнт, эрчимт шинжтэй байдаг бол хэрэгцээ нь илүү бат тогтвортой, суурь шинжтэй ойлголт юм.

Үндэсний эрх ашиг нь тухайн улс түмний язгуур үнэт зүйл-үндэсний тусгаар тогтнол, түүний аюулгүй байдал, нийгмийн амин чухал хэрэгцээ болох хүн, түүний-баталгаатай амьдрах таатай орчин-иргэний нээлттэй нийгэм, эрх зүйт төр, хүний эрх, эрх чөлөө болой. Ийнхүү үндэсний эрх ашиг хэмээх ойлголт хэрэгцээ талаасаа түлхүү тодорхойлогдож байна. Тэгвэл үндэсний ашиг сонирхол нь илүү ойрын зорилтоос урган гарсан, тактикийн шинжтэй, харьцангуй тодорхой хугацаанд үйлчлэх асуудлуудыг хөндөнө. Ийм учраас төр засгийн болон улс төрийн намын баримт бичгүүдэд эл ойлголтыг жигдрүүлж, нэг мөр болгомоор байна.

Улс төрийн нам байгуулах асуудлыг үндэсний язгуур эрх ашгийн хүрээнд хуулиар зөвшөөрсөн байдаг бөгөөд ийм ч учраас “Улс төрийн намын тухай” Монгол Улсын хууль-д: “Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэстний эв нэгдлийг задлан бутаргах,

Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг түйвээн үймүүлэх, аллага хядлага үйлдэх, яс үндэс, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг хориглоно" (2,126) гэжээ.

Нам судлаачдын үзэж байгаагаар: улс төрийн нам гэдэг нь үндэсний язгуур эрх ашгийн хүрээнд улс төрийн тодорхой номлолыг тойрч нэгдсэн, ашиг сонирхлоороо ойролцоо буюу нэгдмэл хүмүүсийн улс үндэстний хийгээд улс төрийн тогтолцооны бүрдэл болох түвшинд зохион байгуулагдсан, засаглалыг ардчилсан арга замаар авч, хэрэгжүүлэх зорилго бүхий улс төрийн байгууллагын институтжсэн өвөрмөц хэлбэр мөн (3,84) гэж тодорхойлж байна.

Эдүгээ манайд улсын бүртгэлтэй 20 шахам нам ажиллаж байна. Эдгээр намуудыг үзэл баримтлалын нь үүднээс шинжилж үзвэл бүгд л үндэсний ардчилсан үзэл дээр тулгуурлан үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн тунхаглаж, бүгдээрээ л ардчилал, зах зээлийн төлөө зогсож байна. Парламентад эзэлж буй байр сууриар нь ангилвал:

1. Парламентад олон суудал авч, намын бүлгээ байгуулан ажиллаж буй нам (МАХН)

2. Парламентад зохих суудал авч, эвсэл байгуулан ажиллаж байгаад тарсан намууд (МоАН, Иргэний Зориг-Бүгд Найрамдах Нам, МАШСН буюу саяхан нэрээ сольсон Эх Орон нам)

3. Парламентад цөөн тооны суудалтай нам. (Монголын Бүгд Найрамдах Нам) ажиллаж байна.

Монголд олон намын тогтолцоо бүрдүүлснээс хойш Монгол улсын үндэсний язгуур эрх ашигт шууд харшлах үйлдэл хийгээгүй боловч, бие биеийнхээ нэр хүндийг унагах үүднээс улсын нууцтай холбоотой мэдээ хэвлэлээр цацах, утга учиргүй ам өрсөн хэрүүл шуугиан дэгдээх, улс төрийг бизнесийн эрх ашигтай хутгах зэрэг хөөнд ассан ямаалзгана мэт өнгийн бодолгүй, болчимгүй явдал гаргаж буй намууд байгаа нь улс үндэстний эрх ашигт сэв суулгаж байгааг хэлэх хэрэгтэй юм.

Улс төрийн намууд, тэдний удирдагчдын ийм гаж үзэл бодол, үйлдэл үргэлжилбэл цаашид үндэсний эрх ашигт харш, үндэсний эв нэгдлийг бусниулахад хүргэж болохыг ухамсарлаж, дараах зүйлийг анхаармаар байна. Үүнд:

- Улс төрийн намуудын төлөвшлийг тогтвортой бүрэлдүүлэхүйц чиглэлээр “Улсын төрийн намуудын тухай” хуулийг байнга боловсронгуй болгох шаардлагатай байна. УИХ-аас тус хуульд оруулсан өөрчлөлт бол мөн л тийм нэгэн алхам юм. “Намын эрх зүй” хэмээхгүйг боловсруулж, онол-үйлдлэгийн төвшинд тавих хэрэгтэй болж байна.

- Аль ч улс төрийн нам төр, засгийн янз бүрийн шатны албан тушаалд хүнээ таньж, олж, дэвшүүлж байх нь чухал юм. Учир нь улс төрийн намууд: “Шинжлэх ухааны салбаруудаас улс төр шиг авъяас чадваргүй хүмүүсээр тэгтлээ зэрэмдэглүүлсэн нь үгүй” /4.125/ хэмээн Германы их сэтгэгч Фридрих Генцийн хэлсэн үгийг ямагт санаж байх ёстой.

Оноодор манай төр засгийн түвшинд эрдэм ухааныг огоорч, мөнгөтэй хүн ямар ч албан тушаал эрхэлж болно гэсэн хандлага бий болсон нь нууц биш юм. Хүний нөөцийн үндэсний чадавхийг зохистой ашиглах бодлого алдагдаж байна. Ийм учраас төрийн түшээ, төрийн албан хаагчид бага юм мэддэгээ ухаарахын тулд маш их шаргуу суралцах хэрэгтэй болж байна. Өөрөөр хэлбэл, мэдлэгээ ямагт хүрэлцэхгүй байгааг ойлгон мэдэрч, хичээнгүйлэн суралцах, мөн олж мэдсэнээ үргэлж чамлаж билгийн чинадал тэмүүлэх шаардлагатай байна. Их Чингис хаан: “Ухаан, эрдэм хоёр эс нийлбээс их үйлийг бүтээж үл чадъяу” хэмээн эгээ л нэг хэлээгүй болов уу.

- Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Парламентын тэргүүн, хичнээн том намын дарга ч бай, тэдний үзэл бодлыг цэгнэх цорын ганц хэмжүүр буй бөгөөд тэр нь үндэсний язгуур эрх ашиг гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Намын болон хувийн явцуу эрх ашигт шунан захирагдах тусам үндэсний язгуур эрх ашигт өө сөв суулгаж болохыг хэнбугай ч сэтгэлдээ хатуу чандлан сүншиглэх ёстой. Одгөөгийн улс төрийн амьдралд гарч буй хямралын шинжтэй үзэгдэл нь төр, түмний үйлсэд явч сайн зүйл биш бөгөөд явж явж үндэсний эрх ашигт л хохирол учруулах хор холбогдолтой хэрэг юм.

- Хэрэв тухайн нам улс үндэстнийхээ эрх ашгийг эрхэмлэж байгаа бол нөгөө намынхаа эерэг алхам бүрийг дэмжиж, сөрөг үзэгдэл бүхнийг шүүмжилж, засч залруулахад тусалж байх ёстой. Гэтэл өнөөгийн залуу улс төрчид сөрөг намынхаа эерэг алхам бүрийг ямар ч хамаагүй аргаар харлуудан гутаахад чиглэж байгаа нь харамсалтай байна. Жишээ нь: өмнөх сонгуулийн хугацааны үед МАХН-ын бүрдүүлсэн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусч, хэрэгжин, хүн бүхний нүдэн дээр үр ашгаа өгч эхэлж байгаа "Мянганы зам"-ыг "мянгуужингийн үлгэр" мэтээр гутаах оролдлого гарч байсныг бид мэднэ. Ц.Элбэгдоржийн засгийн газрын үед "Ногоон хэрэм" хөтөлбөр гэж ярьж эхэлсэнээ одоо чимээгүй болжээ. Иймээс улс төрчид сөрөг намынхаа хийж буй сайн зүйл бүхнийг хүлээн зөвшөөрч чаддаг байх нь нийгэмд эрүүл саруул, ардчилсан сэтгэлгээ зонхилж буйн шинж, улс үндэстэн хөгжин дэвшиж, урагшлахын өнгө төрх мөн. Тэвчихүй, үл тэвчихүйн хооронд их зааг байх боловч, үндэсний эрх ашиг түүнийг зохистой харьцаанд нь тавих бөгөөд тэр нь төрийн мяндсан ухааны үл тасалдах уламжлалт, залгамж шинжийг агуулна. Тухайн нам үндэсний эрх ашгийг эрхэмлэж байгаагаа амаар биш ажлаараа харуулах ёстой. Хэлсэн нь хийсч, үйлдсэн нь үлддэг хорвоо шүү дээ.

-Улс төрд ухаан гэж байхаас сэтгэл гэж байдаггүй гэдэг. Нямдорж, Гүндалай нарыг төрийн түшээгийн зиндаанд хүрээгүй байхад тэр болгон хүн анзаардаггүй байсан. Харин УИХ-ын гишүүн, УИХ-ын дарга, төрийн сайд болоод олны анхааралд ормогч хувь хүн тал нь бүдгэрч, дуугарч, үйлдэж байгаа бүхэн нь төрийн хүнийх болно. Ийм учраас төрийн хүний төв эрхэмсэг шинжийг монголчууд эрхэмлэн дээдэлж иржээ. Миний багш, академич С.Норовсамбуу нэг удаа надад ярихдаа: "Одоогийн улс төрчид чинь тун зовлонтой хүмүүс юм. Үнэнийг худлаа болгож ярина, худлааг үнэн болгож ярина, үнэн, худлыг хольж ярина, энэ бүхнээс хожоо, хонжоо харна. Үүнийг гүн ухаанд эклектизм гэдэг юм" гэж бүлгээ. Өвгөн багшийн минь үг улс төрийн залуу зүтгэлтнүүдэд ихэд сургамжтай болой.

Дорно дахины уламжлал ёсоор төрийн хашир зүтгэлтэн хүн хийхээсээ бодох нь их, хэлэхээсээ дуугүй байх нь их болдог. Үүнээс "Дуугарах мөнгө, харин дуугүй байх алт", "Учиртай ярианд ухаан төвлөрч, увайгүй чалчихад

ухаан сарнина” хэмээх үг гарчээ. Төрийн түшээ хүний төв эрхэмсэг шинжийн тулгуур төрх ийм л байх. Харин хааяа дуугарах ухаандаа богинож, хэлэндээ ширгээсэн үг нь хүний оройруу орж, зүрхэн тольтод бадамлахаар байх ёстой.

Төрийн зүтгэлтний төв эрхэмсэг шинж нь явцуу утгаараа төрийн зүтгэлтэн хүн дотоод ертөнц, гүн бясалгалаа олон түмэн, хувь хүн, мөн харийнханд илэрхийлэх гадаад илрэл мөн. Оргон утгаараа, төрийн зүтгэлтэнд буйлан шингэсэн цогц мэдлэг, чадвар, ааль авир нь нийгэм, олон түмэнд ээлтэй тусах тусан, улс төрийн бодлогын давхар оньсыг улс үндэстнийхээ эрх ашигт эерэгээр мултлах чадвар юм. Товчоор хэлбэл, төрийн зүтгэлтний эрхтэй атлаа болгоомжтой, найртай атлаа хэрсүү байх чанар, намбалаг бөгөөд сүрлэг байх гадаад илрэл юм. Улс төрийн намын зүтгэлтнүүд энэ л шинжийг эрхэмлэж байж сая амжилтанд хүрнэ.

-Омнох үеэ аргадаж тойлж хандсан нам, улс төрийн зүтгэлтэн юм юмтай хоцордог нь түүхэн жам ёсон. Эстонийн нэрт яруу найрагч Юхан Лив: “Урьдын түүхээ мэдэхгүй хүн, ирээдүйн амьдралгүйтэй адил” хэмээн тун онож хэлжээ. Улс төрчид онгөрсөн үедээ түүхэн зүхлийн үүднээс бус түүхэн ухаарлын үүднээс хандах нь чухал.

“Ахаараа тогловол

Арван дааганы алдангитай

Төрөөрөө тогловол

Түмэн дааганы алдангитай” хэмээх ардын мэргэн үгийг улс төрчид сэтгэлийнхээ мухарт хадгалж байхад илүүдэхгүй болов уу.

-Хэрэв Таны харьяалагдаж буй нам чинь үндэсний язгуур эрх ашгийн төлөө байгаа бол атгаг бодолгүй намдаа саналаа өгөх нь зөв. Харин үндэсний язгуур эрх ашигт өө сөв, бүр хохирол учруулахаар бол намын эрх ашиг гэдэг үндэсний эрх ашигтай харьцуулвал тун өчүүхэн гэдгийг ухаарвал зохино. Их бодож, үнэнийг шигшихэд ийм л гаргалгаа гарна. Үнэн үнэндээ багтдаг гэдэг энэ буюу. Сонгуулийн үед бие биеэ өөлөх баалах, сонгогчдоо худал амлах, эд зүйл, мөнгөөр татах, ил, далд гүжир гүтгэлэг тараах зэргээр хууль зөрчиж, увайгүй, эрээ цээргүй загинах нь үндэсний эв нэгдэлд туйлын харш юм. Нам, эвслүүд сонгогчдыг

талцуулахгүй, бүгдэд тэгш, соёлтой хандах нь нийгмийн тогтвортой байдал, эв нэгдлийг сулруулахгүй байх гол хүчин зүйл мөн.

-Улс төрийн намууд үндэсний эрх ашгийн үүднээс байнга зөвшилцөж, хэл амаа ололцож байх ёстой. 2004 оны УИХ-ын сонгуулиас хойш үүсэн бий болсон нөхцөлд намууд нухацтай дүн шинжилгээ хийж, харилцан зөвшилцсөний үр дүнд их эвслийн засгийн газар байгуулсан билээ. Гэвч "Эх орон, ардчилал" эвсэл задарснаас шинэ нөхцөл байдал бий болж, Ардчилсан намын гишүүд МАХН-ын бүлэгт нэгдсэн нь бас л зөвшилцлийн үр дүн байлаа. Харин ардчилсан намын гишүүд МАХН-ын бүлгээс дахин салж тусдаа бүлэг байгуулсан нь Үндсэн хууль зөрчсөнийг Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан, дараа нь их суудлын хуралдаанаас гаргасан шийдвэр харуулсан билээ. Зөвшилцөл бол харилцан санал солилцсоны үр дүнд тодорхой асуудлаар хамтын шийдэлд хүрэхийг хэлнэ. Эдүгээ манайд өрнөж буй үйл явцыг "хуйвалдаан", "будлиан" гэж сөрөг талаас нь үнэлэхээсээ улс үндэстний эрх ашгийн үүднээс намууд эе эвээ эрхэмлэж зөвшилд хүрэх гэсэн ардчилсан шинжтэй оролдлого хэмээн үнэлэх нь зүйтэй болов уу? Одгөө үүнийг нийгмийн харилцааны баялаг ч гэж томъёолох нь буй.

-Аль ч намын залуу зүтгэлтнүүдэд хандаж хэлэхэд, "Эрхшсэн дадал, шунасан санаа ухааныхаа сүвийг битүүрүүлдэг" гэдэг. Эрхшсэн дадал гэдэг нь эрх тушаал, эрх мэдэлдээ омогших, бардах, дээрэнгүй хандах, өөрийгөө бусдаас дээгүүр тавих хандлага, үйлдэл юм. Энэ нь тухайн албан тушаалтны билгийн мэлмийг бүдгэрүүлж, алд дэлэм алдахад хүргэдэг. Ийм байдалд орсон удирдах хүн ихэмсэглэхийн хэнээ тусч, олон түмнээс хөндийрч, яваандаа мухардалд ордгийг түүхэн сургамж өгүүлж байна. Эрхийн зэвсгийг ухварлан нягтлах хүний уян гар л зүй зохисоор эдэлнэ. Эдүүгээ олон түмэн улс төрийн намуудад итгэл алдрах байдал бий болжээ. Монголд МАХН, МоАН гэсэн хоёр намын систем тогтох хандлага бүхий байснаа сүүлийн жилүүдэд эдгээр намуудад ч үл итгэх, тэр ч байтугай харааж зүхэх болов. Манайд "намгүйжих" үйл явц эхэлж байна. "Намгүйжих" үйл явц гэдэг нь илүү хүчтэй нам байхгүй, намуудын хүч саармагжих гэсэн үг.

Манай улс төрийн намууд хичнээн өөр өөр үзэл бодолтой байлаа ч,

үндэсний эрх ашгийн үүднээс монгол төрийнхөө тулганд нэгэн аргал болж ноцох ёстой. Зөвхөн ганц үүнийг Мэдэгтүн! Сахигтун! хэмээн улс төрийн хүрээний дээдэст зурхлэн очмоор байна. Гэвч тэнгэрт оготнын дуу үл хүрэх гэгчийн үлгэр болох буй заа.

Зарим хүн “Эв нэгдлийн тухай” Монгол улсын хууль гаргах нь зүйтэй гэж үздэг. “Эв нэгдэл” хэмээх ойлголт бол хууль зүйн талаасаа гэхээсээ ёс суртахууны тал нь давамгай ухагдахуун юм. Ийм учраас “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Үндэсний эв нэгдлийн тухай” ойлголтыг нарийвчлан тайлбарлаж, нийт хуульд Үндэсний эв нэгдлийг хангах боломжтой бүх зүйл заалтыг тусгаж, амьдралд хэрэгжүүлж байх нь зүйтэй юм.

Эшлэл, зүүлт

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 1994
2. “Улс төрийн намын тухай” Монгол Улсын хууль, Төрийн мэдээлэл. 2004. № 7 /388/
3. Д.Болд-Эрдэнэ. Монголын улс төрийн нам, намын систем. УБ., 2000
4. Цэцэн мэргэний нэвтэрхий толь. /Засамжилж нягталсан хоёр дахь хэвлэл/ УБ., 2002

НЭР ТӨР, АЛДАР ХҮНДИЙН ОЛОН УЛСЫН

ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

/Монгол улсын эрх зүйд тусгагдсан ив./

Ш. Сүхбаатар МУИС-ийн докторант

Хүний хамгийн халдваргүй ариун нандин зүйлийн нэг бол нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд билээ. Үүнийг хуульчлан хамгаалах асуудал дэлхийн улс орнуудад ч харилцан адилгүй арга замыг туулж иржээ. Тэдгээрийг судалж үзэхэд дэлхий дахинд Олон улсын конвенцын хэм хэмжээгээр, дотооддоо үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль, эрх зүйн актуудаар баталгаажуулж ирсэн байна. Эдгээрээс хүний нэр төр чухал гэдгийг 1945 оны 6 дугаар сарын 26-нд гарын үсэг зурсан НҮБ-ын Дүрэм¹-д анх дэлхий дахинд нотолсон бөгөөд улмаар 1948 оны арванхоёрдугаар сарын 10-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”² нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг олон улсын төвшинд хамгаалах эрх зүйн тулгуур суурь нь болж ирсэн юм.

Уг тунхаглалын оршил хэсэгт “Хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүнд угаас заласан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнгийг иш үндэс болгон, хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны жигшлийг төрүүлсэн балмад үйлдэлд хүргэнэ”³... хэмээн онцлоод... Нэгдсэн үндэстний Байгууллагад нэгдсэн улс түмэн хүний үндсэн эрх, бие хүний нэр төр, үнэ хүндийг сахин хамгаалах”-ыг чухалчилж “гишүүн улс орны ард түмэн, тэдгээр улсын эрх мэдэлд байгаа нутаг дэвсгэр дээр оршин суудаг ард олны аль алинаар нь зохих ёсоор зөвшөөрүүлэхийг” Ерөнхий Ассамблейгаас зарлан тунхагласан байна.

Хүний нэр төр, алдар хүндийн олон улсын эрх зүйн тулгуур эх сурвалж нь НҮБ-ийн энэхүү баримт бичиг бөгөөд уг тунхаглалын тавдугаар зүйлд:

¹ Хүний эрх. УБ 2005 он. 21 дэх тал.

² Хүний эрх Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ 1993 он. 3-8 дэх тал

³ “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” /НҮБ. ЮНЕСКО-1948./

“Хэний ч... нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно” гэж заасны хамт наймдугаар зүйлд: “Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” хэмээн баталгаажуулсан юм.

Мөн дээрхи тунхаглалын хоёрдугаар зүйлд: “эрх зүй буюу олон улсын статус ямар ч байлаа гэсэн эрх зүйгээр хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах эрхийн үндэслэл” болно хэмээн заасан байдаг.

Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн дархлаа хэмээн нийтээр хүлээн зөвшөөрсөн “Хэний ч... нэр төр, алдар хүндэд нь дураар халдах ёсгүй. Тэгж оролцох, тийнхүү халдах гэвэл хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтыг уг тунхаглалын арван хоёрдугаар зүйлд тодорхойлсон юм.

“Нэр төрөө хамгаалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын талын эрх дархаа тухайн орны хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны нөөц бололцоонд нийцүүлэн эдлэх эрхтэй”-г тунхаглалын хорин хоёрдугаар зүйлд заасан нь хүн нэр төр, алдар хүндээ эрх зүйгээр бүрэн хамгаалуулах түүхэн сурвалж болсон байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний үндсэн эрх бүр хүн бүрт тодорхой үүрэг буй болгодог. Тухайлбал “хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэн үзэх үүрэгтэй” хэмээн эрх үүргийн нэгдэлийг тод томруун тусгасан нь бий.

Энэ бүгдийг хураангуйлан хүний үндсэн үүргийг Тунхаглалын хорин есдүгээр зүйлд “Хүн бүр нийгмийнхээ. Огно тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, ов тэгш хөгжлийг хангана. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг хууль зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон хязгаарлалтад л захирагдана. Эдгээр эрх, эрх чөлөөг НҮБ-ын зорилго зарчимд

харшуулан эдлэх ёсгүй”⁴ гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө”-г тунхагласан хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 13-д “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэригий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй”⁵ гэж заажээ. Ийнхүү хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хуульчлан бэхжүүлсэн бөгөөд зөвхөн нэр төр төдийгүй хүний бие, эд хөрөнгө, хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, орон байрны халдашгүй эрхийг албан тушаалтан болон бусад хүмүүсийн дур зоргоороо аашлан халдах явдлаас хамгаалах асуудлыг үндсэн хуулийн хэмжээнд баталгаажуулсан байна. Энэ нь хүний нэр төр, алдар хүндийг Монгол улсад эрх зүйгээр хамгаалах үндэсний хэмжээний хамгийн гол эх сурвалж болж буй бөгөөд өмнө дурьдагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаатай нийцэж байгаа юм.

Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд баталж Монгол Улс 1974 онд нэгдэн орсон Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁶ нь нэр төрийн иргэний эрх зүйн олон улсын хамгаалалтын тулгуур эх сурвалжийн нэг болж байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын дүрэмд тунхагласан зарчмуудын дагуу хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг харгалзан улс гүрэн бүр хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахих явдлыг хохүүлэн дэмжих, хувь хүн бүр бусдын өмнө үүрэг хүлээхийн зэрэгцээ эрхийнхээ төлөө тэмцэх учиртайг уг пактын оршил хэсэгт тодотгон заажээ.

НҮБ-аас баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-ын долдугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэнтэй ч хэригий, хүний ёсноос гадуур, эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно”, аравдугаар зүйлийн нэгд “Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр өөртэй нь хүнлэг, бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэн, хүн ёсоор хандах эрх эдэлнэ”, арван долдугаар

⁴ Нэр төр, гүтгэлэг”. УБ 2002 он.7 дaнь тaл

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” УБ 2000., 110-р тал

⁶ Хүний эрх олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ 1993 он.8-27 дaнь тaл.

зүйлийн нэгд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар халдах, мөн түүний нэр төр, алдар хүндэл хууль бусаар халдаж болохгүй”, арван есдүгээр зүйлийн гурвын “а”-д Бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх”, хорин дөрөвдүгээр зүйлийн хоёрт “Хүүхэд төрмөгцөө нэн даруй бүртгүүлж, нэртэй байх ёстой” хэмээн тунхагласныг уг байгууллагад нэгдсэн улс орнууд ч даган мөрдөж үндэсний хууль тогтоомжууддаа хүний үндсэн эрх, бие хүний нэр төрийг сахин хамгаалахаа тусгаж ирсэн юм. Цааш нь уг Пакт⁷-д “Хүн төрөлхтөний бүх гэр бүлийн гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс” хэмээн заан тодорхойлжээ.

Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд...-ийг хуулиар тогтоон хамгаална” хэмээгээд мөн зүйлийн 17 дахь хэсгийн хоёрт “Хүний нэр төр, алдар хүнд...ийг хүндэтгэх”⁸-ийг Монгол улсын иргэний үндсэн үүрэгт хуульчилж өгсөн нь чухал ач холбогдолтой заалт болсон байна.

Нэр төр, алдар хүндийг дэлхийн улс орнуудад хуулиар хамгаалж буй байдал

Хүний нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэргийг олон улсын хэмжээнд хэрхэн шийдвэрлэж ирснийг дэлхийн улс орнуудын эрүү, иргэний хууль тогтоомжуудаас шүүж үзвэл үндсэндээ гурван бүлэгт хамааруулж үзэж болохоор байна. Үүнд:

1. Хүний нэр төр алдар хүндийг эрүүгийн болон иргэний хуулиар хамгаалдаг улсууд. Энэ ангилалд ихэвчлэн хуучин тоталитар дэглэмтэй ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан ОХУ, Украин, Беларусь зэрэг улсууд болон БНХАУ, БНАСАУ, Куба, Вьетнам зэргийг хамааруулж болно. Эдгээр оронд хувь хүн өөрийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжиллоо, гүтгэгдлээ гэж үзвэл эрүүгийн болон иргэний журмын алинаар хандахаа өөрөө шийдвэрлэдэг байна.

⁷ “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харинаж шийтгэхийн эсрэг конвенц” /1984/ ...2002 УБ

⁸ Ж.Амарсанаа, О.Батсайхан. Монгол улсын Үндсэн хууль. УБ 2004 он 466-467 дүгээр тал.

2. Зөвхон хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан гүтгэхээс бусад үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй улсууд. Энэ ангилалд Европийн холбооны улсууд буюу эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудыг нэрлэж болно.

3. Нэр төр алдар хүндийг эрүүгийн хуулиар хамгаалдаггүй иргэний шүүхээр асуудлыг шийдвэрлэдэг улсууд. АНУ, Их Британи, тэдгээрийн колонни байсан буюу Англо-Саксоны эрх зүйн системтэй орнуудыг энэ ангилалд хамааруулж болох юм.

Манай улсын хувьд эхний ангилал буюу эрүүгийн хуулиар хүний нэр төр, алдар хүндийг хамгаалдаг улсуудын тоонд ордог байна. Энэ талаар докторант Ц.Цэлмэг⁹ “Нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг” сэдэвт өгүүлэлдээ дурьдаж байсантай санал нэг байна.

Судалгааны явцад зарим улсын гол хуулиудад хүний нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалах асуудал хэрхэн тусгагдсаныг судалж үзвэл Герман улс үндсэн хуулийнхаа 1.1-д “Хүний нэр төр, эрхэмсэг оршихуй (Menschenwerde)-д халдаж болохгүй. Хүний нэр төрийг хүндэтгэх нь төрийн үүрэг” хэмээн хүний мөн чанар, түүний үнэ цэнийг онцгойлон тодотгож, иргэний хүсэл, мөрөөдөл, нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэхийг төрдөө хуулиар үүрэг болгон баталгаажуулж өгсөн байна.

2002 оны 8-9 дүгээр сард Монголын нээлттэй нийгэм хүрээлэнгийн ивээн тэтгэлгээр “Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөх нь” сэдэвт сургалтыг “Эрх чөлөө” төвөөс зохион байгуулсан юм. Энэхүү сургалтанд АНУ-ын сэтгүүлч; багш Жозеф Антони МакГованд уригдан оролцож манай сэтгүүлчдийн асуултанд хариулт өгөхлөө “АНУ-д гүтгэх, хүний нэр төрийг гутаах, алдар хүндийг нь унагаах гэдэг зүйл анги хэзээ ч эрүүгийн хэрэгт байдаггүй. Харин гүтгэх, нэр төр гутаах гэдэг нь өөрөө иргэний хэрэг байдаг, иргэний журмаар шийддэг. Хэрвээ иргэн хүн өөрийн нэр төрөө гутаасан, гүтгэгдсэн гэж үзвэл шүүхэд иргэний журмаар хандаж нэхэмжилж болно. Мөн мөнгөн нэхэмжлэл гаргадаг. Нэгэнт энэ нь иргэний хэрэг учраас гүтгэсэн буруутай этгээд хэзээ ч шоронд явдаггүй, харин мөнгөн төлбөр, торгууль төлдөг. Энэ нь бас хэвлэлийг олон нийт хянах хэрэгсэл болж өгдөг”¹⁰ хэмээн хариулжээ.

⁹ Ц.Цэлмэг. Нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг. Шингүтүг сэтгүүл. УБ 2005 он. 67 дэх тал.

¹⁰ Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөхүй. УБ 2002 он. 25 дэх тал.

Түүнчлэн хүний нэр төр, алдар хүндтэй холбогдсон маргаанд хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл хамгийн ихээр холбогддог нь судалгаагаар тогтоогддог. Тэгвэл АНУ-ын "Нью-Йорк Таймс" сонин 2000 оны 12 дугаар сард "Бидний нэр алдрын дүрэм" хэмээх бодлогын баримт бичиг гаргасан бөгөөд түүндээ "Хэрэв "Нью-Йорк Таймс" сонин дээр хэн нэгэн хүнийг шүүмжилсэн нийтлэл гарвал шүүмжлүүлд байгаа этгээдэд нэр төрөө хамгаалах болон няцаалт өгөх боломжийг сонины зүгээс санал болгох ёстой"¹¹ хэмээн бичжээ. Уг сонин 1998 онд "Бидний хамгийн их сүр хүч бол "Нью-Йорк Таймс" сонины нэр хүнд. Бид үүнийг гутаах, сүйтгэх ямар ч зүйлийг хийх ёсгүй, харин ч боломжийн хирээр тэрхүү нэр хүндийг дээшлүүлэх ёстой"¹² гэж олон нийтэд зарласан байна. Энэ нь хэвлэл мэдээлэлийн аль ч хэрэгсэлийн анхаарч явууштай зүйл юм.

Оросын холбооны улсад хэвлэл мэдээллийн эрх зүйн байдал 1990 онд өөрчлөгдснөөс эхлэн төрийн болон коммунист намын номнолыг тус оронд халж, хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэх гэж буй мэдээ мэдээллийн агуулгыг хэвлэн нийтлэхийн өмнө хянадаг байсан тогтолцоог хуулиар халсан байна.

Гэсэн хэдий ч 1995 оны нэгдүгээр сарын нэгнээс мөрдөгдөж эхэлсэн шинэ иргэний хуулиар хэвлэл мэдээллийнхнийг хувь хүний нэр төр, алдар хүндэд харшилсан мэдээлэл тараасных нь төлөө иргэний хариуцлага хүдээлгэх хүчтэй тогтолцоог Орос оронд нэвтрүүлж эхэлжээ.

Нэр төр сэргээх асуудалтай холбогдсон гомдол маргаан 1990 оноос хойш "ОХУ-ын хэмжээнд жил ирэх тусам 30 орчим хувиар байнга өсөж байгаа ба эдүгээ жилд 4000 орчим хэвлэл мэдээлэлтэй холбоотой нэр төр, алдар хүндийн тухай маргаан гардаг"¹³ гэсэн нь энэ төрлийн хэрэг маргаан олон улсын шинж чанартайг харуулж байна. Америкийн өмгөөлөгчдийн холбооны мэдэгдэлд дурьдсанаар Орос оронд хувь хүний эрхийг хамгаалсан заалтыг ийнхүү өргөжүүлснээр шүүх дээр иргэний маргааны тоо эрс нэмэгдэж эдгээрээс хэвлэлийн байгууллага маш олон

¹¹ "Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөхүй" УБ 2002.8 дэхь тал

¹² "Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөхүй" УБ 2002. 12 дэхь тал

¹³ ОХУ-ын хуульч Галина Араловын "Нэр төр сэргээх талаархи хууль тогтоомж оронын шүүхийн хуульчил" өгүүлдэг. Нэр төр, гүтгэлцэг. УБ 2002 он. 40 дэх тал.

иргэний хэрэгт хариуцагчаар татагдах болсон байна. Манай улсын хувьд ч ийм төрлийн хэрэг түүн дундаа иргэний хэргийн тоо жил бүр өсөн нэмэгдсээр байгаа билээ.

ОХУ-ын үндсэн хуулийн дагуу тодруулбал 21 болон 23 дугаар зүйлд "... юу ч алдар хүндийг унагаах үндэс болохгүй. Хүн бүр нэр төр, сайн нэрээ хамгаалах эрхтэй байна." гэж заасны дагуу хамгаалах эрх олгогддог. Энэхүү үндсэн хуулиар баталгаажсан эрх нь бусад дийлэнх салбар хуулиудад, тодруулбал ОХУ-ын Иргэний хуулийн 152-р зүйлд зөвхөн хувь хүний нэр төр болон алдар хүнд бус мөн түүний ажил хэргийн нэр хүндийг хамгаалах иргэний эрх зүйн арга хэрэгсэлийг тодорхойлсон байдаг¹⁴.

ОХУ-ын Иргэний хууль дахь нэр төр, алдар хүнд ба ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжлох /диффомаци/, ажил хэргийн нэр хүнд болон эрхэмсэг чанар, нэр төрийг гутаах талаархи Америкийн диффомацийн эрх зүйн онцлогийг Кристофер Осаке "Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги"¹⁵ номондоо тусгаснаас үзэхэд тухайн орнуудад нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг эрх зүйгээр хамгаалах асуудлыг үндсэн хуулийнхаа голлох заалтын хэмжээнд авч үзсээр ирсэн байна.

Гүтгэлэг ба олон улсын хандлага

Хүний нэр төр, алдар хүндийг гүтгэн доромжилж асуудлыг Европын Хүний Эрхийн Шүүх тодорхой авч үзсэн бөгөөд шийдвэрүүд нь олон улсын хэмжээнд бүрэн нийцдэг ажээ. Европын хууль эрхийн цуврал баримт бичигт "Шүүх хувь хүмүүс нь улс төрийн удирдагч, нийгмийн зүтгэлтэн, албан тушаалтнууд, Засгийн газар болон төрийн байгууллагуудыг шүүмжлэх эрхтэй" бөгөөд "Ор үндэсгүй худал, хэрээс хэтэрсэн доромжлол бол шийтгэл хүлээж болох юм" гэжээ. Европын Хүний эрхийн шүүх "түүнчлэн Засгийн газар, албан байгууллага, албан тушаалтныг шүүмжилсний төлөө шоронд суулгах нь Европын зөвлөлийн гишүүдийн хувьд үл нийцэх, хүлээн зөвшөөрч болохгүй зүйл" гэдгийг тодотгосон байдаг. Энэ баримт бичгүүдэд Монгол улс нэгдээгүй ч олон улсын жишиг юм. Сүүлийн 10 гаруй жилд

¹⁴ О.А.Пешкова. Компетация морального вреда. Москва 2006 г. Стр 112

¹⁵Кристофер Осаке "Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги.Ж.Номдорж, Л.Номтой, Д.Унарах нарын орчуулга: УБ 2005. 225-237 дахь тал.

Европын орнуудаас гүтгэлгийн хэргээр нэг ч хүн хорих болон баривчлах ялаар шийтгүүлээгүй байхад манай улс дөнгөж 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн шинэ Эрүүгийн хуулиараа хоёр ч сэтгүүлч эмэгтэйг багагүй хугацаагаар баривчлах ялаар шийтгэж, цөөнгүй тооны хүнийг эрүүгийн хэрэгт татан мөрдөн шалгаж иржээ.

Ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө баталгаажсан байх ёстой ч хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хамгаалах үүднээс шаардлагатай хязгаарлалтуудыг нарийвчлан тусгаж өгөх нь 2000 оны 2 дугаар сарын 29-нөөс 3 дугаар сарын 1-ний өдрүүдэд Лондон хотноо зохиогдсон Түтгэлгийн эсрэг хууль"-ийн талаархи семинарын гол зарчим байсан байна. Гүтгэлгийн эсрэг хуулийн гол зорилго нь нэр хүндээ бууруулуулж хохирсон иргэн нэхэмжлэл гаргах эрхтэй ч албан хаагчийн буруутай үйл ажиллагааг зүй ёсоор шүүмжилсэн, хээл хахуулийг ил гаргасан тохиолдолд гүтгэлгийн эсрэг хуулийг хэрэглэхийг хоригложээ. Түүнчлэн зарчмын хувьд эрүүгийн хуулиас гүтгэлгийн эсрэг заалтыг хасч Иргэний хуулиар зохицуулах хэрэгтэйг гүтгэлгийн эсрэг заалтууд эрүүгийн хуулиндаа хэрэглэж байгаа орнуудад зориуд анхааруулсан байх юм.

Иймд манай Эрүүгийн хуульд цаашид нэг талын нэр төр гүтгэгдсэн гэх гомдол шаардлага нь эргэлзээтэй, нотлох баримт бүрэн бус бол хэнийг ч гүтгэлэг, доромжлолын эсрэг хуулиар ял шийтгэж болохгүйг тусгаж өгөх шаардлагатай байна. Няцааж байгаа зүйл нь худал ташаа болох нь нотлогдоогүй, санаатай хуурамчаар үйлдсэн буюу худал ташаа болохыг мэдсээр атал бодлогогүй мэдээлсэн, эсвэл нөгөө талд зориуд хор уршиг учруулахаар тусгай зорилготой гүтгэж доромжилсон нь нотлогдоогүй бол гэмт хэрэгт тооцоггүй байх нь дэлхий нийтийн жишиг болсныг анхаарууштай юм. Гүтгэгдсэн гэх тал өндөр байр суурьтай, өөрөөр хэлбэл, төр засгийн албан тушаалтан байсан ч тэдний өмнөөс гүтгэлгийн эсрэг хэрэг үүсгүүлэхээр хэн нэгэн санаачлага гаргасан бол түүнийг хүлээж авахгүй байх нь зүйтэй юм. Хорих, сэтгүүд зүйн эрхийг нь хасах, хэт их торгууль тавих буюу Эрүүгийн хатуу ял шийтгэл хариуцлагыг гүтгэлгийн гэмт хэргийн субъектэд оногдуулахгүй байх өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага амьдралаас урган гарсаар байна.

**Нэр төр, алдар хүнд ба ажил хэргийн нэр хүндийг хохироосноос
учирсан эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлж
буй бусад улсын практик**

ОХУ-ын хууль тогтоомжоор эдийн бус хохирлыг нэгд: бие махбодийн хохирол, **хоёрт**: ёс суртахууны хохирол гэж хуваадаг байна. Ёс суртахууны хохиролд нэр төрийн болон сэтгэл зүйн хохирлыг хамааруулж ойлгодог практик тогтжээ. ОХУ-ын одоогийн шүүхийн практикт хууль тогтоомжоор зохицуулагдсан, эсхүл ОХУ-ын дээд шүүхээс улирдамж болгосон сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох аргачлал байхгүй хэдий ч зарим аргачлалыг шүүхийн практикт хэрэглэж эхлээд байна. Тухайлбал, А.Эрделевскийн зохиосон хүснэгтийг шүүхийн практикт хэрэглэж байна.

Энэхүү хүснэгтээр тухайн гэмт хэргийн төрлөөс хамааруулж эдийн бус хохирлын хэмжээг тарифжуулан тогтоосон байх бөгөөд энэ нь төдийлэн оновчтой биш юм. Учир нь тухайн гэмт хэргийн улмаас хохирогч бүрт харилцан адилгүй хэмжээний эдийн бус хохирол учирдаг байна. Тухайлбал, хань ижил, үр хүүхэд, эцэг эхдээ ачлалтай нэгэн буслад гүтгүүлж доромжлуулан нэр төрөө гутаалгах, харин гэр бүлийнхэндээ байнга хүчирхийлэл, дарамт учруулагч этгээд буслад гүтгүүлж, доромжлуулсан тохиолдлыг авч үзэхэд ар гэрийнхэнд нь учрах сэтгэл зүйн хохирлын хэмжээ харилцан адилгүй бөгөөд ялгамжтай байна. Тэгэхээр эдийн бус хохирлын хэмжээг ийнхүү тарифжуулан тогтоох нь учир дутагдалтай бөгөөд хохирогчийн хөндөгдсөн эрх бүрэн дүүрэн сэргээгдэнэ гэх үндэслэлгүй юм.

Франци, Герман, Англи, Америк зэрэг улсуудын зохицуулалтаас үзэхэд аливаа компаний ажил хэргийн нэр хүндэд халдсан тохиолдолд учирсан гэм хорыг эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус гэж ангилдаггүй, харин тэрхүү бодит байдалд нийцэхгүй мэдээлэл түгээсэн этгээдэд уг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр, эсхүл мэдээллийг түгээсэн тэр замаар дамжуулан няцаах үүргийг хуульчлан оноодог байна.

Дэлхийн зарим оронд нэр төртэй холбогдсон хэрэг маргааныг шийдвэрлэж ирсэн практик

АНУ-ын Алабама мужийн Монтгомери хотоос сонгогдсон комиссын 3 гишүүний нэг Л.Б Суливаныгээрэг “Нью-Йорк таймс” сонины үүсгэсэн хэрэг нь хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой томоохон заргад тооцогддог. АНУ-ын дээд шүүх энэ хэргийг 1964 о.ны 3-р сарын 9-ны өдөр хэлэлцэхдээ “Нью-Йорк таймс” сонины талд шийдвэрлэжээ. Суливаныг хотын цагдаагийн байгууллагыг хариуцдаг байхад нь хар арьстануудын жагсаал болж, тэд парламентийн ордоны шатан дээр дуу дуулигаажээ. Уг жагсаалыг Суливан тэргүүтэй цагдаа нар хянахыг оролдсон байна. Үүнийг эсэргүүцэж тэндэхийн дорвон хар арьст санваартан “Нью-Йорк таймс”-д бүтэн нүүр зарлал өгч нийтлүүлсэн байна. Уг зарлалд: Алабама хотын цагдаа нь коллежийн байр луу утасдаж, оюутнууд ойр хавийнхаа цайны газрыг сүйтгэж хууль зөрчсөн тухай буруу мэдээлэл сургуульд нь өгснөөс тэд сургуулиасаа хөөгдөхөд нөлөөлсөн гэж бичжээ. Суливан өөрийг нь гүтгэсэн мэтээр шүүхэд зарга мэдүүлж, энэ гүтгэлэгээс болж түүний нэр төр хохирсон гэж гомдол гаргасан аж. Муж улсын анхан шатны шүүх түүний нэр төрийг хохирсон гэж үзэж 500 мянган доллар төлүүлэхээр тогтоосон бөгөөд Алабама муж улсын давах шатны шүүх уг төлбөрийг төлүүлэхийг бас дэмжсэн байна. Харин АНУ-ын дээд шүүх нэр төр хохирсоны төлбөрийг төлүүлэхгүйгээр шийджээ.

Шүүх энэ шийдвэрийг гаргахдаа “Нью-Йорк таймс” сонинд төлбөртэйгээр нийтлэгдсэн зарим мэдээлэл худал байсныг дурьдсан хэдий ч Алабамагийн хуулиар төрийн албан хаагчийн хувьд гүтгэлэгийн хэрэг дээр олон нийтийн өмнө залруулга гаргахыг өөрөө эхэлж бичгээр шаардаад түүнийг биелүүлэхээс татгалзахаас бусад тохиолдолд залхаан цээрлүүлэх шинжтэй хохирлыг төрийн албан хаагчдаар төлүүлдэггүй хуулийн заалтыг удирдлага болгожээ.

Шүүх “Олон нийтэд хамааралтай асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлтээр баталгаажиж, энэ нь манай үйл ажиллагаанд эртнээс нэвтэрсэн билээ. Чөлөөтэй мэтгэлзэж

байх үед алдаатай мэдээлэл нийтлэгдэх нь зайлшгүй бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь оршин байх ёстой юм бол түүнд хамгаалалт байх ёстой” гэж хэлжээ.

Үндсэн хуулиар баталгайжсан эрх, эрх чөлөө нь Холбооны улсын хуулиудад төрийн албан хаагчийн хэрэг дээр тухайн албан хаагчийн талаар зориуд, атгаг санаагаар гүтгэлэг тараасан гэдгийг тухайн албан хаагч нотолсон тохиолдолд хохирол төлүүлж болдог харин бусад тохиолдолд хохирол төлүүлэхийг хориглох журам баримталдаг байна.

Зориуд атгаг санаатай мэдээлэлд тухайн мэдээлэл худал байсныг мэдсэн хэрнээ нийтлэх, эсвэл тухайн мэдээллийг худал эсэхийг огт сонирхохгүйгээр авч нийтэлсэн мэдээлэл тооцогддог. “үндсэн хууль маань иргэд болон чөлөөт хэвлэлд төрийн албаны үйл ажиллагааны талаар шүүмжлэх хязгаарлагдаагүй эрх чөлөөг олгосон гэдэгт би хатуу итгэдэг”¹⁶ гэж шүүгч Голдберт хэлжээ.

Оөр нэгэн баримт дурдвал Панам улсад сүүлийн хоёр жилийн дотор нэр төр алдар хүндийн эсрэг хэд хэдэн хэрэг гарсан байна. Телевизийн болон сонин сэтгүүлчид Засгийн газрын албаны хүмүүсийн нэр төрийг гутаасан, гүтгэсэн хэргээр хоригдож зарим нь хорин жил шоронд суух ял хүлээсэн байна. Эдгээр сэтгүүлчдийн өмгөөлөгчид нь Америк тивийн хүний эрхийн шүүхэд хандсан бөгөөд тус шүүх Панам улсын ил тод байдлыг үзэн ядсан хууль, шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шийдвэр гаргасан байна.

¹⁶ Мелвин Менчер “Сэтгүүд зүйн бичлэгийн үндэс” /5 дахь хэргэм/, УБ 2001 он.

АШИГЛАСАН НОМ

1. "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" /НҮБ, ЮНЕСКО-1948/
2. "Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм", 2002 УБ
3. Хүний болон иргэний эрх, үүрэгтэй холбогдолтой Монгол Улсын Хууль /түүвэр МХЭТ., УБ 2001
4. А.Азаров нар " Хүний эрхийг хамгаалах тогтолцоо". УБ 2002
5. "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө". УБ 2001
6. Мелвин Менчер "Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс" /5 дахь хэвлэл/, 2001 АНУ
7. Ц.Цэлмэг. Нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг. Шихитутуг сэтгүүл. УБ 2005 он. 67 дахь тал
8. Пешкова.О.А.Компенсация морального вреда.Москва 2006 г.

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ ХИЙХ, ОЛБОРЛОХ ЖУРАМ ЗӨРЧИХ
ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОН
КРИМИНОЛОГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Шихихутуг ХЗДС-ийн багш, докторант Ц. Цэлмэг.

Экологийн тэнцвэрт байдалд эхлээд гажилт /аномия/ үүсэж, тэр нь даамжирсаар экологийн хямрал, доройтолд хүргэдэг, эцсийн бүлэгт экологийн сүйрэлд хүргэх дэс дарааллаар процесс явагддаг бөгөөд Монгол Улсын хувьд 1960-д оноос эхлэн байгалийн тэнцвэрт байдалд гажилт үүсэж, улмаар 1990-д оны эхээр экологийн хямрал эхэлсэн гэж судлаачид дүгнэдэг.

Энэ сэдвийг сонгон авсаны учир холбогдол нь өнөөдөр манай улс дээр дооргүй газрын доорхи баялаг, ашигт малтмалаа хэрхэн ашиглах вэ, энэ баялагаа түшиглэн эдийн засгаа хэрхэн өөд нь татах вэ, нөхөн сэргээлтийг хэрхэн хийх, хууль зөрчигч нарт ямар хариуцлага тооцох талаар ярилцаж, УИХ саяхан Ашигт малтмалын тухай шинэ хуулийг батлан гаргасантай холбоотойгоор өөрийн саналыг илэрхийлэхэд оршиж байгаа юм. Мэдээж энэ нийтлэлийн гол зорилго нь ашигт малтмалын хууль тогтоомж зөрчигч нарт оногдуулж байгаа хариуцлагын тогтолцоо, нөхөн сэргээлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэгдэж байгаа.

Анх 1961 оны Эрүүгийн хуулиар байгалийн зарим төрөл зүйлүүдийг хамгаалалтанд авсан боловч ашигт малтмалын талаар заагдаагүй байсан, харин 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 181-р зүйлд ... Недрийг ашиглах, алт үнэт металл, үнэт чулууг улсад тушаах журам зөрчсөн бол гэж хуульчилж байсан бөгөөд энэ нь байгаль орчныг хамгаалсан гэхээсээ илүү аж ахуйн үйл ажиллагааны эсрэг чиглэсэн объектой байсан.

Дараа нь 2002 оны Эрүүгийн хуулийн 214-р зүйлд, Ашигт малтмалын хайгуул хийх, олборлох журам зөрчих гэмт хэргийг хуульчилсан ба гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар доор өгүүлнэ.

Өнөөдрийн байдлаар ашигт малтмалын лиценз эзэмшигчдийн тоо 600

гаруйд хүрээд байгаа бөгөөд 2005 онд 75 аж ахуйн нэгж ашигт малтмал олборлож байгаагаас 67 нь алт олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж¹.

Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас явуулсан шалгалтаар тусгай зөвшөөрөл бүхий 68 компаний шороон ордыг хамруулахад гурваас бусад нь нөхөн сэргээлт хийлгүй байгаль орчинд ноштой хохирол учруулсан, 12 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байсан нь илэрчээ. Энд дурьдахад нөхөн сэргээлтийг техникийн ба биологийн гэж хуваах ба дээрх нөхөн сэргээлт нь зөвхөн техникийн нөхөн сэргээлт гэдгийг дурьдах нь зүйтэй.

Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын уул уурхайн албанаас гаргасан мэдээнээс үзвэл уурхайнууд байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн ажилд жилд дунджаар 130 сая төгрөг зарцуулж, 500 га талбайд нөхөн сэргээх ажил хийж байгаа хэдий ч жижиг уурхайнууд нөхөн сэргээлтийн ажлыг орхигдуулсан бөгөөд байдлыг залруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Түүнчлэн үйлдвэр, худалдааны яамны гаргасан мэдээгээр хувиараа алт олборлогчид 90 мянгад хүрсэн бөгөөд тэд гар аргаар газар ухааж, шороог угаан алтыг тунгааж зардаг, түүнийг нь худалдан авдаг бүлэг хүмүүсийн сүлжээ нэгэнт үүсчээ. Мэдээж хууль бусаар алт олборлогчдын хувьд газрын нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах асуудал хамаагүй гэдэг нь тодорхой.

Албан ёсны тоон мэдээгээр 90000 мянган хүн тусгай зөвшөөрөлгүй ашигт малтмалыг олборлож Монгол улсын хуулийг зөрчиж байхад тэдгээр хүмүүсийг байгаль хамгаалагч болон цагдаагийн ажилтанууд хааяа нэг хөөн тараахаас өөр арга хэмжээ авахгүй байна.

Энэ гэмт хэргийн **объект** нь ашигт малтмалын хайгуул хийх, олборлох журам байна. Халдлагын зүйл болох ашигт малтмал гэж геологийн хувьсал өөрчлөлтийн үр дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсэн бий болсон аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдэс бодисын хуримтлалыг хэлнэ.

Ашигт малтмалд алт, үнэт металл, үнэт чулууг хамааруулан ойлгох ба

¹ Газрийн сонин, 2005 оны 11 сарын 3 ны өдрийн дугаар

тэдгээр нь унаган төрхөөрөө байсныг ашигласан нь энд хамаарах бөгөөд үүгээрээ өмч ашиглах гэмт хэргээс ялгагдана. Үнэт чулуунд: доржпалам, маргал, индраанил, бадмаараг, сувд орох ба үнэт металл гэдэгт : платина болон түүний бүлгийн металл / родий, рутений, пладий, осмий, иридий/ алт, мөнгө хамаарна². Ашигт малтмалын хайгуул, олборлолтын лиценз, мөн ашиглалтын лиценз гэж 2 төрөлд хуваагдах ба манай улсад гарч байгаа нийтлэг дутагдал нь хайгуулын лицензээр ашигт малтмалыг ашиглаж байгаа боловч хариуцлагын тогтолцоо хэт сул байгаагаас хууль зөрчигчид хэтэрхий даврах байдалд хүрчээ.

Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл гэж хуулийн дагуу геологи, уул уурхайн кадастрын албанаас олгогдсон ашигт малтмал ашиглах эрхийг хэлнэ. Энэ төрлийн үйл ажиллагааг заавал тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхлэх ёстой бөгөөд зөвшөөрөлгүй этгээд үйл ажиллагаа явуулбал хор уршиг учирсан эсэхээс үл хамаарч эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Объектив тал нь тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон үйлдээр илэрнэ.

Ашигт малтмалын хайгуул хийсэн гэж ашигт малтмалын хуримтлал байгаа эсэхийг тодорхойлох, байршил, тоо хэмжээг нь тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд үйл ажиллагаа явуулах, түүнчлэн ашигт малтмалыг ашиглах боломжийг судлаж, техник эдийн засгийн үнэлгээ хийх, малталт хийх, нэвтрэх, сорьц авах, туршилт, тандалт хийхийг хамааруулна.

Ашигт малтмалыг олборлох гэж тусгай зөвшөөрөлгүй этгээд газрын хэвлийд нэвтрэн малталт хийж ашигт малтмалын төрөл зүйлийг өөрийн эзэмшилд авахыг хэлнэ.

Байгаль орчны талаар явуулж байгаа бодлого, арга хэмжээ, ашигт малтмал олборлох явцад эвдрэл, элэгдэлд орсон газрын гадаргуу, хөрснийг нөхөн сэргээх, гарч болзошгүй хорт нөлөөлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ашиглагчаар гүйцэтгүүлж түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.

Орд газрын нөөцийг өөрчлөн ашиглахыг зогсоох, үндсэн ба дагалдах

² Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эхлэлтэй. УБ., 2004 он, 260-р тал.

баялгийг иж бүрэн хянгдалгүй ашиглах, алтны уурхайнууд болон аж ахуйн нэгжүүдэд ашигт малтмалын тухай хуулийг болон байгаль орчныг хамгаалах тухай хууль, холбогдох эрх зүйн актуудыг мөрдүүлэхэд чиглэгдэж байна.

Энэ гэмт хэргийн субъектив тал нь санаатай, шунахай сэдэлтээр илэрдэг бол **субъект** нь ашигт малтмалын хайгуул хийх, олборлох зөвшөөрөлгүй этгээд байна.

Ихэнхи тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, захирал энэ төрлийн гэмт хэргийн субъект байдаг. Хэрэв тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалыг онц их хэмжээгээр олборлосон бол ялыг хүнарүүлэх нөхцөл байдал болно.

Дээр дурьдсанаар ашигт малтмалын тухай хууль болон Эрүүгийн хуулийн заалтыг зөрчин хууль бусаар зөвхөн хувиараа алт олборлодог хүмүүсийн тоо 90000 хүрсэн, жилд дунджаар 32 орчим аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөлгүй ашигт малтмалыг ашигласаар байхад эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол гараагүй, захиргааны хариуцлага хүлээлгэх төдийгөөр өнгөрчээ.

Судлаачийн зүгээс дараах дүгнэлтэнд хүрээд байна. Үүнд, **нэгдүгээрт** :

Эрүүгийн хуулийн 214-р зүйл буюу тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон бол гэсэн объектив талын заалт нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, хор уршиг шаардаагүй учир дээрх гар аргаар алт олборлож буй 90000 хүмүүс гэмт хэрэг үйлдсэн мэт байдалтай харагдаж байгаа бөгөөд одоогийн хуулиар дээрх хүмүүсийг нэг бол бүгдийг эрүүгийн хариуцлагад татах ёстой, үгүй гэвэл эрүүгийн хариуцлагагүй болгохоор хуульд өөрчлөлт оруулах ёстой.

Нэгэнт Монголын ард түмний нэг хэсэг болсон 90000 хүнийг эрүүгийн хариуцлагад татах нь харгис явдал болох учир хуулийн заалтыг өөрчлөх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Иймд 214-р зүйлийн 1 дэх хэсгийн бүрэлдэхүүнийг материалаг бүрэлдэхүүнтэй болгох, өөрөөр хэлбэл, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хор уршиг учирсан бол гэж, түүнчлэн зөвшөөрөлтэй боловч хайгуул хийх, олборлох журмыг ноштой зорчсон, нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас байгаль орчинд үлэмж хэмжээний хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр өөрчлөн найруулах

шаарлалтай. Оноор Эрүүний хэлтсээр гэмт хэрэг үйлдэж буй гар аргаар агт огдорж буй хүмүүсийн асуудлыг шингивэрэх арга зам нь "Гар аргаар агт огдорж буй" хуулийн төслийг боловсруулж УИХ батлах, олоогийн эрүүний хуульч нэмэлт өөрчлөлт оруулах замаар шингивэрэх боломжтой юм.

Хорьдугаарт. Эрүүний харилцааг хүлээх **сүбъект** нь зөвхөн хувь хүн байгаа олоогийн үзэл баримтлалыг өөрчлөж аж ахуйн нэгж байгуулалтыг гэмт хэргийн бүрэлдэхүүний **сүбъект** байхаар ерөнхий ашиггүйсгаж байгуулалтыг гэмт хэргийн бүрэлдэхүүний харилцааны төрөл, хэмжээг хүлээнхөж өгөх шаардлагатай. Олон улсын жишгээр бол/ихэнхдээ Англыг хуульчлалт өгөх шаардлагатай. Тусгаж байгуулалтад хүлээгээр эрүүний харилцааны төрөл, хэмжээг төргийн эрүүний харилцааг хүлээгээр ба энэ нь торгууль, тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулахыг нь хориглох /1-5 жил/, байгуулалтад эл хөрөнгийг хурааж, татан буулгах зэрэг болно.

Байгаль орчинд ноцтой хохирол үрхүүлж байгаа **сүбъект** нь аж ахуйн нэгж байгуулалтууд бөгөөд олоогийн Эрүүний хуулиар харилцаа тооцох гэхээр тухайн байгуулалтад үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх захиралыг харилцаанд татах болно, тэр нь өмчийн эзэн нийгэмчид харилцаанд татагдаж байгаа гэхэд байгуулалтад хуульч байвал, үйлдвэрлэх захирлыг харилцаанд татагдах гэхэд байгуулалтад хуульч зорьсон үйл ажиллагаа үргэлжлэж байгааг орчинд ноцтой хохирол үрхүүлснээр өөр үйлдвэрлэх захиралыг томилох асуудлыг шийддэг.

Нэг жишээ дурьдахад, Оворхангай аймгийн Олигийн агтын үүрхэй /Эрэг компанй/ нутгийн байгаль орчинд ноцтой хор үршиг үрхүүлснээр тухайн хуулийн 204-р зүйлд зааснаар үйлдвэрлэх захирал б-г-г эрүүний хэрэг үйлдвэрлэх захирал ба хэрэг прокуратураар хэрэг үйлдвэрлэж байгаа б-г-г ахорон өгөд үйлдвэрлэх захиралыг томилох ажиглуулалтад тухай б-г-г ахорон өгөд хэргийг хэрэгсэхгүй болгон шингивэрээс, харилцааг хохиралыг нэх аргаар гаралдуулахыг, үл ашиггүйсгээр үр зоргоороо үйл ажиллагаагаа явуулснээр г байна.

Гуравдугаарт. Тогдох ялыг хөдөлмөрийн хөдөлмөр хамгаалах үйлдвэрлэх нь амьдралтай нийцэхгүй, хүнлэг цинхэр цинхэр байдалд

хүргэж байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газраас тогтоодог, байнга өсөн нэмэгдэж байгаа нь хохираын хэмжээ, гэмт хэрэгт тооцох шалгуурыг өсгөсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд улам хүндрэлтэй болж байна. Түүнчлэн ялын бодлого хууль тогтоогчийн хүсэл зоригоос үл хамаарч улам бүр хүндэрч байгаа зэрэг нь энэ ялын агуулгыг өөрчлөх шаардлагатай болсоныг харуулж байна.

Торгуулийн ялыг Монгол улсад үндсэн ялын чанартай хэрэглэж байгаа нь дэлхий нийтийн жишигт нийцэхгүй байгаа тул үндсэн болон нэмэгдэл ялын / холимог / чанартай хэрэглэдэг болох нь зүйтэй.

Миний бие энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гаргагчдын дунд судалгаа хийж үзэхэд хүйсний хувьд 95 хувь нь эрэгтэй, 5 хувь нь эмэгтэй, насны хувьд 18-35 хүртэлх насны залуучууд 60 хувь, 36-50 хүртэлх идэр насны хүмүүс 35 хувь, 50-с дээш насны хүмүүс 5 хувь, нийгмийн байдлын хувьд 70 хувь нь амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур амьдралтай хүмүүс байлаа.

Түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гаргагчдын шалтгаан, нөхцөлийг судлаж үзэхэд юуны өмнө эдийн засгийн шалтгаан буюу ажилгүйдэл, ядуурал голлох байр суурьтай, ялангуяа хувиараа ашигт малтмал олборлож байгаа хүмүүсийн 98 хувь нь амьжиргаагаа залгуулах, мөнгө олох зорилгоор алт ухаж байна.

Хоёрдугаар шалтгаан нь хүн амын экологийн ухамсар, соёл, мэдлэгийн түвшин дорой, байгаль хамгаалах уламжлал, зан заншил алдагдсан явдал болж байна.

Хууль ёсыг үл тоомсорлох үзэл газар авсан, хуулиудын уялдаа холбоо муу, хэрэгжилт тааруу, хариуцлагын тогтолцоо сул байгаа нь хууль зөрчигчдийг өөгшүүлэх байдалд хүргэсэн нь мөн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил даамжрах үндсэн шалтгааны нэг болж байна. Ялангуяа алтны компаниуд байгаль орчныг ихээр сүйтгэж, нөхөн сэргээлт хийдэггүй, зөвхөн цаасан дээр нөхөн сэргээлт хийсэн, төчноон төгрөг зарцуулсан мэтээр тайлагнадаг байхад хяналтын байгууллагууд дуугүй өнгөрдөг нь тэднийг хууль зөрчигсөдтой ямар эрх ашгаар холбогдоод байгаад эргэлзэх сэтгэл эрхгүй төрүүлж байгааг дурьдах шаардлагатай.

ТЭГШ ЭРХИЙН ЗАРЧИМД ЭРХ ЧӨЛӨӨ, ЭРХ ЗҮЙТ ЁСНЫ ҮҮДНЭЭС ХАНДАХ НЬ

(Хууль зүйн шинжлэх ухааны ерөнхий онолын асуудал)

*М.Батсуурь (докторант)
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш*

Удиртгал

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулинд “эрх чөлөө”-ний зарчимтай зэрэгцэн орж ирсэн зүйл бол “тэгш эрх”-ийн зарчим юм. өнгөрсөн нийгэмд магадгүй хамгийн тод сонсогдож, хэрэгжүүлэхийг эрмэлзэж байсан энэ уриа нь яагаад орчин үеийн “либерал” гэх үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын нэг болон тунхаглагдсанд гайхахгүй байхын аргагүй. “Тэгш эрх байгаа газар эрх чөлөө хүнийгсэгддэг” гэсэн үгсийг урьд нь олонтаа анзаарч байсан учир энэ нь тун ч хачирхалтай санагдаж билээ. Тиймээс тэгш эрх, эрх чөлөө хоёр хоорондоо зохицдог уу, эсхүл бие биеэ үгүйсгэдэг үү? Тэгш эрхийг бид ямар агуулгаар ойлгох ёстой вэ? гэсэн асуултуудад хариу эрэх нь өгүүллийн маань үндсэн зорилго болох нь.

Эдгээр асуултад хариулахын өмнө “орчин үеийн сэтгэлгээ, орчин үеийн асуудлууд гэдэг нь сонгодог сэтгэгчдийн бидний зүг чулуудсан шинэ шинэ гэрэл гэгээ, оюун бодлыг дахин тунгаах, сохон тавих явдал билээ”¹ гэсэн М.Фрееманы үгийг үндэслэн “тэгш эрх”-ийн үзэл санааны хөгжлөөс асуудлаа хондох нь зүйтэй хэмээн үздээ.

Тэгш эрхийн үзэл санаа

Тэгш эрхийн тухай үзэл санаа нь зөвхөн эрх зүйн бус, улс төр, ёс суртахууны онолын байнга анхаарлын төвд байдаг, энгийн юм шиг атлаа хамгийн ярвигтай ойлголтуудын нэг юм. Тэрээр өргөн утгаараа шударга ёсны ойлголттой дүйдэг бөгөөд энэ нь нэлээд эртнээс улбаатай болохыг

¹ Freeman M.D.A. Lloyd's Introduction to Jurisprudence. London, 2001, p. 15

Бид эртний сэтгэлийн бичиж үлдээсэн зүйлсээс харж болно. Тухайнбад, Африкотойг "шударга ёс буюу тэтг эрх талат нь ашиг тэтг хүмүүст ашиг тэтг ханах, ашиг тэтг бус хүмүүст ашиг бусаар ханахыг хэнх" хэмээн тэмцэлгээс бөгөөд түүнээр өнөө үйлдсээр энэ шударга ёсыг ойлгохыг бид залгаж хөгжүүлсээр и байгаа билээ. Түүний тодорхойлолтоос бид тэтг эрхийн хоёр үндсэн санааг гарган авчар болгож нэгдүгээрт, тэтг эрхийн эсвэл "хэмээн томъёолсноос мөн харж болно. Энэ зарчим нь хувь хүнийн бодит байдал руу төдийгөө халгалтгүй уявир хожим либерал үзэл санааг баримтлалтын гол үрийг болгоно юм. АНУ-ын үндсэн хуулийн эцэст хэмээн нэрлэгддэг Т.Жефферсон "хүн бүр тэтг эрхтэй байхав бүтээгдсэн" хэмээн тэмцэлж байсан. Тэгвэл энэ санаатай орьны үеийн үндсэн хуулийн охь лээж нь болсон АНУ-ын Тусгаар тогтнолын тунхалт "бурхан хүн бүрд амьдраг, эрх чөлөө, аз жаргал руу тэмүүлэх халгалтгүй дархан эрхийг завсран" гэсэн байдалар бүлэгтсэн.

Тэгэхээр бид агаас юу ойлгож болох вэ? Юуны түрүүнд хүн бүр бүрхны өмнө ашиг тэтг эрхтэй гэсэн тунхагийн санаа нь төвөр хуулийн хийгээд ёс зурга хуулийн агуулгатай бөгөөд хүн бүрийн ашиг бишгй хуулийн тусламжтайгаар ашиг хамгаалах тухай асуудал мөн. Хүмүүсийн зарим нь төрд ажиглан, эх орныхоо төгөө зүтгэхийг нэр төрийн хэрэг гэж бодож байхал зарим нь зүгээр и бусад саад болохгүй, өөрийнхоо зам мөрөөр амьдрахыг эрмэлзж байлт. Тиймээс өөр өөр хувь заяа, хүсэл зорилгооо хөтөлгөх хүмүүст хэн нэгний хүслийг тухааж болохгүй. Төрийн үүрэг бол хувь хүний энэ эрхийг тухайн нийтлэгийн олонхи хийгээд гэдгид заналхийлгээс хамгаалахад оршино гэсэн санаа гарч буй юм. Үүнийг бид тэтг бодоомж хэмээн тэмцэлгээд бөгөөд Францын хувьсгалын үед гарсан "Une Carte ouverte aux les talents" буюу авьяас байвал дам нээлтэй

Top-от АНУ, Франц, Энхот, Герман, олонд Африк болон Монгол үсээн үүсээн хүүд дам тэтг эрхийн тухай хийгээд харуулсан судалгаа. Үүнийг нь дээд сургууль төгсөхтэй эргэцэн бүтээх

МАХТЭЛ ҮБ, 2013, 74 дэх тал.

Л.Бот, Индустриал, ҮБ, 2015, 89 дэх тал.

М.Фришман, Р.Фришман, Хувь заяага сонгох нь, ҮБ, 2011, 106 дэх тал.

гэсэн хэллэгтэй зүйрлэн илэрхийлж болно. Хүн бүр бурхнаас заяасан авьяас чадвартай бөгөөд түүнийгээ нээн хөгжүүлж, түүгээрээ амьдрах боломж нь бүгдэд адил байх ёстой бөгөөд хүний энэ чадавхиас өөр буюу үндэс угсаа, арьсны өнгө, хүйс зэрэг байгалийн болон нийгмийн байдал, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, албан тушаал зэрэг нийгмийн шинжийн аль ч түүний өмнөх тэр бололцоог тодорхойлох учиргүй. Тиймээс тэгш боломжийн зарчим нь өөрийн хувь заяагаа сонгох эрхийг хувь хүнд өөрт найдан үлдээдэг учир эрх чөлөөтэй зөрчилддөггүй, харин ч түүний тодорхойлолтын нэгэн хэсэг хэмээн тэмдэглэдэг.

Аливаа сонголт хийх боломжийг хувь хүнд өөрт нь үлдээнэ гэдэг гайхамшигтай зүйл мөн. Гэхдээ тухайн эрх чөлөөгөө хэрэгжүүлэх чадвар нь бидэнд хэр зэрэг адил тэгш заяагдсан билээ гэдэг бол үүнээс дутуугүй анхаарал татах асуудал. Амьдрал хэзээд баян. “Байгал эх өөрийн бүтээлийг хэзээ ч давтаггүй, ямарваа нэгэн юмыг хэзээ ч олноор нь, стандарт маягаар үйлдвэрлэдэггүй юм. Байгалийн урлангаас гарч ирсэн хүн бүр хосгүй өвөрмөц бодгаль чанарыг биедээ шингээсэн”⁵ хэмээн Л.Мизес ончтой хэлжээ. Тиймээс тэдгээрт адил тэгш боломж олгоод орхино гэдэг бол угтаа сонголт хийх боломж олгож буй хэрэг биш, харин тэдэнд тулгалт хийн дарангуйлж буй хэлбэр хэмээн үзэх хандлага ч байдаг. Чухамхүү үүнд тулгуурлан тэгш эрхийн өөр нэг агуулга буюу хоёр дахь санаа гарч ирж буй юм. Энэ нь эхлээд зүүн европод хүчтэй байснаа ХХ зууны хоёрдугаар хагасаас эхлэн баруун европ, түүнчлэн атлантын далайг гатлан АНУ-д улам бүр дэлгэрэх болсон юм. Энэ бол шашин луугаа газар авсан тэгш байдлын буюу “Хүн бүр барианд тэгш орох ёстой” гэсэн бат итгэл үнэмшил бүхий үзэл байлаа.

Тэгш эрхийн энэ зарчмын агуулга өмнөхөөс үндсээрээ ялгаатай. Энэ зарчмыг баримтлагчид нь тэгш бололцооны зарчим нь адил тэгш биш хүмүүст хийсвэр боломжийг олгодог бөгөөд энэ нь хэрэг дээрээ харгис шинжийг агуулдаг. Харин тэгш үр дүнгийн зарчим нь байгалаас өөр өөр төрсөн хүмүүст ялгамжтай хандан баялгийг тэгш хуваарилж, нийгэмд шударга ёсыг тогтоож чадна хэмээн үздэг.

⁵ Л.Мизес. Либерализм. УБ., 2004, 33 дахь тал.

и багцат билээ.

Илэрхийлэлт бөгөөд энэ нь социалист хийгээд нагцст эрх зүйн тогтолцоонд харин "хууль ёсны", "хуулийн дагуу байна" (Rule by Law) хэмээх зармаар зоргоос ангижрыгч цагаалуй нөхцөлд түүнийг эрх зүйт ёс хэмээдэггүй, өөрийн дүрмдээ захирагдахгүй, ямарваа нэгэн эрх мэдэлтний дүрд дүрэм буюу хуулийн өөрийн нь дүрмтэй байгаа үзэл санаа мөн. Харин бөгөөд энэ үгтээр нь явчлалын өөрөөр Rule of Law буюу үгтэйгээр "хуулийн дагуу" энэ хуулийн тогтолцоо нь өөрийн гэжхэн дүрмд захирагдах тогтолцоо байж гэжээ ч эрх бөгөөд хийсвэр бус, болит байж чадсан, процайрт захирагдсан шүүхээр хамгаалуулсан жинхэнэ бат бэх хуулийн тогторхойж болно. Чухамхүү хараат бус, бие даасан бөгөөд шуларга эрх зүйт ёсыг бат хамгийн товчоор "эрх бөлөөний баталгаа" хэмээх

Эрх зүйт ёс ба тэтш эрх

Гүй түүнээс үрчлэж эрх зүйт ёсны тухай авч үзье.

Зэрэгт засвар хийх хэрэгтэй бөгөөд нийгэмд эрх зүйт ёсны зармаас хөндөх мэтээж, үгүй харилуулахын туйлд бид Аристотелийн тодорхойлолтод бата эрх бөлөөний зармаатай хэрхэн үзвэл үзвэл ва гэсэн асуулаа үүсэх нь байгааг бид илрүүлсэн. Энэ туйлуургаан тэтш эрхийн зармааны агуулаж бүрэн илэрхийлж чадалгүй бол тэтш үр дүнтэй зармааны эрх бөлөө үүсгэж Тэгэхээр, тэтш боломжийн санаа нь тэтш эрхийн зармааны агуулаж зармаан болох эрх бөлөөний зармаатай зөршидэг.

Гэхдээ зармаан нь илүү эрхтэй "гэснэтэй агаа уяир үндсэн хуулийн суурь, Тиймээс Джорж Оруэллийн онгой хэлсэнчлэн "бүгдээр тэтш эрхтэй, хэмээхгүйг, хувь хүний эрх бөлөөт энэ хэмжээгээр хүмүүст" билээ, багцтай "тэтш" хуваарилахыг эрмээдэт бөгөөд нийгэмд төрний үүргийн засварлахыг оролддог. Нийгмийн гишүүдийн тэтш бус байдалыг харгалзан Тэтш үр дүнтэй зармаан нь хамгийн товчоор "багцтайн агаа"-г бөлөөний зармаатай хэрхэн үзвэл ва гэсэн асуулаа гарна.

Тэгэхээр, Аристотелийн тодорхойлолтын "тэтш бус хүмүүст тэтш бусар хандана" гэсэн туйлуургаан тэтш эрхийн хоёр дахь санаа нь эрх

санааг нөхцөл байдлаар солих аваас тэгш эрхийн зарчмын агуулга тодрох юм. Ингэхлээр, “ямар нөхцөлд тэгш хандахыг шаардаж байна, тэр нөхцөлд тэгш хандах, харин ямар нөхцөл байдал тэгш бус хандахыг шаардаж байна, тэр нөхцөлд тэгш бус хандах нь тэгш эрх буюу шударга ёс” гэсэн санаа гарч байна. Гэхдээ зарчмын эхний агуулга нь тэгш эрхийн зарчмын үндсэн санаа бөгөөд хоёрдахь санаагаа хөтлөж, түүнийг захирах шинжтэй. Харин хоёр дахийг хэрэглэхийн тулд зайлшгүй үндэслэлтэй байх ёстой бөгөөд эс бөгөөс тэгш үр дүнгийн зарчим адил эрх чөлөөг үгүйсгэх аюултай. Нөхцөл байдал нь өөрөө мөн хийсвэр агуулгаар тайлбарлагдах боломжтой учир тэгш эрхийн зарчмыг хоёрдахь агуулгаар хэрэглэхдээ үндсэн эхний агуулгыг зөрчихгүй, гагцхүү хэрэглэх зайлшгүй тохиолдлыг суурь болгоно гэсэн үг. Эдгээр санааг тодорхой болгох үүднээс хуулийн зарим жишээ татах нь зүйтэй.

Тэгш эрх ба эрх зүйн хэм хэмжээ

Хэзээ нэгэн цагт эрх зүйн асуудлууд бидний анхаарлыг татахаа боливол магадгүй шударга ёсны үзэл санаа нь хэрэг дээрээ бодит бие даасан бөгөөд бүх нийтийн болсон байх үед биз ээ”¹ хэмээн George P. Fletcher гайхалтай хэлсэн байдаг. Тэгш эрхийн зарчим нь эрх зүйн үзэл баримтлалын хүрээнд хамгийн түрүүнд хуваарилах шударга ёсны агуулгатай давхцан эрх чөлөөний зарчимтай уялдаг. Түүний агуулгыг профессор Р.Нозик дараахь байдлаар тайлбарлажээ. үүнд:

1. Одоо байгаа зүйлээ эзэмших зүй ёсны зарчимд тохирсон зүйлийг хүн эзэмших эрхтэй (адил тэгш эрхтэй байх)
2. Хэн нэгний шилжүүлэн өгсөн зүйлийг л эзэмших зүй ёсны зарчимд тохирсон зүйлийг хүн эзэмших эрхтэй (тухайлбал, өмчлөх эрх)
3. Дээрхи хоёр зарчимд тохироогүй зүйлийг хүн эзэмших эрхгүй.

Эрх зүйн хэм хэмжээний хувьд хуваарилах шударга ёс нь “хүн бүр адил эрх чөлөөтэй байна” гэсэн үндсэн зарчмаар баталгааждаг. Харин эрх чөлөө бол хамгийн товчдоо сонголт, үүрэг, хариуцлага гурвын нэгдэл мөн. Өөрийн оюундаа тулгуурлан сонголт хийх боломжтой байж, тэрхүү

¹ G.P.Fletcher. Basic Concept of Legal Thought. Oxford University Press. 1996. p. 79

сонголтын үр дүнд бий болох үүргээ хүлээн, бусдын энэ эрх чөлөөнд хариуцлагатай байх тухай сургааль юм. Энэ утгаараа эрх чөлөө хувь хүнээс оюуны хөгжлийн тодорхой үе шатыг шаардаж, хэрэв тухайн нөхцөл байдал бий болоогүй бол эрх чөлөөний зарчим хязгаартайгаар хуваарилагдана гэсэн үг.

Тодруулах үүднээс Монгол улсын үндсэн хуулийн 14 зүйлийн 2-т заасан “Хүнийг ... нас...-аар ялгаварлан гадуурхаж үл болно”¹⁰ гэснийг зарим эрх чөлөөний зарчимтай холбон авч үзье. Тухайлбал, амьд явах эрх чөлөө нь төрснөөс эхлээд жамаараа үхтэл (энд цаазаар авах ялыг түр орхиё) аль ч насны хүнд эдлэх зүй ёсны эрх чөлөө нь байдаг бол бусадтай эрх зүйн харилцаанд орон эд хөрөнгийн эрх эдэлж, үүрэг хүлээх эрх чөлөө нь тухайн хүний биологийн байдлыг харгалзан хязгаартайгаар хуваарилагддаг. Тиймээс эрх зүйн хувьд эдгээр боломжийг заримдаг, хэсэгчилсэн, бүрэн бус хэмээн ялгаатай авч үздэг билээ. Эхний тохиолдолд хүмүүсийн нас хэд байх нь чухал биш, хүн л мөн бол амьд явах эрхтэй гэсэн агуулгатай буюу нөхцөл байдал ижил хандахыг шаардаж байгаа учир тэгш эрхийн зарчим эхний агуулгаараа хэрэгжиж байгаа болно.

Харин удаах тохиолдолд нөхцөл байдал бус нас нь тухайн харилцаанд оорөөр хандахыг шаардаж байгаа учир ялгаатай хандах нь шударга ёс болж байна. Энэ утгаараа бид эрх зүйн чадамжгүй, эсхүл эрх зүйн заримдаг чадамжтай этгээд эрх зүйн бүрэн чадамжтай этгээдтэй томоохон өмч хөрөнгөтэй холбоотой гэрээний харилцаанд орохыг шударга бус хэмээн үзэж, эрх зүйн анхны байдалд харилцааг сэргээхийг эрмэлздэгсэн¹¹.

Гэхдээ ялгаатай хуваарилалт хийх агуулгаар тэгш эрхийн зарчмыг хэрэглэх нь зайлшгүй байх ёстой гэдгийг бид урьд тэмдэглэсэн билээ. Тухайлбал, хөдөлмөрлөх эрх нь манай улсын хууль тогтоомжид зааснаар эрэгтэй жаран нас, эмэгтэй бол тавин таван нас хүртэл (хэрвээ хүсвэл) байхаар заасан байдаг. Энэ тохиолдолд хүйсийн тэгш эрхийн асуудал хөндөгдөж байгаа бөгөөд хүйс нь хөдөлмөрлөх эрхийг “ялгаатай” хуваарилах үндэслэл болох уу гэдэг асуудал үүснэ. Зарим биений хүчний

¹⁰ Монгол улсын үндсэн хууль, 1992, 14 зүйл

¹¹ Энэ үгэл санаа Иргэний хуульд тусгасан байдаг.

хөдөлмөр эрхэлдэг барилгачин, хүнд үйлдвэрийн ажилчны хувьд энэ нь байж болохоор асуудал мөн. Гэтэл оюуны хөдөлмөр эрхэлж байгаа багш, шүүгч зэрэг ажил эрхэлж буй хүмүүст хөдөлмөрлөх эрхийг хязгаарлаж буй энэ зохицуулалт нь хэр зэрэг зохимжтой вэ? Мэдээж эргэлдээтэй. Хөдөлмөрлөх эрхээ эдлэх насны дээд хязгаар нь энэ тохиолдолд хүйсээс биш, харин хөдөлмөрийн нөхцөл байдлаас шалтгаалж байна. Эхний нас заасан тохиолдол биений хүнд хүчир хөдөлмөр эрхэлж буй хүмүүст хамаарвал илүү зохимжтой бол харин оюуны хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийн хугацаа илүү урт байх боломжтой. Тухайлбал, АНУ-д далан нас хүрсэн шүүгч өөрөө л хүсвэл тэтгэвэр тогтоолгодог бөгөөд хэрэв ингэвэл ажлын богиносгосон цаг буюу өдөрт 4 хүртэл шагаар ажиллан, хүнд хэргүүдийг шийдвэрлэдэг байна.¹² Нөгөө талаас, шүүгч, багш зэрэг оюуны хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн бие тэнхээ, оюуны чадал зэрэг нь нас ахихын хирээр муудах биш, харин улам бүр арвижин тэлж байдагсан.

Бид тэгш эрхийн зарчмын хоёр агуулгыг хуваарилах шударга ёстой холбон үзсэн бол одоо засварлах шударга ёстой холбон авч үзье. Засварлах шударга ёс нь энэхүү хуварилалтын шударга ёсны зарчим алдагдсан тохиолдолд түүнд хариу болж байдаг. Хэрэв хэн нэгэн этгээдийн эрх зөрчигдлөө хэмээн үзэх аваас энэ хуваариалалтын шударга ёсны зарчим эвдэгдэж байна гэсэн дохио мөн бөгөөд эрхийг сэргээх замаар шударга хуваарилалтыг анхны байдалд нь эргээд сэргээхэд засварлах шударга ёсны зарчим үйлчилнэ. Засварлах шударга ёсны үзэл баримтлал нь ретрибутив буюу шийтгэх, коммутатив буюу нөхөн сэргээх гэсэн хоёр агуулгаар тэгш эрхийн зарчимтай уялдаж бөгөөд бид энд ретрибутив шударга ёсыг тэгш эрхтэй уялдуулан авч үзнэ.

Ретрибутив шударга ёсны үндсэн зарчим бол хуваарилах шударга ёсны эвдэгдсэн хэмжээгээр хариу барих явдал. Балар эртний эрх зүй дэх “талсоны зарчмууд” нь хүний нүдийг гэмтээсэн бол гэмт хэрэгтний нүдийг сохлох байдлаар хохирол, шийтгэл хоёрыг тэнцэтгэн, шударга ёсыг

¹² Б.Батзориг, АНУ-д улс төртэй холбоотой асуудлыг шүүх шийдвэрлэдэггүй, *Liberty* сэтгүүд, № 1(601), УБ, 2006. 21 дэх тал.

тогтооход оршиж байв. Германы сэтгэгч Г.Гегелийн “нийгмийн харилцааг ямар хэмжээгээр гэмтээсэн бол тухайн үйлдэл нийгмийн харилцааны анхдагч байдлыг үгүйсгэж байгаа хэлбэр бөгөөд үүнийг гагцхүү үгүйсгэх байдлаар сэргээх боломжтой гэсэн”¹³ “үгүйсгэлийн үгүйсгэлийн хууль”-ийн санаа бол үүний тод илэрхийлэл мөн. Харин өнөө үед энэ нь эрх чөлөөний агуулгатай уялдан харьцангуй хүмүүнлэг шинжтэй болж, эрх чөлөөний анхдагч байдлыг сэргээхдээ гэмтээсэн хэмжээгээр хариу барих биш, харин нөхөн сэргээх агуулгыг илүүтэй тээж байна. Ретрибутив шударга ёс тэгш эрхтэй хэрхэн уялдаж буйг тодорхой жишээ авъя.

Монгол улсын Эрүүгийн хуульд зааснаар онц хүнд гэмт хэрэг үйлдсэн үед цаазаар авах ял шийтгэдэг. Гэхдээ уг хуулийн 53.4 зүйлд зааснаар “арван найман насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жаран нас хүрсэн эрэгтэй хүмүүст цаазаар авах ял оногдуулж болохгүй”¹⁴ хэмээжээ. Тэгэхлээр, эхний тохиолдолд буюу насанд хүрээгүй этгээд үйлдсэн бол насанд хүрсэн этгээдээс ялыг ялгамжтай хандан оноох нь тэгш эрхийн зарчимд тохирно. Учир нь насанд хүрээгүй этгээдэд бидний өмнө үзсэнээр хуваарилах шударга ёсны дагуу эрх чөлөө нь хязгаартай хуваарилагдсан. Харин энд анхаарал татаж буй асуудал бол мөн л хүйсний асуудал юм. Хуулийн уг заалтыг өмөөрөгчид энэ бол хүмүүнлэг ёсны зарчим хэмээн тайлбарладаг. Хэрэв үнэхээр хүмүүнлэг ёсны зарчим мөн бол эрэгтэйчүүдийг өөрийн анхаарлын гадна орхидог хувьдаа илүү харгис шинжтэй болж таарна. Тиймээс энд хүйсний ялгаатай байдал гэхээсээ гэмт хэргийн мөн чанар, хор хохирол, үйлдсэн арга зэрэг нь ялыг ялгаатай оногдуулах үндэслэл чухамхүү тэгш эрхийн зарчимд илүүтэй нийцэх билээ.

Дүгнэлт

Огүүдлийн эхэнд бид тэгш эрхийн зарчмыг хэрхэн ойлгох талаар асуудал дэвшүүлсэн бөгөөд үүндээ эрх зүйт ёсны үүднээс хариулт эрсэн

¹³ Б.Шюенманн, Эрүүгийн эрх зүйн хүмүүнлэг шинж чанар, ХБНГУ-ын Ханис-Зайцелийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл, УБ., 2005

¹⁴ Монгол улсын Эрүүгийн хууль, 2002

билээ. Эрх чөлөөний зарчимтай үл зөрчилдөх тэгш эрхийн санаа нь илүүтэй хуулийн буюу формаль агуулгаар илэрдэг болохыг хөндсөн. Тэгээд тэгш эрх бол эрх зүйн тэгш хуваарилалт хийх замаар эрх чөлөөг хангадаг эрх зүйт ёсны суурь зарчим болохыг олж илрүүдсэн. Тиймээс тэгш эрх нь эрх чөлөөтэй зөрчилдөх биш, харин түүний салшгүй хэсэг мөн хэмээн дүгнэж, өгүүллээ эцэслэе.

Ном зүй

Гадаад хэл дээр

1. Freeman M.D.A. Lloyd's Introduction to Jurisprudence. London., 2001. p. 15
2. Fletcher G.P. Basic Concept of Legal Thought. Oxford University Press. 1996. p. 79

Монгол хэл дээр

3. Батцэрэн Б. АНУ-д улс төртэй холбоотой асуудлыг шүүх шийдвэрлэдэггүй. Liberty сэтгүүл. № 1(001). УБ., 2006. 21 дэх тал.
4. Боаз Д. Либертарианизм. УБ., 2005. 89 дэх тал
5. Мизэс Л. Либерализм. УБ., 2004. 33 дахь тал.
6. Төр-од Л. АНУ, Франц, Энэтхэг, Герман, өмнөд Африк болон Монгол улсын үндсэн хууль дахь тэгш эрхийн тухай заалтууд: харьцуулсан судалгаа. Гадаадын их дээд сургууль төгсөгчдийн эрдмийн бүтээлийн эмхтгэл. УБ., 2003. 74 дэх тал.
7. Фридман М., Фридман Р. Хувь заяагаа сонгох нь. УБ., 2001. 106 дахь тал
8. Хаек Ф.А. Боолчлогдох зам. УБ., 2004. 67 дахь тал
9. Шюнемани Б. Эрүүгийн эрх зүйн хүмүүнлэг шинж чанар. ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл. УБ., 2005
10. Монгол улсын үндсэн хууль. 1992.
11. Монгол Улсын Иргэний хууль. 2002.
12. Монгол улсын Эрүүгийн хууль. 2002

ҮНДСЭН ЭРХ: СУУРЬ ОЙЛГОЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ,
ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Докторант Ч.Өнөрбаяр

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш

Оршил: Үндсэн эрхийн мөн чанар, агуулга

Жам ёсны эрх нь хүмүүсийн бий болгосон (позитив) эрхээс давуу гэсэн үзлийг МЭО V зууны Грекийн түүхээс бид олж мэдэх болно. Чухам энэ л үеэс бурхан тэнгэр хүн бүрийг тэгш байхаар бүтээсэн бөгөөд хэнийг ч боод болгоогүй гэсэн үзэл санааны улбаатай. Эртний сэтгэгч Аристотель “Аливаа хууль нь нэгэн төрлийн (жам ёсны Ч.О) эрхэд үндэслэж байдаг”¹ гэж бичсэн байна. Хэрэв тиймгүй бол хууль нь хэмжээгүй эрхт ноёрхлын хэрэгсэл болж хувирна”² гэж тэрээр бичжээ. Түүний үзлийг цааш хөгжүүлсэн ромын хуульч Марк Туллий Цицерон “Жинхэнэ хууль гэдэг нь байгалийн хууль зүй тогтолд нийцсэн, хүн бүрт хамаатай, мөнхийн ухамсар юм”³ гэж тэмдэглэсэн нь бий. Хожим сонгодог жам ёсны эрх зүйчид энэхүү эрхийг “салгаж боломгүй”, “өөрчлөгдөшгүй”, “мөнхийн” гэсэн янз бүрийн томъёоллоор ойлгож ирсэнээс тэдгээр нь өөр хоорондоо сөргөлдөхөд хүрсэн байна⁴. Улмаар энэ нь дундад зууны Европ дахиныг бүхэлд нь эзэмдсэн абсолютизмын эхлэл болсон юм. Үүний шалтгааныг зарим судлаачид бичмэл Үндсэн хууль байгаагүйтэй холбон тайлбарладаг.⁵ Хэмжээгүй эрхт хаант засгийг хамгаалсан абсолютизмыг эсэргүүцэж, эрх чөлөөт, үндсэн хуульт ёс бүхий ардчилсан төртэй байхыг шаардсан анхны онолч бол Жон Локк юм. Түүний үзлээр хаант засгийн тэнгэрлэг гарал

¹ Аристотель, Политика 12, 18, 1225а, С.19.

² Мөн ном, III, 2, 4.

³ Ю.Харбих, Орчин үеийн үндсэн хуульт төрийг тодорхойлох нь, ХБНГУ-ийн Хэлнэ-Зайхслийн сангийн 10 жилийн ойд зориулсан олон улсын симпозиумд танисан явдал.

⁴ New Encyclopaedia Britannica (ed 15)1992, pp 656

үүсэл худал хуурмаг ажээ. Төрийн бүхий л эрх мэдэл нь бүх нийтийн ашиг сонирхолд үйлчлэх учиртай. Төрийн эрх мэдлийг хэн ч, хэзээ ч дур зоргоороо хэрэгжүүлж болохгүй бөгөөд зөвхөн хууль эрх зүйд нийцсэн байх ёстой. Хожим нийтээр хүлээн зөвшөөрөгдөх болсон түүний гол уриа нь: Хүмүүсийн бус, хуулийн засаг (Government of laws, not of men) байв.⁴ Үндсэн эрх нь хувь хүнийг төр засгийн хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах шинжтэй эрхүүд болохын хувьд дарангуйллын төрд байх бололцоогүй төдийгүй тийм төрийн оршин тогтнох чадварыг сулрууладаг. Энэ ч утгаар Виржинийн Хүний эрхийн Биллийн оршил хэсэгт үндсэн эрхийг “засаглалын үндэс”⁵ хэмээн тунхагласан.

Үндсэн эрхийн гол агуулга нь юу вэ? гэдэг асуултад нийтлэг хариулт өгөх боломжгүй. Учир нь энэ нь хүн төрөлхтний сэтгэлгээний хүрсэн төвшин, оршин буй нийгмийн эрхэмлэлээс шалтгаалан янз бүрийн цаг хугацаанд харилцан адилгүй байх бололцоотой. Тухайлбал, Георг Еллиникийн бичсэнээр “хүний хамгийн суурь үндсэн эрх нь бурхантай харилцаа тогтоох эрх чөлөө” юм.⁶ Харин зарим судлаачид хүний үндсэн эрхийн үзэл баримтлалын гол агуулга нь өөрөө өөрийгөө мэдэхүй (human dignity)⁷ эсхүл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө гэж үздэг.⁸ Миний баримталж буй үзлээр, энэ нь өөрөө өөрийнхөө үндэслэл, баталгаа болдогт оршино.

Үндсэн эрхэд тавигдах формал шаардлага

Орчин үеийн үндсэн хуульд ёсны онолоор хүний жам ёсны эрх нь эрх зүйн үндсэн хэм хэмжээ хийгээд зарчмуудад зайлшгүй тусгалаа олсон байх ёстой. Ингэж байж гэмээнэ үндсэн эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан, төрийн эрх мэдлийг хязгаарлах хүчин чадалтай, шууд үйлчлэх эрх зүй болж чадна. Хэрэв ээ хүний эрхийг дан ганц жам ёсны

⁴ Ю.Харбах, Орчин үеийн үндсэн хуульд төрийг тодорхойлох нь, ХБНГУ-ын Хаанс-Зайдстийн сангийн 10 жилийн ойд зориулсан олон улсын симпозиумд тавьсан илтгэл.

⁵ Мөн тэнц.

⁶ Виржинийн Хүний эрхийн Биллийн (1776, 07, 12) Оршил хэсэг.

⁷ Peter Saladin, Grundrechte im Wandel, 2. Auflage, Bern, 1975, S 2ff (дам нийтэн)

⁸ Дэвид Боал, Либертарианизм, УБ., 2005, 91 дэх тал.

зүйл, философийн бодрол эрэгцүүлэлийн нэг хэсэг гэж үзэх аваас энэ нь өөрөө хэрэгжих(self-executive) эрх болж чадахгүй. Нэгэнт хэм хэмжээчлэгдээгүй эрхийг шүүхүүд хэрэглэх боломжгүй юм. Харин олон улсын болон зарим улсын үндэсний эрх зүйд өөрөө хэрэгжих шинжгүй(non self-executing) үндсэн эрхүүд гэж бий. Энэ нь шүүх хэрэглэхээс өмнө хууль тогтоогч зайлшгүй баталгааг нь бүрдүүлж өгөх учиртай тийм үндсэн эрхүүд юм. Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-д заасан: “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”, 16 дугаар зүйлийн 4-д заасан: “хөдөлмөрийн аятай нохцлоор хангуулах эрх” 16 дугаар зүйлийн 6-д заасан “эрүүл мэндээ хамгаалуулах” зэрэг үндсэн эрхүүд өөрөө хэрэгжих шинжгүй(non self-executing) юм. Ийм утгаар нь эдгээр үндсэн эрхүүдийг Үндсэн хуулийн цэцгээс хамгаалах боломжгүй. Тиймээс ийм эрхүүдийг үндсэн хуульд ардчилсан төртэй улс орнууд үндсэн эрх гэдэг утгаар нь бус харин “нийгмийн баримжаат төр” гэсэн үндсэн хуульд ёсны зарчмаар хангадаг байна. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд: “ХБНГУ нь ардчилсан бөгөөд нийгмийн баримжаат холбооны улс байна”¹¹ хэмээн тодорхой заасан юм. Энэхүү зарчмыг Монгол улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт: “...хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”¹² хэмээн тунхагласан.

Австрийн хуульч, эрх зүйн онолч Ханс Кельзен “Хэрвээ хуулийн утгыг ямар нэг дур зоргод захируулвал, цэвэр эрх зүй утга алдана. Учир нь нийгэм дэх эрх зүйн шийдэх ёстой асуудлыг эрх зүйн бус аргаар шийдээд эхэлбэл тухайн нийгэм хаос төлөвт орно. Тэгэхлээр, эрх зүй гэдэг хэм хэмжээт логик илэрхийлэл юм”¹³ гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Тэрбээр “Эрх зүйн цэвэр онол” бүтээлдээ эрх зүй өөрөө өөрийнхөө ертөнцийг цогцлуулахын тулд бусад бүх хэм хэмжээг бүтээх Үндсэн хэм хэмжээ байхад л хангалттай¹⁴ гэж бичсэн нь хууль зүйн шинжлэх ухааны дотоод системчлэлийг өргөжүүлэн тэлж, орчин үеийн үндсэн хуульд ёсны

¹¹ Ц.Сарантува. Үндсэн эрх болон Хүний эрх: харьцуулалт, онолын эргэнцүүлэл. Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №01, 19 дэх тал.

¹² ХБНГУ-ын Үндсэн хууль, 1949, 20 дугаар зүйл.

¹³ Монгол улсын Үндсэн хууль, 1992.

¹⁴ M.D.A. FREEMAN, LLOYD'S INTRODUCTION TO JURISPRUDENCE, LONDON 2001, P 336.

онолыг хөгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлсэн юм. Кельзений үндсэн хэмжээ нь аливаа улсын Үндсэн хуулинд тусгалаа олдог байна.¹⁵ Тиймээс Үндсэн хуулийг "тусгай журмаар батлагдаж, хүндрүүлсэн журмаар өөрчлөгдөж болдог дээд хэм хэмжээнүүдийн нийлбэр"¹⁶, "...хамгийн дээд зарчим буюу хэм хэмжээнүүдийн хэм хэмжээ..."¹⁷ гэж тодорхойлдог. Энэ нь үндсэн эрхтэй зөрчилдөж буй бүхий л захиргааны акт, шүүхийн шийдвэр, тэр ч бүү хэл хууль хүртэл алдаатайд тооцогдоно гэсэн үг.

XX зууны дунд үеэс үндсэн хууль ёсны хөгжилд томоохон хувьсал гарч, энэ нь хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн асуудлыг цоо шинээр авч үзэхэд хүргэсэн. Тодотговол, эрх зүйг хэм хэмжээ хэмээн үзэх уламжлалт хандлага нь "тэг эсхүл, үгүй" (all-or-nothing) гэсэн ерөнхий нөхцөлд захирагддаг учраас түүний дунд орших асар олон эрх зүйн асуудлыг шийдэхэд хүчин мөхөсддөг. Тиймээс эрх зүйн харьцангуй уян хатан чанарыг нэмэгдүүлэх замаар түүний үндсэн зорилгыг хангахын тулд эрх зүйн зарчмуудыг чухалчлах болов. Үүнийг онолын түвшинд боловруулсан сэтгэгч бол профессор Р.Дворкин юм. Түүнийхээр эрх зүйн хэм хэмжээ ба зарчмын хоорондын ялгааны асуудал бол цэвэр логикийн асуудал бөгөөд тэдгээрийн аль аль нь хэргийн тодорхой нөхцөл байдалд тохирон мөрдөгдөх ёстой хүрээ хязгаар, стандартыг тогтоож өгдөг боловч тус тусын чиглэлээр бие биеэс ялгагдана. Тухайн тодорхой тохиолдолд нийцэж тохирохгүй байвал эрх зүйн хэм хэмжээ нэг бол хэрэглэгдэж, үгүй бол үл хэрэглэгдэнэ. Үүнээс үүдэн эрх зүйн хэм хэмжээ нь урьдчилан тодорхойлсон шийдвэрийг агуулж байдаг. Харин эрх зүйн зарчмууд нь шийдвэр гаргах үндсэн чиглэлийг тодорхойлдог.¹⁸

Энэ бүхэн нь Үндсэн хуулийг иргэний үндсэн эрхийн бүхий л асуудлыг үүрд мөнхийн болгон баталгаажуулж өгсөн хэм хэмжээнүүдийн оргил, ардчилсан эрх зүйт ёсны суурь зарчмуудын бүрдэл гэж ойлгоход хүргэдэг.

¹⁵ Ibid. S 221-222.

¹⁶ Gerhard Robbers, *An Introduction to German Law*, German, 1998, p 48.

¹⁷ Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй, суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005, 41 дэх тал.

¹⁸ Хайнрих Шеллер, Нийцдэг эрх болох үүний эрүүдийн түүх, онол, тогтолцоо, (Хүний эрх ба Үндэсний аюулгүй байдла, Олон улсын сэнхлэг)УБ., 1996, 42 дэх тал.

¹⁹ R.Dworkin, *Is law a system of Rules?*, Harvard Review, P 43

Үндсэн эрх нь үндсэн хуулийн бүрдэл хэсэг төдийгүй үндсэн хуульт ёсны давуу хүчин чадалтай байх зарчим болдог. Хэдий тийм ч “Үндсэн хууль” хэмээх нэр зүүсэн улс төр, эрх зүйн бүхий л баримт бичигт тусгалаа олсон хүний эрх, эрх чөлөөг үндсэн эрх гэж шууд ойлгож болохгүй. Түүхийн хуудас сөхвөл, 19 дүгээр зууны Үндсэн хуулиуд, түүнчлэн 20 дугаар зууны зарим Үндсэн хуульд улс төрийн мөрийн хөтөлбөр, зарлан тунхагласан зүйлүүд, хоосон амлалт, эсхүл хэрэгжүүлбэл зохих бодлогын шинжтэй ямар ч үүрэггүй заалт агуулагдах нь олонтаа тохиолдог.¹⁹ Тийм ч учраас 1789 оны Францын “Хүний ба иргэний эрхийн тунхаг”-т: “Хүний эрхийг баталгаажуулаагүй, засгийн эрхийг хуваарилаагүй нийгэм бол угтаа Үндсэн хуульгүй нийгэм юм”²⁰ гэж заасан нь тохиолдлын хэрэг байгаагүй юм.

Үндсэн эрхийн ангилалт, түүний шалгуур

Уламжлалт хандлага. Хүний эрхийн сэтгэлгээ үүсч бүрэлдэхдээ юуны өмнө эхлээд улс төрийн болон иргэний эрхийн хүрээгээр хязгаарлагдсан (*сонгох, сонгогдох, үг хэлэх, хэвлэн нийтлэх болон орон сууцны халдашгүй байдал, амьдрах эрх, чөлөөтэй аюулгүй байх г.м*) байсан бол XIX зууны сүүлч үеэс нийгэм, эдийн засгийн болон соёлын эрхийн төрөл зүйлийг хамрах болсноор (*хөдөлмөрлөх, сурч боловсрох, хувийн өмчтэй байх г.м*) түүний хүрээ ихээхэн өргөгжсөн байна. XX зууны хоёрдугаар хагасаас экологийн болон хөгжих эрх, эрүүл мэндээ хамгаалах, мэдээллийн эрх чөлөө зэрэг хүрээг нэмж тусгах болсон.²¹ Үүнээс үүдэн иргэний үндсэн эрхийг:

- Хувийн эрх, эрх чөлөө
- Эдийн засаг нийгэм соёлын эрх, эрх чөлөө
- Улс төрийн эрх, эрх чөлөө²² гэж ангилах болсон.

Эрх зүйт нийгэмд амьдарч буй жирийн иргэнд хүний эрх, эрх чөлөө, ардчиллын боловсрол олгох гэж байгаа бол энэхүү ангилалт чухал ач

¹⁹ Ю.Харбин, Орчин үеийн үндсэн хуульд төрийг тодорхойлох нь, ХБНГУ-ын Хөнгө-Зайзэлийн сангийн 10 жилийн ойл зориулсан олон улсын симпозиумд тавьсан илтгэл.

²⁰ David Appeloony, French Legal System, NLSIU, Bangalore, 1995.

²¹ Д.Баярсайхан, Хүний эрхийн онцгой сэтгэлгээ, уламжлал, шинэчлэлийн асуудал, Эрх зүй сэтгүүл, УБ., 2000, №01, 14 дүв тал.

²² Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000, Д.Түндэлжиданов, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, УБ., 1997.

холбогдолтой нь мэдээж. Харин үндсэн хуулийн шүүхийн журмаар үндсэн эрхийг хамгаалах гэж байгаа бол төдийлөн ач холбогдолгүй билээ.

Орчин үеийн хандлага. Үндсэн хуульт ёсны онолд үндсэн эрх нь түүхэн хөгжлөөсөө үл хамааран хүний эрх зүйн байдлыг л хамгаалах үүргийг гүйцэтгэх ёстой гэж үздэг. Үүнээс үүдэн зарим судлаачид хүний эрхийг эх сурвалж, уг чанараар нь жам ёсны буюу төрөлх эрх, олдмол буюу позитив эрх гэж ангилдаг.²³ Нөгөөтэйгүүр үндсэн эрхийг *материаллаг (status substantive)* ба *процессын (status proceduralis)*²⁴ гэж ангилж болох талтай. **Материаллаг эрхэд** хүний эдлэх ёстой тодорхой эрх, эрх чөлөө: үг хэлэх, шүтэх, эс шүтэх эрх чөлөө, оршин суух газраа чөлөөтэй сонгох, эрүүд мэндээ хамгаалуулах гэх мэт эрх хамаарна. **Процессын эрх** гэдэг нь хүний мэдэлд олгогдсон төр засгаас хүн өөрийн эрхийг хангах, биелүүлэх, хамгаалуулахыг шаардах үйлдлийн арга, тэдгээрт хамааралтай институтуудыг хэлнэ.²⁵ Гэсэн хэдий ч ингэж ангилах нь тэр бүр оновчтой байдаггүй. Учир нь төр засгийн зүгээс хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болох эрх, ямар ч нөхцөл байдал үүссэн хязгаарлаж үл болох эрхийн аль алиныг зөвхөн материаллаг эрхийн ангилалд хамааруулан авч үздэгээрээ онол, арга зүйн хувьд учир дутагдалтай. Тиймээс иргэний үндсэн эрхийг *negativus(status negativus)* болон *pozitivus(status positivus)*²⁶ гэж ангилах нь бий.

Негатив эрх гэж хувь хүний амьдралд төр засаг ямар ч нөхцөлд дур мэдэн оролцохоос хамгаалсан хориг. Үүнийг Монгол улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Они болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх

²³ Б.Чимэд. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. Хоёрдугаар дэлгэр. УБ, 2004. 17 дахь тал.

²⁴ Х.Шоллер. Нийцлэг эрх болох хүний эрүүдийн түүх, онол, тогтолцоо. Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал. Олон улсын симпозиумын эмхтгэл. УБ, 1996. 52 дахь тал.

²⁵ Д.Солонго. Хүний эрхийн тухайд. Хүний эрх сэтгүүд. УБ, 2003. 4 дэх тал.

²⁶ Thomas W. Simon. Law and Philosophy, Illinois State University, 2001. p. 216-227. Х.Шоллер. Нийцлэг эрх болох хүний эрүүдийн түүх, онол, тогтолцоо. Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал. Олон улсын симпозиумын эмхтгэл. УБ, 1996. 52 дахь тал. Д.Солонго. Хүний эрхийн тухайд. Хүний эрх сэтгүүд. УБ, 2003. 4 дэх тал.

чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэригий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө”²⁷ гэж бэхжүүлсэн байна. Гэсэн хэдий ч эрх чөлөөтэй байна гэдэг Эрх зүйт ёс(The rule of law)-оос гадуур амьдарна гэсэн үг биш ээ. Учир нь эрх зүйт ёс гэдэг бол хэн нэг эрх мэдэлтний баталсан тушаал, заавар бус, нийтээр хүсэж аяндаа бий болгосон эрх зүйн дэг журам юм. Түүнээс дээгүүр хувь хүн, түүнээс гадуур ямар нэг дур зориг гэж байх ёсгүй.²⁸ Тиймээс негатив эрхийн ойлголт эрх зүйт ёсноос илүүтэй хууль тогтоогчын баталсан хуулиудтай холбогдон үүсдэг.

Төр засгийн үүрэг бол иргэдийн эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах. Энэхүү үүргийг хууль зүйн шинжлэх ухаанд **позитив эрх** хэмээн нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, би алив нэг эрхтэй бол төр засаг миний хувьд ямар нэг юм хийх үүрэгтэй. Тухайлбал, иргэд шүүхэд хандах эрхтэй гэж байгаа бол төр засаг зохих шатны, чадварлаг, мэргэшсэн шүүгчдээс бүрдсэн шүүх байгуулах үүрэгтэй. Хэдий тийм ч төр засаг энэхүү үүргээ биелүүлэхдээ хувь хүний өөрөө өөрийгөө хогжүүлэхэд нь тээг болох ёсгүй. Хэрэв үндсэн эрхүүдийн хооронд зөрчилдөөн үүссэн тохиолдолд түүнийг үндсэн хуулийн шүүхүүд эрх зүйн тайлбар хийх замаар шийдвэрлэж байх ёстой. Үндсэн хууль ёсны үзэл баримтлалын дагуу “эрх чөлөөтэй байх” баталгааг бүрдүүлж буй хэм хэмжээнүүд нь “адил тэгш байх” эрхийн баталгааг бүрдүүлж буй хэм хэмжээнээс ямагт давуу хүчин чадалтай байх ёстой.

Үндсэн эрхийг хязгаарлах үндэслэл ба үндсэн хууль ёс

Иргэний үндсэн эрх нь эн тэргүүнээ төрөөс эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхийн эсрэг эрх зүйн хамгаалалт юм. Үндсэн эрх нь нийгэм, эрх зүйн орчинд хэрэгжихдээ төрийн анхааралд байх ёстой өөр эрхэм зорилго, үнэт зүйлтэй өөрийн эрхгүй зөрчилддөг. Тухайлбал, хувь хүний эрх амьдрах эрх, төрөөс цагдаагийн хүчээр нийгмийн дэг журмыг сахиулах үүрэгтэй, хувийн өмчийн халдашгүй дархан байдал лайны болон онц байдлын үед хувийн өмчийг дайчлан авах эрхтэй зөрчилдсөн тохиолдолд төрөөс үндсэн эрхийг хөндөх магадлал өндөр байдаг. Иймд төрийн эрхэмлэх ёстой үнэт

²⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

²⁸ Дэвид Боул, Либертарианизм, УБ, 2005, 33 дахь тал.

зүйл буюу үндэсний аюулгүй байдал, хувь хүний чөлөөтэйгээр орших баталгаа болсон үндсэн эрхийн харьцааг зөв тодорхойлох чухал юм.

Ардчилсан нийгэмд үндсэн эрхийг хоёр талаас аюул заналхийлж байдаг: нэг талаас, зохион байгуулалттай гэмт хэргээс өөрийгөө хамгаалах чадваргүй, үүнээс үүдэн хувь хүний аюулгүй байдал алдагдахад хүрэх хэтэрхий сул төр, нөгөө талаас Үндсэн хуулиа тоомсорлодоггүй, ямар ч хяналтгүй хэтэрхий хүчтэй төр.²⁹ Харин үндсэн хуульт ардчилалд үндсэн эрхийг дээдлэн хүндэтгэх нь төрийн бүхий л байгууллага, албан тушаалтны үндсэн үүрэг билээ. Ийм утгаараа бид Монгол улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал..., нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”³⁰ гэснийг үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахих нь үндсэн эрхийг дээдлэн хүндэтгэхээс эн түүрүүнд тавигдах ёстой гэж ойлгож хэрхэвч болохгүй.

Үндсэн эрхийг төрийн зүгээс хязгаарлах үндэслэлүүд өдгөө нэг мөр шийдэгдээгүй боловч дараахь хэдэн үндэслэл дээр эрх зүйчид маргадаггүй. Үүнд: 1) зөвхөн хуулийн үндсэн дээр хязгаарлах; 2) Үндсэн хуулийн өөр заалтанд захируулах замаар; 3) харьцангуй байх зарчмыг баримтлах; 4) үндсэн хуулийг өөрчилж үл болох хэсгийг хөндөхгүй байх; 5) эрх зүйт ёсны үндсэн зарчмыг зөрчихгүй байх.³¹

Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалаар гагцхүү ардчиллын зарчмаар гарч ирсэн хууль тогтоогч л хуулиар эрх олгосон тохиолдолд төрийн зүгээс иргэний үндсэн эрхийг хөндөж болно. Хуульгүйгээр засгийн газар ч тэр, шүүх ч тэр үндсэн эрхийг хөндөх ёсгүй. Харин энд зайлшгүй баримтлах ёстой зарчим бол хязгаарлалт нь үндсэн эрхийг хэдий чинээ хөндөхөөр байна төдий чинээ хуулиар тогтоосон эрх зүйн үндэслэлүүд нь “тодорхой байх ёстой”³² гэсэн эрх зүйт ёсны формал шаардлага хангагдаж байх учиртай. Үүнтэй зэрэгцэн үндсэн эрхийг хязгаарлах тохиолдол бүрийг

²⁹ Еорг Паул Мюллер. Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд. Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал. Олон улсын симпозиумын эмхтгэл. УБ, 1996. 76 дахь тал.

³⁰ Монгол Улсын Үндсэн хууль, 1992. 19 дүгээр зүйл.

³¹ Еорг Паул Мюллер. Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд. Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал. Олон улсын симпозиумын эмхтгэл. УБ, 1996. 76 дахь тал.

нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн эрхэм зорилгоор зөвтгөж болно. Тухайлбал, нийгмийн дэг журмыг сахин хамгаалах, нийт иргэдийн сайн сайхан байдлыг хангах, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зэрэг нь Ард түмний гэрээ(Social contract) болсон Үндсэн хуульд тусгалаа олсон байдаг. Түүнээс биш нийгмийн тодорхой хэсэг(олонхи эсхүл цөөнхи), аль нэг улс төрийн хүчин, санхүүгийн олигархуудын ашиг сонирхлыг хамгаалах үүднээс үндсэн эрхэд халдаж үл болно. Хэдийгээр Монгол улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно"³³ хэмээн заасан боловч бид энд маш болгоомжтой хандах учиртай. Ваймерийн БНУ нуран унасны гол шалтгаан бол Үндсэн хуулинд заасан онц байдлын заалт бүдүүлгээр зөрчигдсөнөөс болсон хэрэг. Үүнээс болоод Бонны Үндсэн хуулинд ерөөсөө онц байдал тогтоох тухай заалт оруулах эсэх дээр үнэхээр айж байсан юм. Үүнийг нэлээд хожим 1961 оноос хойш нөхөж оруулсан билээ. Гэсэн хэдий ч Германы үндсэн хуулийн эрх зүйчид Бонны Үндсэн хуулинд орсон онц байдлын талаархи заалтууд нь ойлгомж муутай, нэгдмэл ойлголт өгөхөөргүй шүүх, олон нийтийн зүгээс хяналт тавихад хэцүү болсон гэж дүгнэдэг.³⁴

Үндсэн эрхийг хязгаарлахад баримтлах дараачийн үндэслэл бол харьцангуй байх зарчмыг удирдлага болгох явдал юм. Энэ нь тухайн тодорхой тохиолдолд эрх зүйн үүднээс ямар шаардлагатай байна тэрхүү хэмжээгээр л хязгаарлалтыг тогтоож болно гэсэн үг. Үүнээс илүү ч үгүй дутуу ч үгүй. Үүнийг эрх зүйт ёсны формал шаардлагуудын нэг болсон ухаалаг(рациональ) байх зарчим хангадаг. Тухайлбал, хууль тогтоох үйл ажиллагаанд хэн нэгэн хүн саад учруулсан бол тухайн хүнийг парламентын хэвийн үйл ажиллагаа сэргэх хүртэл цагдан хорьж болно.

Үндсэн хуульд ёс бүхий ардчилсан улсуудад ямар ч тохиолдолд, бүр төрийн эрхэм зорилгын үүднээс ч хөндөж үл болох үндсэн эрх гэж бий.

³³ D. Neil MacCormick, 'Rechtsstaat' and Rule of Law, The Rule of Law, Edited by Josef Thiesing, Konrad-Adenauer-Stiftung, 1997, p. 72.

³⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

³⁵ Еорг Паул Мюллер. Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд. Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал. Олон улсын симпозиумын эмэлтгэл. УБ.,1996. 87 дэх тал.

Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д: “Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэргийг хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...”³⁵ хэмээн агуулга болоод хэлбэрийн талаас нь хоёрдмол утгагүйгээр нарийн тодорхой зааж өгсөн. Түүнчлэн дээрхи хуулийн 14 дүгээр зүйлийн 2-д заасан: “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн нь мөн л дээрхи үндсэн эрхэд хамаарна. Эдгээр эрхүүдийг төрийн зүгээс ямар ч тохиолдолд бүр үндэсний аюулгүй байдалд бодитой хор аюул учирсан байсан ч хөндөж үл болно.

Төрөөс үндсэн эрхийг хязгаарлахад зайлшгүй баримтлах ёстой үндсэн хуульт ёсны бас нэг шаардлага бол эрх зүйт ёсны үндсэн зарчмуудыг хүндэтгэх явдал билээ. Тухайлбал, хэн нэг хувь хүнээс эрх чөлөө, ардчилал, энх тайваны эсрэг онц аюултай гэмт хэрэг үйлдсэн байлаа ч гэсэн хууль зүйн туслалцаа авах, ямар ч тохиолдолд хараат бус шударга шүүхээр шүүлгэх эрхийг нь хасаж болохгүй. Түүнчлэн хуульд заагаагүй зүйл ангиар хэнийг ч шийтгэж болохгүй(*nulla poena sine lege*).³⁶ Энэхүү зарчмуудыг Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д: “...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах...эрхтэй. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно”³⁷ хэмээн бэхжүүлж өгсөн байна.

Үндсэн эрх үндэсний аюулгүй байдлын бүрдэл хэсэг болох нь

Бидний олонхи үндсэн эрх үндэсний аюулгүй байдалтай цагт ямагт зорчилддаг мэт боддог. Гэсэн хэдий ч ингэж ойлгох нь дийлэнхидээ алдаанд хүргэдэг. Монгол улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д:

³⁵ Монгол Улсын Үндсэн хууль. 1992. 16 дугаар зүйл.

³⁶ Bentham Jeremy. *Anarchical Fallacies*. London.Methuen, 1967. p. 73

³⁷ Монгол Улсын Үндсэн хууль. 1992. 16 дугаар зүйл.

“...үндэсний аюулгүй байдал...-ыг хангах нь төрийн үүрэг мөн”³⁸ гэж заасан байна. Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэснийг 11 дүгээр зүйлийн 1-д заасан төрийн үүрэгт багтаан ойлгох нь зүйтэй. Гэсэн хэдий ч хууль тогтоогч болон үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д заасан ойлголтуудыг хэрхэн тайлбарлахаас ихээхэн зүйл шалтгаалах юм. Магадгүй буруу тайлбар хийвэл энд үндсэн эрх зөрчигдөх магадлалтай. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д: “Үндэсний аюулгүй байдал” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”³⁹ гээд үндэсний аюулгүй байдлын бүрдэл хэсгийг дараахь байдлаар тодорхойлсон байна:

- Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;
- нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;
- иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;
- эдийн засгийн аюулгүй байдал;
- шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;
- мэдээллийн аюулгүй байдал;
- монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;
- хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;
- экологийн аюулгүй байдал⁴⁰

Оноо үед баримталж буй хамгийн түгээмэл хандлагаар “Үндэсний аюулгүй байдал” буюу “National Security” нь төрийг гадны халдлага, иргэний дайн, эдийн засгийн хүнд хэцүү хямрал, байгалийн гамшиг, одоон хатгалга, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, төрийн эргэлт хийх оролдлого, хувьсгал, өргөн хүрээтэй үндэсний аюулгүй байдалд заналхийлэх хууль бус явдлаас хамгаалах гэсэн утгатай.⁴¹ Эндээс харахад хууль тогтоогчийн хийсэн тайлбарыг үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэхгүй бол

³⁸ Монгол Улсын Үндсэн хууль, 1992. 11 дүгээр зүйл.

³⁹ Үндэсний аюулгүй байдлын тухай, Монгол улсын хууль, 2001.

⁴⁰ Үндэсний аюулгүй байдлын тухай, Монгол улсын хууль, 2001.

дэндүү өргөн хүрээтэй томъёолол болох нь харагдаж байна. Учир нь үндсэн эрхийг хязгаарлах үндэслэл хэднй чинээ өргөн хүрээтэй байна төдий чинээ зөрчигдөх бололцоотой байдаг. Түүнчлэн аль ч ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдалд үнэхээр аюул тулгарах үед төрийн зүгээс хэтрүүлсэн арга хэмжээ авч, ингэснээр дарангуйлал руу хальтран орж, эрх зүйт ёсны зарчмыг алдагдуулах аюул цаг ямагт нүүрлэж байдгийг санах хэрэгтэй. Ялангуяа аюул учирсан үед Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх явцад хүний эрх, чөлөөг хөсөрдүүлэх явдал олонтаа гардаг.⁴² Энэ утгаараа хуулиуд тэр дундаа үндсэн эрхийг шууд хязгаарлах үндэслэл болж чадах хуулийн зүйл, заалтууд илүү "тодорхой" байдлаар бүтээгдсэн байх ёстой. Үүнтэй зэрэгцэн үндсэн эрхийг хязгаарлах үед төрд өөрт нь хязгаарлалт болдог эрх зүйт ёсны зарчим гэж бий. Үүнийг ихэнхдээ "хязгаарлалтын хязгаарлалтын зарчим"⁴³ гэж томъёолдог. Энэхүү зарчим ёсоор үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь учирах аюулын цар хүрээг зөв тодорхойлсон байх ёстой. Ямар ч ардчилсан нийгэмд үймээн дэгдэх потенциал байдгийг тухайн төрийн зүгээс хүлээн зөвшөөрсөн байх нь чухал бөгөөд түүнийг хүлээн тэвчиж чаддаг байх нь либериал ардчиллын гол зарчим билээ. Тиймээс багахан хэмжээний үймээн дэгдэх төдийд төрд аюул учирч байгаа мэт үзэн иргэний үндсэн эрхийг хязгаарлаж болохгүй юм. Нөгөө талаар иргэний иймэрхүү үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх явдал нь үндсэн хуулийн хэм хэмжээгээр баталгаажсан хувийн болон нийтийн ашиг сонирхлууд хоорондоо мөргөлдөхөөс урьдчилан сэргийлж байдаг. Ийм утгаараа иргэд өөрсдийн үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөгөө эдлэх нь үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцэж байдаг төдийгүй тэдгээр нь үзэл баримтлалын хувьд зөрчилддөггүй юм.

Үндсэн эрхийн эрх зүйт ёсны баталгаа

Эрх зүйн хэм хэмжээнүүд нь иргэний эрх, эрх чөлөөг хангах үүрэгтэй

⁴² Х.Виктор Кондэ, Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага (Орчуулсан, Ж.Амарсана, Н.Цогт) УБ, 2002, 107 дэх тал.

⁴³ Еорг Пауз Мюллер, Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал, Олон улсын символизмын эмхтгэл, УБ, 1996, 81 дэх тал.

⁴⁴ Д.Сүхжид, Үндсэн эрхийн хязгаарлалтын хязгаарлалт, Нээлттэй академ, Цуврал лекц, УБ, 2006, 2 дэх

байдаг. Үндсэн хуульт төрийн тогтолцооны үндсэн бүрдэл болохын хувьд эрх зүйн хэм хэмжээнүүдийг хараат бус шүүхүүд улам бүр баталгаажуулж өгдөг. Тиймээс шүүх нь төрийн эрх мэдлийн бусад байгууллагуудын нөлөөлөл, хяналтаас гадуур гаргахуу хууль тогтоогчийн баталсан хэм хэмжээ эсхүл үндсэн хуульт ёсны зарчим, хэм хэмжээнд үндэслэн аливаа эрх зүйн маргааныг шийдвэрлэх үүргийг ард түмнийхээ өмнө хүлээдэг. Энэ утгаараа шүүх эрх мэдлийн үүрэг нь нэг талаас иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах, нөгөө талаас эрх зүйт төрийн суурь зарчмуудыг баталгаажуулах явдал мөн.⁴⁴ Харин энэхүү чиг үүргээ шүүхүүд нь **хэвтээ** болон **босоо** гэсэн хоёр төвшинд хэрэгжүүлдэг.

Хуулийн доор нэг хүний дур зоргоороо аашлах явдал нөгөө хүний дур зоргоороо аашлах явдалтай холбогдон эрх чөлөө бий болдог хэмээн Имманиул Кант бичсэн⁴⁵ нь бий. Ийнхүү бусдын дур зоргоос иргэний эрх, эрх чөлөөг шүүх эрх мэдлийн тусламжтайгаар дамжуулан хамгаалахыг **үндсэн эрхийн хэвтээ үйлчлэл** гэнэ.

Энэ нь зөв шүүхийн тогтолцоогүйгээр хэрэгжихгүй бөгөөд тийм нийгэмд хувь хүний эрх, эрх чөлөөнд аюул учрах болно. Мэдээж хэрэг эл шүүхийн тогтолцоо нь бусад эрх мэдлээс хараат бус байж гэмээнэ иргэний үндсэн эрхийн хамгаалал, эрх зүйт ёсны баталгаа болж чадна. Тийм ч учраас Ш.Л.Монтескье төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн бие даасан гурван салаанд хуваарилж, харилцан хяналт тэнцэлтэйгээр хэрэгжүүлэх нь хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах баталгаа болохыг тэмдэглээд хэрэв “Хууль тогтоох хийгээд гүйцэтгэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлбэл эрх чөлөөний тухай ярих ч аргагүй,... Нэгэнт эрх чөлөөгүй орчинд хараат бус, шударга шүүх оршихгүй. Шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдэлд нэгтгэвэл иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос болно. Хэрэв гүйцэтгэх эрх мэдэлд шүүх эрх мэдлийг нэгтгэвэл дарангуйлал тогтох боломжтой”⁴⁶ гэсэн нь орчин үеийн үндсэн

⁴⁴ Ч.Онорбаяр. Шүүхийн нийгмийн өмнө хүлээх зарцуулалта ба эл тод байдал. “Шүүх-Ардчилал, хүний эрх, шударга ёсны баталгаа” өмсод-практикийн бага хурлын нэгдүгээдүйн эхэтгэл. УБ, 2005. 28 дэх тал.

⁴⁵ Х.А.Вольфф. Ардчилсан эрх зүйт төр дэх эвлэлтаны хэрт хэвн шийдвэрлэх ажлалтаны Үндсэн хуулийн зохицуулалт. Үндсэн хууль ба ардчилсан эрх зүйт төр симпозиумын эхэтгэл. УБ, 2004. 44 дэх тал.

хуульт ёсны дээд үнэн буюу постулат болсон хэвээр байна.

Тор засаг бол бидний мэдэх хамгийн аюултай эрх чөлөөний дайсан мөн.⁴⁷ Тиймээс эрх зүйт ёсны амин сүнс нь төрийн үйл ажиллагааг хязгаарлах замаар нийгмийн бүлэг болон хувь хүний үндсэн эрхийг хамгаалахад оршдог.⁴⁸ Энэхүү үзэл баримтлалыг иш үндэс болговол, иргэний эрх, эрх чөлөөнд төрөөс халдах, хязгаарлахаас хамгаалахыг **үндсэн эрхийн босоо** үйлчлэл гэнэ. Үүнээс үүдэн орчин үеийн үндсэн хуульт ёсны онолоор үндсэн хуулийн өөрчилж үл болох цом нь **ардчилал, эрх мэдэл хуваарилах зарчим, үндсэн эрх** байдаг. Эл зарчмыг анх 1814 оны Норвегийн Үндсэн хуульд: "Нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хуулийн язгуур үзэл санааг зөрчиж болохгүй"⁴⁹ хэмээн бэхжүүлсэн юм. Энэ нь Үндсэн хуулийн суурь бүтцийн онол (Basic Structure of The Constitution)-оор тайлбарлагдана.

Уг онол ёсоор үндсэн хуулийн үүсэл, хөгжлийн үндэс нь хүний эрхийн байдлаар тодорхойлогдож, үндсэн хуульд тусгагдсан иргэний эрх, эрх чөлөө төрийн бүх эрх мэдэлд хамаарч, тэдгээрт өөрийгөө үүрэг болгож, хооронд нь холбож өгч байдаг төдийгүй энэ институтын давуу байдлын зарчим нь бусад институтээ өөртөө нийцүүлэн захирах үндэс болж байгаа юм. Тиймээс үндсэн хуульт ёсонд тулгуурласан ардчилсан эрх зүйт төрийн үндсэн зорилго нь улс төрийн эрх мэдлийг хууль дээдлэх зарчимд нэгтгэж, төрийн бүхий л эрх мэдлийг үндсэн хуулийн шүүхийн хяналтад оруулах замаар иргэний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалахад чиглэдэг.⁵⁰

Үндсэн хуулийн хяналт бүхий дэлхийн улс орнуудад Үндсэн хуулинд заасан өөрийнх нь үндсэн эрх хууль тогтоох, гүйцэтгэх эсхүл шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэрээр зөрчигдөж байна хэмээн иргэн хүн үзвэл үндсэн хуулийн төвшинд сэргээлгэх эрхтэй байдаг. Түүгээр ч үл барам үндсэн эрхийг Үндсэн хуулийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үздэг тул иргэдийн гомдлоор маргаан үүсгэх хяналтын энэ институт

⁴⁷ Н.Лүндэндорж, Тор, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, УБ., 2002, Б.Чингэл, Үндсэн хуулийн үзэл баримтлал, УБ., 2004 оноос үнэ үү.

⁴⁸ John Hospers, What Libertarianism Is, 1974, Reading 5-1.

⁴⁹ F.A.Hayek, Law, Legislation and Liberty, vols. 1-3, Chicago, 1973-1979.

⁵⁰ Ю.Харбин, Орчин үеийн үндсэн хуульг төрийг тодорхойлох нь, ХБНГУ-ын Ханс-Зайделгийн сангийн 10 жилийн ойд зориулсан олон улсын симпозиумд тавьсан илтгэл.

⁵¹ Ч.Оюурбаяр, Үндсэн хуульд ёс буюу Үндсэн хуулийн шүүхийн тухай, Шинэ толь сэтгүүр, УБ., 2005

үндсэн хуулийн шүүх бүхий улс орнуудад нийт маргааны дунджаар 95 орчим хувийг эзэлдэг гэсэн тооцоо байдаг.⁵¹

Профессор Ц.Сарантуяа “Монгол улсад Үндсэн хуульд заасан цөөн тооны хяналтын объектоор Цэцэд хандах эрхтэй бөгөөд үндсэн эрх энэ объектод ордоггүй. Иймд Үндсэн хуулийн “Хүний эрх” бүлгийн хэрэгжилт бодит байдалд хамгаалалтгүй орхигджээ”⁵² хэмээн тэмдэглэсэн байна. Миний баримталж буй үзлээр Монгол улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг эрх зүйн хувьд хамгаалалтгүй орхигдсон мэт үзэх боломжгүй байна. Хэдийгээр энэхүү эрхүүдийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд⁵³ хяналтын объект болгон шууд зааж өгөөгүй боловч үндсэн хуульд ёсны онол, хууль зүйн техникээр нь дамжуулан тэдгээрийг цэцийн маргааны харьяалалд багтаах бүрэн боломжтой гэж үзэж байна. Энэ талаар дараахь хэдэн онолын үндэслэлийг дэвшүүлж байна. **Нэгд:** Үндсэн хуульд ёсны онолоор Үндсэн хуульд заагдсан иргэний үндсэн эрхүүд нь өөрөө хэрэгжих(self-executive) шинжтэй, шууд үйлчилдэг эрхүүд байдаг. Энэ нь үндсэн эрхийг хангахад зориулагдсан хэм хэмжээг хууль тогтоогчоос батлан гаргасан эсэхээс үл хамааран үндсэн хуулийн шүүхээс уг эрхүүдийг эрх зүйн эх сурвалж болгон хэрэглэх бүрэн боломжтой гэсэн үг. **Хоёрт:** Монгол улсын иргэн амь бие, эрх чөлөө, өмч хөрөнгөд нь төр түүний байгууллага, албан тушаалтнаас хууль бусаар халдсан тохиолдолд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх(due process of law) эрхтэй. Энэхүү эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д: Монгол улсын иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах,...шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” хэмээн баталгаажуулж өгсөн бөгөөд үндсэн эрх болохынх нь хувьд түүнийг хүндэтгэх нь төрийн бүх байгууллага, албан тушаалтны үүрэг байдаг. **Гуравт:** Монгол улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1-д зааснаар “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу

⁵¹ http://www.bundesverfassungsgericht.de/...Organisation/statistic_2001/A-III-1.html. Geschäftsfall und erledigung: Verfassungsbeschwerden: 97%, abstrakte und konkrete Normenkontroll-Verfahren: 0.73%, Organ-/Band-Länder-Streitigkeiten: 0.09%.

⁵² Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн процесс: суурь ойлголт, тулгамдсан асуудал. УБ., 2005

⁵³ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай. Монгол улсын хууль. 1997. 13 дугаар зүйл.

өөрийн санаачилгаар... хянан шийдвэрлэнэ” гэж заасан. Энэхүү диспозицноос харахад иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээлэлд үндэслэн маргаан үүсгэх эсэхийг Цэц өөрөө шийдвэрлэх бүрэн боломжтой. Тиймээс Монгол улсын Үндсэн хуулийн цэц иргэдээс ирүүлсэн өргөдөлд⁴ үндэслэн тэдний зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох бүрэн боломжтой юм.

ДҮГНЭЛТ: Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийн талаархи заалтууд нь эрх зүйт ёсны шаардлагыг хангаж байж гэмээнэ, тэдгээр нь зөрчигдөх явдлаас хараат бус шүүхээр хамгаалагдаж байж гэмээнэ, зөрчигдсөн тохиолдолд сэргээгдэх боломжтой байж гэмээнэ, энэ нь бүхэлдээ шууд хэрэгждэг, шууд үйлчилдэг эрх зүй болох юм. Үүний тулд:

- Монгол улсын Үндсэн хууль дахь хүний үндсэн эрхийн цэсээс өөрөө хэрэгжих шинжгүй(non self-executing) зарим эрхүүдийг хасах;
- Бусад үндсэн эрхүүдийг шүүхийн журмаар хамгаалахад ач холбогдолтой байдлаар ангилах;
- Үндсэн эрхийг хязгаарлах үндэслэлүүдийг үндсэн хуульд ёсны үзэл баримтлалд нийцүүлэх замаар илүү тодорхой болгох;
- Үндсэн хуулийн цэц үндсэн хуульд ёсны онол, хууль зүйн техникийг ашиглан монгол улсын иргэний үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд түүнийг сэргээдэг практик тогтоох нь нэн чухал байна. Ингэж байж гэмээнэ үндсэн хуульд ёс жинхэнэ утгаараа оршиж чадна.

⁴ Иргэдээс өөрийнх нь Үндсэн хуульд заасан “Үндсэн эрх” зөрчигдсөн тохиолдолд тул эрхээ сэргээгдэхээр өргөдөл, зарим Үндсэн хуульд заасан төр, түүний байгууллага, албан тушаалтнууд, тэдний гаргасан шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг тогтоолгохоор мэдээлэл гаргадаг.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

(харьцуулсан шинжилгээ)

*Хууль зүйн ухааны магистр, цагдаагийн хурандаа, Чингэлтэй
дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга Д.Батсайхан*

Эрх зүйн зохицуулалт гэж нийгмийн хөгжлийн шаардлагын дагуу нийгмийн харилцааг хөгжүүлэх, хамгаалах, зохицуулах, журамлах зорилгоор эрх зүйн арга хэрэгсэлүүдийн тусламжтайгаар хүмүүсийн зан үйл, нийгмийн харилцаанд нөлөөлж буй эрх зүйн хэм хэмжээний үйлчлэл мөн¹.

Эрх зүйн зохицуулалт нь нийтлэг болон нэг бүрчилсэн зохицуулалтын хоёр үндсэн хэлбэртэй байна. Нийтлэг зохицуулалт нь хэм хэмжээний зохицуулалт бөгөөд хууль, хуульчилсан акт бүтээж, мөрдүүлэх; харин нэг бүрчилсэн зохицуулалт нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх замаар, өөрөөр хэлбэл эрх зүйн хэм хэмжээ хэрэглэсэн акт гаргаж биелүүлэх замаар хэрэгжинэ.

Нэг талаас цагдаагийн байгууллага² нь хууль хэрэгжүүлэгч, хэрэглэгч субъект учраас өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн байгууллагын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгож энэ хүрээнд зохион байгуулагдаж, зорилт чиг үүргээ хэрэгжүүлнэ.

Цагдаагийн эрх зүйн үндсэн эх сурвалж нь цагдаагийн байгууллагын хуульд зааснаар: Үндсэн хууль, Цагдаагийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон

¹ Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ., 2004. 307 дэх тал.

² Полици гэснэг үг нь politia-төрийн зохион байгуулагдсан амьдрал гэсэн утгатай латин үгнээс гаралтай бөгөөд орчин үед нийгмийн хэл журмыг дэмжих, гэмт хэргийг тэмцэх мэргэжлийн байгууллагын нэр болжээ// Kobali и Balokovic-Krkles, 1995: 10.

улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө³.

Зарим хуульчдын үзэж байгаагаар өнөөдөр нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагааг зохицуулж байгаа Монгол Улсын хуулиуд 90 орчим байгааг тооцоолжээ⁴.

Нөгөө талаас цагдаагийн байгууллага нь хуулийг биелүүлэх зорилгоор холбогдох этгээдүүдээр дагаж мөрдүүлэхээр өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал, дүрэм, журам, заавар гаргаж мөрдүүлнэ. Энэ агуулгаар эрх зүйн хэм хэмжээг бүтээх субъект болно. Иймд цагдаагийн байгууллага нь эрх зүйг хэрэгжүүлэгч-эрх зүйг бүтээгч субъект мөн гэж тодорхойлж болно.

Эрх зүйн зохицуулалт нь бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, тухайн бүтцийн үйл ажиллагаа, эрх хэмжээ, чиг үүргийг журамлах хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Ийм учраас цагдаагийн байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг түүний хэлбэрийн талаас биш, харин бүтэц, үйл ажиллагааны талаас нь авч үзэх нь зүйтэй юм.

Бүтэц-чиг үүргийн арга нь нийгмийн үзэгдлийн бүхэл тогтолцоонд түүнийг бүрдүүлж байгаа аль нэг бүрдэл хэсгийн гүйцэтгэх үүргийг нээн харуулахад чиглэсэн функционализмын үндэслэлд тулгуурлана. Гэхдээ функционализм нь зөвхөн тогтолцооны доторх үзэгдлүүд хоорондын холбоо харилцааг тодорхойлдог гэдгийг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын цагдаагийн бүтэц зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо, чиг үүрэг, эрх хэмжээг Монгол Улсын хууль, тогтоомжоор зохицуулна.

Нэг. Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцооны эрх зүйн зохицуулалтын асуудал

Бүтэц, зохион байгуулалт гэдэг нь байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд зайлшгүй шаардлагатай байгаа хөдөлмөрийн

³ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүд, УБ., 1993. Дугаар 8.

⁴ Д.Яамдорж. Нийгмийн хэв журам хамгаалах, хэрэг зорилгаас урьтчилан сэргийлэх ажил иргэдийн оролцоог нэгтгэдгээр арга замтай // "Цагдаа" сэтгүүд, IV, 2006. 35 дэх тал.

хэмжээ, хувиарлалт, функциональ хэсэг, хөдөлмөрийн босоо хувиарлалт, удирдлагын түвшиний хоорондын эрэмбэ дэс дараатай, харилцан хамаарал мөн⁵.

Төрийн байгууллага бол хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хүрээнд бүрэн эрх эдэлж, хуульд заасан чиг үүрэг хэрэгжүүлдэг, нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалдаг, хуулиар бий болгосон, “зохиомол” тогтолцоо мөн⁶.

Цагдаагийн байгууллагын тухай Монгол Улсын хуульд зааснаар: “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн” гэж тодорхойлсон юм.

Бид одоо зарим улс орны цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг нарийвчлан авч үзье.

1.1. Оросын Холбооны Улсын Цагдан сэргийлэхийн⁷ тухай хуулийн 1 зүйлд зааснаар “цагдан сэргийлэх нь нийгэм, төрийн ашиг сонирхол, өмч, иргэдийн амь нас, эрүүд мэнд, эрх, эрх чөлөөг гэмт болон эрх зүйн бусад халдлагаас хамгаалах үүрэг бүхий, алдбадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй, төрийн гүйцэтгэх засаглалын байгууллагын тогтолцоо мөн” гэж тодорхойлжээ.

ОХУ-ын “Цагдан сэргийлэхийн тухай” хуулийн 1 зүйлд зааснаар цагдаа нь Дотоод хэргийн яамны тогтолцоонд багтана. ОХУ-ын Дотоод Хэргийн сайд нь ОХУ-ын бүхий л цагдаагийн байгууллагыг удирдлагаар хангана. Энэ хуулийн 7 зүйлд зааснаар ОХУ-ны сэргийлэх (шаашид нийтлэг жишгээр “цагдаа” гэж нэрлэх) нь эрүүгийн болон олон нийтийн аюулгүй байдлын цагдаа гэж ангилагдана.

Оөрийн үйл ажиллагааны хувьд цагдаа ОХУ-ын Дотоод хэргийн Сайдад захирагдах боловч, нийгмийн аюулгүй байдлын цагдаа нь ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын зохих байгууллагуудад давхар

⁵ Сонгодог жинхэнэ дээр удирдагчид суралцах нь. Удирдлагын академн. УБ., 2002. 385 дах тал.

⁶ Н.Лундзэдорж. Төрийн онол. УБ., 2005. 176 даях тал.

⁷ Милитши гэсэн нэр томъёо нь (miles, militis), -цэрэг гэсэн утгатай латин үгнээс гаралтай бөгөөд “хот тосгонд дэг журам тогтоох зорилго бүхий зэвсэглэсэн, тусгай бүлгийг” хэлнэ.

харьяалагдана.

Орон нутгийн засаг захиргааны мэдлээс гарч, зөвхөн босоо харьяалал, хяналтыг хадгалсан эрүүгийн цагдааг тусгаарлах үзэл санааг анх 1960-аад оны үед идэвхтэй хэлэлцэж байсан юм.

Цагдааг “холбооны” болон “орон нутгийн” гэж ангилах нь аажимдаа муниципал цагдаа бий болох урьдчилсан нөхцөл болох талтай. Зарим судлаачдын үзэж байгаагаар, нийгмийн дунд муниципал цагдааг дэмжих хандлага улам их болж байна.¹

Олон нийтийн засаглалын механизмыг бэхжүүлэх нь хүн амын амьдралын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд бүс нутгийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхтэй нягт холбоотой. Хэдийгээр муниципал цагдаагийн тухай үзэл санаа нь хэн бүхний талархлыг хүлээж байгаа боловч, улс төр, нийгэм-эдийн засгийн тогтвортой байдлын нөхцөлд л бүрэн хэмжээгээр хэрэгжих боломжтой юм. Үүнийг оросын хууль тогтоогчид ухамсарлаж байна. Цагдаа нь төрийн гүйцэтгэх засаглалын нэг хэсэг болж хадгалагдан үлдэх боловч, түүний “нийгмийн аюулгүй байдлын” (орон нутгийн) цагдаа гэсэн нэрээр нэгдсэн зарим хэсэг нь зөвхөн босоо захирагдаад зогсохгүй, мөн энэ цагдаагийн удирдлагуудыг томилж байгаа орон нутгийн засаг захиргаанд хэвтээ удирдагдана.

Нийгмийн аюулгүй байдлын цагдаагийн хоёрдмол нэр нь (орон нутгийн ба нийгмийн аюулгүй байдлын цагдаа) 1999 оны дөрөвдүгээр сараас өмнө зэрэгцэн оршиж байсан юм. Холбооны 1999 оны 3 дугаар сарын 31-ний хуулиар “орон нутгийн цагдаа” гэсэн нэр хасагдаж, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн өнөөгийн нэг бүтэц төрхөөр нийгмийн аюулгүй байдлын цагдаа гэж нэрлэгдсэн юм. Орон нутгийн, муниципал цагдаа байгуулах нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагад бүрэн шилжсэн үед л боломжтой бөгөөд энэ нь ирээдүйн хэрэг билээ.

Цагдааг эрүүгийн болон нийгмийн аюулгүй байдлын цагдаа гэж ангилах үндэс нь дараах шалгуурт үндэслэгдэж байгаа юм:

¹ Соловей Ю.П., Черныков В.В. Комментарий к Закону Российской Федерации «О милиции». Издание второе, переработанное и дополненное - М.: «Проспект», 2001.

- Шийдвэрлэх зорилтын хүрээ;
- Хэрэгжүүлж байгаа эрх хэмжээний багтаамж;
- Захирагдах, хянагдах байдал;
- Удирдах албан тушаалд томилох, болон чөлөөлөх журам;
- Санхүүжих болон хөрөнгөжих эх үүсвэр.

Хэдийгээр хууль тогтоомж эрүүгийн болон нийгмийн аюулгүй байдлын цагдааг ялгаж байгаа боловч, тэд дотоод хэргийн байгууллагын тогтолцоонд бие даасан хараат бус бүтэц бас биш юм. Энэ хоёр цагдаа нь цагдаагийн нэгдсэн аппаратын нэг хэсэг мөн. Эдгээр байгууллагууд нь хамтарч ажиллаж, цагдаагийн өмнө тавигдсан зорилтыг хамтарч шийдвэрлэх ёстой. “Эрүүгийн цагдаа гэсэн үг нь немешийн хууль зүйн бүтээлүүдэд өргөн хэрэглэгдэж байгаа «Die Kriminalpolizei» гэсэн нэр томъёоноос гаралтай. Эрх зүйчид немец хэлнээс орос хэлэнд орчуулахдаа зөвхөн үгчилсэн, хадмал орчуулгаар хязарлагдсан байна. Өөрөөр хэлбэл агуулгаар биш, зөвхөн хэлбэрээр бэхжсэн гэхэд болно. Зарим судлаачдын үзэж байгаагаар “ эрүүгийн цагдаагийн үгчилсэн тайлбар нь цагдаагийн өөр (эрх зүйн эсрэг) үйл ажиллагааг зааж” байна.

Ийм ч учраас хуулийн бүтээлүүдэд “эрүүгийн цагдаа” гэдгийг үгчилбэл, гэмт цагдаа гэсэн агуулга илэрхийлнэ гэж нэг бус удаа тэмдэглэгдсэн байдаг. Гэвч үгчилсэн болон хэлбэрийн (фигураль) тайлбараас гадна тэднийг ойлгох уламжлалт (заншсан); өөрөөр хэлбэл, түүх-улс төрийн тодорхой тохирооны явцад бүрэлдэн тогтож, үгийн эхний утгаас гажсан ойлголт гэж бий*.

Энд зөвхөн философийн биш, мөн ёс суртахууны асуудал яригдаж байгаа учраас энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд О.А.Галустян, А.П.Кизлык нар одоогийн эрүүгийн цагдаа гэсэн нэр томъёог “холбооны цагдаа” гэсэн нэр томъёогоор орлуулан ашиглахыг санал болгож байгаа юм. Үүтэй адил санал улс төрчдөөс цухалзаж байна. Жишээлбэл, 2002 онд Б.Грызлов (дотоод хэргийн сайд байхдаа) эрүүгийн сэргийлэхийн албыг Холбооны

* Волков М.П. Уголовно-процессуальная интерпретация результатов оперативно-розыскной деятельности: Монография / Под науч. ред. проф. В.Т. Томина. - Нижний Новгород: Нижегородская правовая академия, 2001.

цагдаа гэж нэрлэхийг санал болгож, “цагдаа гэсэн нэр томъёо нь одоогийн эрүүгийн цагдаагийн хийж байгаа чиг үүргийг гүйцэтгэж ирсэн түүхтэй юм гэж тэмдэглэж байжээ.

Гэхдээ зарим хүмүүс цагдааг холбооны болон орон нутгийн цагдаа гэж ангилах нь хууль зүйн зарим бүтээлд тэмдэглэснээр энэ хоёр цагдааг өөр хоронд нь сөргүүдэн тавьж, бус нутгийн хүмүүсийн дургүйцлийг хүргэх, сөргөөр хандах, сэтгэшийн хаалт тавих зэрэг сөргөлдөөний урьдчилсан нөхцлийг бүрдүүлж болзошгүй гэж үзэж байна. Тэд “эрүүгийн цагдаа гэсэн нэгэнт тогтсон нэр томъёо нь хууль зүйн талаас ч, ёс суртахууны талаас ч ямар нэгэн бодит зөрчил үүсгэхгүй учраас өөр нэрээр солих шаардлагагүй гэж үзэж болохоор байна.

Ийм учраас эрүүгийн цагдаа болон олон нийтийн аюулгүй байдлын цагдаагийн бүтцийг авч үзье.

Эрүүгийн цагдаагийн бүтцийг ОХУ-ын Засгийн газрын 2000 оны № 925 дугаар тогтоолоор (2001, 2002, 2003 онд нэмэлт өөрчлөлт орсон) батласан байна.

Энэ тогтоолын дагуу эрүүгийн цагдаагийн бүрэлдэхүүнд:

- Эрүүгийн эрэн сурвалжлах;
- Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх;
- Татварын гэмт хэрэгтэй тэмцэх;
- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх;
- Шуурхай эрлийн;
- Тусгай техникийн арга хэмжээний;
- Омчийн аюулгүй байдлын;
- Тусгай зориулалтын цагдаагийн отрядын;
- Шуурхай эрэн сурвалжлах мэдээллийн.

Эрүүгийн цагдаагийн бүрэлдэхүүнд мөн Интерполын үндэсний товччоо, түүний орон нутгийн хэсгүүд багтана.

Урд нь эрүүгийн цагдаагийн бүрэлдэхүүнд ОХУ-ын ДХЯ-ны дэргэдэх мансууруулах хэрэгсэл болон сэтгэцэд нөлөөлөх хууль бус эргэлттэй тэмцэх талаарх Улсын хороо (мансууруулах хэрэгсэл болон сэтгэцэд нөлөөлөх хууль бус эргэлттэй тэмцэх тасгууд) мөн орж байлаа. Түүний

хэсэг тасгууд ОХУ-ын субъектуудын ДХЯ, Ерөнхий газар, Газруудын дэргэд болон Дотоод хэргийн хөгуудын байгууллагуудын дэргэд ажиллаж байв. Орчин үед энэ хороо нь гүйцэтгэх эрх мэдлийн холбооны бие даасан байгууллага-Мансууруулах бодисын эргэлтэнд хяналт тавих Холбооны алба болон өөрчлөн (2004 онд ОХУ-ын Ерөнхийлөгчийн № 927 тоот зарлигаар батлагдсан Мансууруулах бодисын эргэлтэнд хяналт тавих Холбооны албаны дүрэм) байгуулагдсан юм. Урд нь өндөр технологийн салбар дахь гэмт хэрэгтэй тэмцэх салбар тусгаарласан юм. Гэвч ОХУ-ын Засгийн газрын "ОХУ-ын ДХЯ-ны үйл ажиллагааг зохицуулж байгаа ОХУ-ын ЗГ-ын зарим тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2001 оны № 558 тоот тогтоолоор энэхүү салбарын тухай хэсгийг хассан юм. Өндөр технологийн салбар дахь гэмт хэрэгтэй тэмцэх салбар татан буугдаж түүний бие бүрэлдэхүүн, бүтэц, материал техникийн хангамж Оросын ДХЯ-ны тусгай техникийн арга хэмжээний Удирдах газарт шилжсэн байна. Дээр дурдсан салбаруудыг байгуулах үндсэн дээр тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлийг мэргэшүүлэх зарчмын суурь тавигдсан юм.

Эрүүгийн цагдаагийн салбаруудын харилцан ажиллагааны журмыг ОХУ-ын дотоод хэргийн сайд тодорхойлно.

Нийгмийн аюулгүй байдлын цагдаагийн бүтэц, бүрэлдэхүүнийг ОХУ-ын Засгийн газрын 2000 оны " Нийгмийн аюулгүй байдлын цагдаагийн салбарын тухай " №926 тоот тогтоолоор (2001, 2005 онд нэмэлт өөрчлөлт оржээ) баталжээ.

Нийгмийн аюулгүй байдлын цагдаагийн бүрэлдэхүүнд:

- Жижүүрийн алба;
- Цагдаагийн хэсгийн төлөөлөгч;
- ОХУ-ын ДХЯ-ны замын хөдөлгөөний аюулгүй байдлын Төрийн хяналтын алба;
- Сэжигтэн, яллагдагчийн цагдан хорих байрууд;
- Захиргааны журмаар баривчлагдсан эдгээдийг байрлуулах зориулалттай хүлээн авах байр;
- Гуйлагчин, тэнүүлдчийг хүлээн авах, хувиарлах газар;
- Дотоод хэргийн байгууллагын харьяа эмнэлэгийн эрүүлжүүлэх

байр;

- Насанд хүрээгүй эрх зүй зөрчигчийг түр тусгаарлах төвүүд;
- Цагдаагийн тусгай зориулалтын (дайрагч хэсэг) отрядууд;
- Салбарууд;
- Дотоод хэргийн байгууллагуудын дэргэдэх хувийн хамгаалалтын

цагдаа;

- Хэрэг бүртгэх;
- Цагдаагийн эрүүл хамгаалалтын алба;
- Хувийн хамгаалалтын болон детектив албанд зөвшөөрөл олгох

болон хяналт тавих;

- Сэжигтэн, яллагдагчийг хамгаалах, хуяглан хүргэх;
- Насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх;
- Захиргааны хууль тогтоомжийг биелүүлэх болон хэрэглээний зах зээлийн хүрээн дэх эрх зүйн зөрчилтэй тэмцэх;
- Гадаадын улсуудын элчин, төлөөлөгчдийн хамгаалалт.

Эрүүгийн цагдаагийн үндсэн зорилт бол гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, урьдчилан мөрдөн байцаалт заавал явуулбал зохих хэрэгт урьдчилсан мөрдөн байцаалт явуулах; шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас оргон зайлсан буюу эрүүгийн ял шийтгэл эдлэхээс зайлсхийсэн, мөн ОХУ-ын хууль тогтоомжоор сураггүй алга болсон буюу бусад этгээдийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулахад оршино. Эрүүгийн цагдаа нь нийгмийн аюулгүй байдлын цагдаад ногдсон үүргээ биелүүлэхэд нь туслана.

Нийгмийн аюулгүй байдлын (орон нутгийн) цагдаагийн үндсэн зорилт бол хувийн аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, өмчийн хамгаалалт, гэмт хэрэг болон захиргааны зөрчлийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, урьдчилсан мөрдөн байцаалт заавал явуулах шаардлагагүй гэмт хэргийг илрүүлэх, зарим төрлийн этгээдүүдийг эрэн сурвалжлах, тэдний нийгмийн аюулгүй байдлын цагдаагийн эрх хэмжээнд хамаарагдах хэсгийн оршин байгаа хаягийг тодорхойлох явдал мөн.

Нийгмийн аюулгүй байдлын цагдаа нь эрүүгийн цагдаагаас оорийн

өмнө тавигдсан үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана ("Цагдаагийн тухай" хуулийн 9 зүйл).

Цагдааг дараах хоёр төрөлд ангилах нь дараах нөхцөл байдлуудаар тодорхойлогдож байгаа юм.

Нэгдүгээрт, иргэдийн эрх, эрх чөлөөний найдвартай хамгаалалтыг хангах, гэмт явдал байнга өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор төрийн нийтлэг ашиг сонирхолыг хангах шаардлага нь эрүүгийн хүнд гэмт хэрэг болон төрийн эрх мэдлийн байгууллагын албан тушаалтнуудаас үйлдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх, гүйцэтгэх ажил эрхэлж байгаа цагдаагийн салбар нэгжүүдийг удирдах төвлөрсөн удирдлагыг сайжруулах явдлыг зүй ёсоор шаардаж байна. Шинжээчдийн дүгнэж байгаагаар энэ асуудлаарх орон нутгийн нөлөөлөл нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүнээс хамгийн ноцтой гэмт хэрэгтэй хийх тэмцэлд сөргөөр нөлөөлж байгаа юм¹⁰.

Хоёрдугаарт, цагдаагийн байгууллагыг хүн амд ойртуулахын тулд түүний зарим хэсгийг орон нутгийн эрх мэдэлд шилжүүлж, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын шууд харьяалалд өгөх нь цагдаагийн ажилд орон нутгийн онцлог нөхцлийг цаг алдахгүйгээр тооцож, түүнийг зайлшгүй шаардлагатай өмч хөрөнгөөр хангах эн тэнцүү боломжийг олж авна¹¹.

1.2. Украин улсын цагдан сэргийлэхийн тухай хуульд зааснаар, цагдаа нь: "нийгэм төрийн ашиг сонирхол, байгаль орчин, өмч, иргэдийн амь нас, эрх, эрх чөлөөг эрх зүйн эсрэг халдлагаас хмгаалж байгаа төрийн гүйцэтгэх засаглалын зэвсэгт байгууллага мөн" гэж тодорхойлжээ.

Украин улсын цагдаагийн хувьд хяналт тавих, шийдвэр гаргах цэрэгжсэн дарангуйлалд үндэслэгдсэн зөвлөлт маягийн бүтэц, зохион байгуулалтын ул мөр одоог хүртэл арилаагүй байна¹².

1.3. Герман улсын цагдаагийн тухай хууль тогтоомжид зааснаар, цагдаагийн байгуулга гэж нийгмийн аюулгүй байдал болон эрх зүйн журамд учирсан аюул, заналхийллийг зайлуулах, түүнчлэн эрүүгийн ял шийтгэвэл зохих этгээдийг мөрдөн мөшгиж, урьдчилсан мөрдөн байцаалт явуулах

¹⁰Зубан А.В., Кокорев А.Н., Русакова Р.А. Основные направления деятельности милиции - М. Шит-М. - 2005. - с.8, 77.

¹¹ Кондратов Б.П., Соловей Ю.П., Черников В.В. Российский закон о милиции. М., 1992. С. 71.

¹² Алриан Бек, Алексей Поволоцкий, Александр Ярошич. Реформа милиции в Украине. // Материалы симпозиума «Реформа полиции в Центральной и Восточной Европе» Прага, 2002.

чиг үүрэг бүхий байгууллагыг хэлнэ.

Германы Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд зааснаар цагдаагийн байгууллага нь ерөнхийдөө Газруудын эрх хэмжээнд багтана¹³. Холбооны цагдаагийн тогтолцоонд Холбооны эрүүгийн цагдаагийн удирдах газар болон Холбооны хилийн хамгаалалт гэсэн хоёр гол байгууллага багтана. Мөн түүнчлэн эрүүгийн мөрдөн мөшгөлт явуулдаг холбооны бусад тусгай байгууллагууд, тухайлбал: эдмйн засгийн салбар дахь зөрчлийг мөрдөх гаалийн болон татварын албад; төмөр зам болон түүний зорчигчлод хор хохирол учруулсан эд хөрөнгийн гэмт хэргийг мөрдөх, Холбооны төмөр замын удирдах газрын хэлтэс; шуудангийн салбарт хамааралтай хэргийг мөрдөх, Холбооны немецийн шуудангийн үйлдвэрлэлийн аюулгүй байдлын алба; Холбооны парламентын алба багтана.

Харин дотоодын аюулгүй байдлыг муниципаль буюу орон нутгийн газруудын цагдаа, мөн эрүүгийн болон ус, эргийн хамгаалалтын цагдаа гүйцэтгэж байгаа юм¹⁴.

1.4. Чех улсын Цагдаа нь төрийг төлөвшүүлэх, нийгмийн амгалан тайван харилцааг нөхөн сэргээх, аливаа сөргөлдөөнийг тайван замаар шийдвэрлэх, улс төрийн амьдралаар дэмжигдэж байгаа нийгмийн тийм онцлог холбоог бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна¹⁵.

1990 оны сүүлчээр холбооны хурал Чех болон Словак улсуудад өөрсдийн цагдаагийн хүчнийг байгуулахыг зөвшөөрсөн боловч, цагдаагийн үйл ажиллагааг журамласан хууль зөвхөн 1991 онд батлагдсан юм. Энэхүү шинэ хуулиар гүйцэтгэх үүрэг нь ихээхэн хумигдсан цагдаагийн холбооны хүчинг холбооны дотоод хэргийн яамны дэргэд үлдээсэн байна.

Цагдаагийн гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалтын бүтцийг Цагдаагийн тухай 1991 оны хууль цоо шинээр тодорхойлсон байна. Сүүлийн 40 жилд анх удаа холбооны болон орон нутгийн цагдааг анх *ирэний байгууллага* гэж тунхаглажээ. Удирдлагын шатлалыг парламентаас томилогдсон цагдаагийн дарга, сайдад захирагдсан цагдаагийн шеф

¹³ Конституция зарубежных государств. М., 1996.

¹⁴ Х.-Ю. Кернер. Криминология. Словарь-справочник. М., 1998. 217-218 дахь тал

¹⁵ Лоадер и Волкер (Loader and Walker, 2001: 20)

байхаар тогтоосон байна.

Цагдаагийн тухай хууль нь цагдаагийн удирдлагын харьцангуй шинэ заалтуудыг агуулж байгаа юм. Удирдлага нэг бүрийн бүрэлдэхүүнд, эрүүгийн мөрдөн шалгах, эргүүл хамгаалалтын алба, замын цагдаа, олон нийтийн зүтгэлтнийг хамгаалах, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх салбарууд болон захиргааны аппарат орж байгаа юм.

Цагдаагийн үүрэг нь хөгжиж байгаа ардчилсан улсад түүний гүйцэтгэх шинэ үүргийг харгалзан нарийн тодорхойлогдсон юм. Энэ үүрэгт: хувийн болон өмч хамгаалах, гэмт явдлыг илрүүлэх, мөрдөх, нийгмийн хэв журмыг дэмжих, замын хөдөлгөөнийг удирдах, зайлшгүй шаардлагатай мэдээлэлтэй ажиллах зэргийг хамааруулжээ (Lundberg, 1993). Ахлах офицерүүдэд ямар нэгэн улс төрийн намын гишүүн байхыг хориглосон байна (Rosenberg, 1995).

Эдгээр шинэ хуулиуд нь батлан гаргах явцад цагдаагийн үйл ажиллагааг зохицуулах байнгын хууль тогтоомж батлагдах хүртэл түр хугацаагаар үйлчилэх зориулалттай байв. Гэвч 1992 оны 5 дугаар сард үндэсний шинэ үндсэн хууль батлагдах ёстой байсан боловч, 1993 онд Чехословак улс нь Чех ба Словак гэсэн хоёр бие даасан улс болон задрах хүртэл цагдаагийн шинэ хууль батлагдаж чадаагүй юм.

Эдгээр шинэ хуулиудад цагдаагийн болон шүүхийн байгууллагуудын хоорондын харилцааны асуудалд онцгой анхаарчээ. Оор нэг онцлог тал бол олон нийтийн жагсаал, цуглааны харилцаан дахь журмыг боловсруулах явдал байжээ. Жишээлбэл, цагдаа нь нийтийн жагсаал цуглааныг тараах ямар нэгэн арга хэмжээ авахаас өмнө орон нутгийн зөвлөлийн зөвшөөрлийг авах шаардлагатайг тодорхойлсон. Энэхүү нөхцөл байдал нь цагдаагийн удирдлагуудын эрх мэдлийг хязгаарлаж, цагдаагийн дураар авирлах магадлалыг багасгасан гэж хэлж болно. Цагдаагийн тухай хуулийн зарим заалтуудыг шүүмжлэх хандлага байсныг үгүйсгэхгүй. Жишээлбэл, цагдаагийн байгууллагын ажилтнуудын үйлдсэн хэрэг цэргийн шүүн таслах ажиллагаанд хамааралтай хэвээр үлдсэнийг дурдах хэрэгтэй. Энэ нь цагдааг иргэний институци гэж зарласантай зөрчилдөж байна гэж үзсэнтэй холбоотой юм.

Зарим ажиглагчид хуулийн энэ үндэслэл нь цагдааг засгийн газрын цээрлүүлэх байгууллага мэт ойлгогдохоор байна гэж үзсэн байна (Kolar, 2002).

1993 онд Чехословак улс задарч, Чех Улсын Үндсэн хууль батлагдсаны дараа цагдаагийн эрх зүйн үндэс бүрэлдэн тогтжээ. (Burianek, 1998). (Loader and Walker, 2001).

Оноодор ардчилсан цагдаагийн үйл ажиллагааны хамгийн оновчтой тодорхойлолтыг Хууль зүйн Үндэсний Институтын захиалгаар Бейли боловсруулсан байна. Олон улсын хэд хэдэн төсөлд (Marenin, 1996; United Nations High Commissioner, 1996; United Nations International Police Task Force, 1996) үндэслэн, Бейли ардчилсан цагдаагийн үйл ажиллагаанд туслах дөрвөн зарчмыг тодорхойлсон байна. Үүнд:

1. Цагдаагийн ажлын тэргүүлэх чиглэл бол тодорхой иргэний хэрэгцээнд болон нийгмийн бүлэгт үйлчлэх ёстой.
2. Цагдаа нь засгийн газарт биш, хуулийн өмнө ажлаа хариуцах ёстой
3. Цагдаа нь ардчилалын хамгийн нэг онцлог шинж болсон улс төрийн чөлөөт үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай хүний эрхийг хамгаалах ёстой.
4. Цагдаагийн бүхий л үйл ажиллагаа ил тод байх ёстой¹⁶.

1.5. Хорватын цагдаа нь Европын цагдаагийн бүтцийн хамгийн залуу нь бөгөөд Хорватын ДХЯ-ны бүрэлдэхүүнд багтана. Цагдаагийн шатлан захирагдах зохион байгуулалтын тогтолцоо нь (Police Law, 2000), пирамидын дээд хэсэгт-цагдаагийн дарга, түүний аппарат, дунд хэсэгт-цагдаагийн 20 газар, доод хэсэгт нь цагдаагийн 200 орчим хэсгээс тус тус бүрдэнэ.

Яамны аппаратын ажилтнууд нь тушаал гаргаж, цагдаагийн салбаруудын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд эрх зүйн дэг журмыг хангах арга хэмжээнд хааяа оролцоно.

Дунд хэсгийн удирдах ажилтнууд нь өөрийн хариуцаж буй бүсийн нөхцөл байдалд хяналт тавьж, цагдаагийн хэсгүүдийн үйл ажиллагааг

¹⁶ Дейвид А. Дженкс. Чехская полиция: привнесла принципы демократии. // Материалы симпозиума «Реформа полиции в Центральной и Восточной Европе». Прага., 2002 г.

зохион байгуулж.....(мөн түүнчлэн)...эрх зүйн журмыг хангах талаарх арга хэмжээнд шууд оролцоно¹⁷.

Цагдаагийн өдөр дутмын ажил нь цагдаагийн хэсгүүд дээр явагдах бөгөөд, тэдгээрийг үндсэн ба тусгай (жишээлбэл, нисэх буудлын цагдаагийн хэсэг, цагдаагийн авто-хяналт, хилийн хяналтын тасаг гэх зэрэг) гэж ангилна.

Оноо үед цагдаагийн албанд ойролцоогоор 20000 орон тооны ажилтан алба хааж байгаа бөгөөд 1000 иргэнд 4,28 офицер ногдож байна гэсэн үг.

Орчин үеийн Хорватын цагдаа нь богино боловч, оргилуун түүхтэй. Хорватын цагдаа нь арав гаруйхан жил оршин тогтнох хугацаандаа хамгаалах дайнд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, одоо ардчилалд хүрэх шилжилтийн замын дунд явж байна¹⁸.

Үүнээс үзэхэд орчин үед, цагдаагийн: цэрэгжсэн болон иргэншсэн, мөн холимог гэсэн гурван хэв маяг байгаа юм.

Төрийн тухай орчин үеийн хоёр зонхилох онол, баримтлалд (төрийг бэхжүүлэх болон түүнийг үгүйсгэх) энэ үзэл санаа гүнзгий туссан байдаг. Тухайлбал, орчин үеийн төрийг бэхжүүлэх үзэлтнүүд: "Төрт ёсны нэг гол чанар нь адбадлага мөн бөгөөд, олон нийтэд төрийн хуулийг сахин мөрдүүлэхийн тулд дүрэмт хувцас өмсч, зэр зэвсэг агссан хэн нэгнийг дайчлан хөдөлгөх туйлын чадавхид оршино"¹⁹ гэж үзэж байхад, либертари үзэлтнүүд: "Нийгэм дэх эмх журмыг хэн ч тулган хүлээлгэдэггүй, зорилгодоо хүрэхийн тулд бусадтай хамтран ажиллаж буй сая сая хүмүүсийн үйл ажиллагаанаас аяндаа гардаг зүйл гэж үзэх нь нийгмийн либертари задлан шинжилгээний нэгэн агуу ойлголт мөн"²⁰ гэж үзсэн байдаг.

Ийм учраас Монгол Улсын цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн асуудлыг эргэж харах нь зүйтэй байна. Монгол Улсын цагдаа нь гүйцэтгэж байгаа чиг үүргийн хувьд иргэншсэн хэв маягтай боловч бүтэц зохион байгуулалтын хувьд шууд цэрэгжсэн, хуучин

¹⁷ Kacetić, Z. 1994. *Ministarstvo unutarnjih poslova* (Ministry of the Interior). Zagreb, Croatia. 35.

¹⁸ Савж Кутник Икономет, *Особая и другие реформы полиции в Хорватии // Интервью симпозиума «Реформа полиции в Центральной и Восточной Европе»* Прага., 2002.

¹⁹ Францис Фукуяма, *Төрийг бэхжүүлэх нь: харин нэгдүгээр зууны эцэстэй ба дэлхийн дэг журм*. УБ., 2005. 8 дахь тал.

²⁰ Дэвид Боалз, *Либертарианизм*. УБ., 2005. 32 дахь тал.

хэв маягийг хэвээр хадгалсаар байна.

Монгол Улсын Цагдаагийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд: "Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. Цагдаагийн байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана. Цагдаагийн байгууллагын тогтолцоо нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа албад, аймаг, нийслэлийн харьяа албад болон аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/, сум, дүүргийн букоу сум, дүүрэг дундын цагдаагийн хэлтэс /тасаг, хэсэг/-ээс бүрдэнэ" гэж заажээ.

Хэдийгээр цагдаагийн байгууллага нь нэгдмэл төвлөрсөн удирдлагыг нутаг дэвсгэрийн удирдлагатай хослуулах удирдлагын зарчмыг тунхагласан боловч энэ хоёрын зааг ялгаа төдийлөн харагдахгүй байна.

Цагдаагийн тухай хуулийн 6 дугаар зүйлд нутгийн өороо удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагыг удирдах үүргийг нарийвчлан тодотгох шаардлагатай.

Мөн цэргийн цол, цэрэгжсэн сургалтаас татгалзаж иргэнших шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ийм учраас цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг шилжилтийн үеийн улс орнуудын алдаа оноо, хөгжилтэй орнуудын туршлагыг харгалзан өөрийн орны онцлогт тохируулан өөрчлөх, эрүүгийн болон орон нутгийн (иргэний) цагдаагийн тогтолцоонд шилжих шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Цагдаагийн төв байгууллага нь зөвхөн бодлогын шинжтэй асуудал болон боловсон хүчнийг сургах, дадлагажуулах, давтан сургах, энэ хоёр цагдаагийн ажлыг уялдуулах, стратеги удирдлагаар хангаж чадахаар зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Цагдаагийн цэрэгжсэн цолыг өөрчилж, цагдаа, түрүүч, дэслэгч, ахмад, комиссарын зэрэг дэвд шилжүүлж, тэдгээрийн эрх хэмжээ, чиг үүргийг нарийвчлан тогтоох хэрэгтэй байна.

Төрийн албаны тухай хуульд заасан ил тод байх; ард түмэнд үйлчлэх зарчмуудыг жинхэнэ ёсоор хэрэгжүүлж²¹, захиран тушаах, улс төржих, хүнд сурталт үйл ажиллагаанаас татгалзах нь зүйтэй байгаа юм.

²¹ Төрийн албаны тухай Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл сэтгүүд. УБ., 2002. Дугаар 1.

Хоёр. Цагдаагийн чиг үүрэг, эрх хэмжээний эрх зүйн зохицуулалтын асуудал

“Чиг үүрэг” /functio-биелүүлэх гэсэн утгатай латин гаралтай үг/ гэсэн нэр томъёо нь шинжлэх ухаанд /математикийн, биологийн, кибернетикийн гэх зэрэг/ янз бүрийн ойлголтоор хэрэглэгдэнэ. Харин хууль зүйн шинжлэх ухаанд бол эрх зүй ба төрийн нийгмийн зорилго, үйлчлэлийн шинжийг тодорхойлно²².

Төрийн чиг үүрэг нь хууль тогтоомж буюу гэрээний үүргээр тогтоогдсон үйл ажиллагааны хүрээ буюу тухайн төрийн мөн чанар, нийгмийн зорилгыг тодорхойлж байгаа үйл ажиллагааны үндсэн чиглэл юм.

Төрийн чиг үүрэг гэж нийгмийн амьдралын хүрээнд төрөөс заавал гүйцэтгэх ёстой эрх зүйн болон зохион байгуулалтын үйл ажиллагааны үндсэн чиглэл мөн.

Төрийн албаны тухай Монгол Улсын хуульд: “Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ. Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино” гэж заажээ.²³

Ийм учраас төрийн албаны мөн чанарыг тодорхойлох үндсэн шалгуур нь олон нийтийн сэтгэл ханамж мөн.

Оросын социологийн “Статус” төвийн судалгаанаас үзэхэд, “та гэмт хэрэгтэн ба цагдаагийн алинаас илүү айдаг вэ?” гэсэн асуулгад оролцсон москвачуудын 37% нь аль алинаас нь адилхан айдаг гэж хариулжээ. Харин 43% нь цагдаагийн ажилтнуудад ямар ч тохиолдолд хаалгаа тайлж өгөхгүй гэж хариулжээ²⁴.

Харин Монгол Улсад 2003 онд санал асуулгад оролцогчдын 37.6% нь хуулийнхны хүнд суртлаас, 20% нь хуулийнхан аюулгүй байдал, нууцлалыг

²² Ч.Нимсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол.УБ., 360-361 дэх тал.

²³ Төрийн албаны тухай Монгол Улсын хууль. УБ., 2002.

²⁴ См.: Скоксерев В. Кто же в России будет защищать граждан, а не государством // Известия.-1997. -5 апр. (64).-С.13.

хадгалж чадахгүй зэргээс болж, гэмт хэрэгт өртөгдөж хохирсон талаараа цагдаа болон хуулийн байгууллагад хандаагүй гэж хариулжээ²⁵.

Чех улсад Олон нийтийн санаа бодлыг судлах Институтээс 1990 онд явуулж, 1992 онд дахин шалгасан дүнгээс үзэхэд олон нийтийн зүгээс цагдаад итгэх итгэл хэдий бага ч гэсэн бага зэрэг өссөн үзүүдэлт гарсан байна. Цагдаад итгэдэг эсэх асуултанд 1992 онд асуулгад оролцогчдын 50 % нь итгэдэг гэж хариулсан 1990 оныхоос 30% нэмэгдэж, энэ хугацаанд цагдаад итгэдэггүй гэж хариулсан хүмүүс 60%-иас 35% хүртэл буурчээ (ИРО, 1992).

Оөр судалгаанаас үзэхэд цагдаад итгэх итгэл 1995 он хүртэл аажмаар өссөөр 1997 он хүрэхэд 70%-д хүрчээ. (Institute for the Investigation of Public Opinion, 1992; Burianek, 1998). Эдгээр асуулгын явцад цагдаагийн ажилд сэтгэл ханамжтай байгаагаа бага хотын оршин суугчид том хотуудынхаас илүүтэйгээр илэрхийлсэн байна. Үүнээс үзэхэд Чехийн цагдаагийн харилцаа эерэг чиглэлд явж байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна²⁶.

АНУ-д Шүүхийн тоо бүртгэлийн Товчоонд (Bureau of Justice Statistics) хүчирхийлэлд өртөгдсөн болон өмчийн гэмт хэргийн хохирогчийн тухай мэдээллийг харьцангуйгаар илүү илэрхийлэх боломжтой, гэр бүлийн ярилцлагад тулгуурласан "Гэмт хэрэгт Хохирох явдлын Үндэсний Судлал" (NCVS /National Crime Victimization Survey/) харьяалагдах болсон юм. Хүн амины гэмт хэргийн тухай мэдээллүүдийг мөн хүч хэрэглэсэн болон өмчийн гэмт хэргийн тухай тоо бүртгэлийг эрхэлж байгаа "Гэмт хэргийн тоо бүртгэлийн ижилтгэсэн систем"-ээс (UCR /Uniform Crime Reports/) авч байгаа юм.

NCVS нь цагдаагийн байгууллагад мэдээлэгдээгүй гэмт хэргийн 50 орчим хувийг илрүүлж UCR-т нэмэлт болгож бүртгүүлдэг байна²⁷. Ийм учраас UCR-т бүртгэсэн гэмт хэрэг 20 сая орчим байсан бол NCVS-ийн мэдээгээр 40 сая орчим хүрч өссөн байна. АНУ-д 1973-1995 онд жилд

²⁵Монгол Улс дэх хохирогчийн талаар хийсэн судалгааны ерөнхий санал, дүгнэлт /хураангуй/. Гэмт явдалтай тэмцэх асуудал. Цагдаагийн академ, 2003, №2, 13-р тал.

²⁶ Burianek, J. 1998. 'Democratization, crime, punishment and public attitudes in the Czech Republic'.

²⁷ Meadows, R. (2004). *Understanding Violence and Victimization*, 3e. Upper Saddle River, NJ: Prentice Hall.

дунджаар 40-50 сая хүндэвтэр /хүндхэн/ гэмт хэрэг NCVS-т бүртгэгдэлгүй үлдсэн гэсэн тооцоо гарсан байна. Харин 1995 оноос эхлэн энэ тоо багасч 2002 онд 23 сая хүрч буурчээ²⁸. (BJS 2003).

Гэр бүлийн ярилцлагаас үзэхэд хүмүүс цагдаагийн байгууллагад итгэдэггүй, гэмт хэргийн халдлагыг өөрсдөө таслан зогсоосон, эсхүл гэмт хэрэгтний дарамтаас айх зэрэг шалтгаанаар гэмт хэрэг үйлдэгдсэн тухай цагдаагийн байгууллагад хандаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн *Гучин гуравдугаар зүйл*-д зааснаар Монгол Улсын Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ²⁹.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар: "Засгийн газар нь хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах бүрэн эрхийн хүрээнд "Хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдээлэл, сургалт, хууль тогтоомж тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж,³⁰ 14 дүгээр зүйлд зааснаар: "Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээ авч хэрэгжүүлж, "Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ" авна.

Ийм ч учраас энэ хуульд зааснаар Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд нь цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлыг³¹ хариуцдаг.

Тэгвэл гадаадын зарим улс орнуудын цагдаагийн байгууллагын зорилт, чиг үүргийг авч үзье.

2.1. Оросын Холбооны Улсын Цагдан сэргийлэхийн зорилт (Цагдан сэргийлэхийн тухай хуулийн 2 зүйл) нь:

- Хувь хүний аюулгүй байдлыг хангах;
- Гэмт хэрэг болон захиргааны зөрчлийг урьдчилан сэргийлж, таслан

²⁸ Lab, S. P. (1997). *Crime Prevention: Approaches, Practices and Evaluations*. Third Edition. Cincinnati, OH. Anderson Publishing Company.

²⁹ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992. Дугаар 1.

³⁰ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүд. УБ., 1993. Дугаар 3.

³¹ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүд. УБ., 1993. Дугаар 3.

зөгсоох;

- Гэмт хэргийг ирлүүлэх, таслан зөгсоох;
- Олон нийтийн хэв журмыг хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг

хангах;

- Хувийн, төрийн, орон нутгийн болон өмчийн бусад хэлбэрийг хамгаалах;

• Хувь хүн, хуулийн этгээдэд энэ хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд гэднээс эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалахад нь туслах гэж тус тус заажээ.

2.2. Украин улсын цагдаагийн тухай хуульд:

- Нийгмийн хэв журмыг дэмжих;
- өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэг бүртгэлт, урьдчилсан мөрдөн

байцаалт явуулах;

- гэмт явдлаас урьдчилан сэргийлэх;
- төрийн, хамтын, хувийн өмчийг хамгаалах;
- галт зэвсэг олж авах зөвшөөрөл олгох;

• гэр оронгүй хүмүүсийн тусгай байгууллага болон халдварт өвчтэй эрх зүй зөрчигчийн тусгаарлах байрны үйл ажиллагааг хангах;

- хүн амын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих (паспортын хяналт болон гадаадын иргэдийг бүртгэх);

- замын хөдөлгөөнийг хангах;

- саяхан суллагдсан этгээдэд хяналт тавих гэх зэрэг үйл ажиллагааны чиглэл, зорилтыг тодорхойлжээ.

Украин Улсын 1996 оны Үндсэн хуулиар цагдаагийн байгууллагын ажиллах хэмжээ, хязгаарыг тогтоож өгсөн байна. Энэ хуулийн 3 дугаар зүйлд: хүн, түүний амь нас, эрүүл мэнд, алдар хүнд, халдашгүй болон аюулгүй байдал нь Украин улсад хамгийн үнэт зүйлс гэж тооцогдоно. Хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа нь төрийн үйл ажиллагааны агуулга, чиглэлийг тодорхойлно. Төр нь хүний өмнө өөрийн үйл ажиллагааг хариуцана. Хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах нь төрийн үндсэн үүрэг мөн гэж тунхаглажээ.

Шинэ үндсэн хуулийн дагуу Украин улсын ДХЯ-ны тогтолцооны

хөгжлийн Үзэл баримтлалыг боловсруулж, гүн гүнзгий өөрчлөлт хийхийн чухлыг (Ministry of Interior, 1996) тэмдэглэжээ. Хэдийгээр Украин улсын парламент дээр цагдаагийн өөрчлөлт шинэчлэлийн талаар янз бүрийн үзэл санаа байгаа боловч, зарим гол асуудлаар нэгдсэн шийдэлд хүрч чадсан байна. Үүнд:

1. цагдаагийн үйл ажиллагаа нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, мөн нийгэм, төрийн ашиг сонирхолыг эрх зүйн эсрэг халдлагаас хамгаалахад чиглэх;

2. ДХЯ-ны бүтэц аль болох энгийн, уян хатан, эдийн засгийн хувьд хэмнэлттэй байх;

3. орон нутгийн түвшинд ДХЯ-ны ажлын гол анхаарлыг төвлөрүүлэх;

4. ДХЯ-ны ажлын тухай мэдээлэл нийгэмд нээлттэй, ил тод байх;

5. Цагдаагийн бүх алба, салбарууд нь тэдний чиг үүргийн онцлогоос үл хамааран гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хангах зорилтыг шийдвэрлэхэд чиглүүлэхийг тэргүүлэх зорилт болгох;

6. Нийгмийн хэв журмыг дэмжих зорилгоор цагдаагаас орон нутгийн өөрөө удирдах байгууллагатай нягт хамтарч ажиллах зэрэг болно.

2.3. Монгол Улсын цагдаагийн байгууллагын чиг үүрэгт:

- Гэмт хэрэгтэй тэмцэх;
- Нийгмийн хэв журам хамгаалах;
- Хүмүүсийг эрэн сурвалжлах;
- Гүйцэтгэх ажил эрхлэх;
- Цагдан хорих, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх зэргийг хуульчилсан байна²².

Монгол Улсын Цагдаагийн төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- цагдаагийн байгууллагын ажлыг улсын хэмжээгээр нэгтгэн зохион байгуулж, харьяа албад, орон нутгийн цагдаагийн байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах;

²² Д.Таванжин, Монгол Улсын Цагдаагийн эрх зүй, УБ., 2006, 77 дээд тал.

- аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн орон нутгийн цагдаагийн байгууллагыг байгуулах, татан буулгах;
- цагдаагийн байгууллагыг зэвсэг техник, тусгай хэрэгсэл, хувцас, бусад материалаар хангах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;
- цагдаагийн байгууллагын боловсон хүчний бодлого боловсруулж, алба хаагчийг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;
- цагдаагийн алба хаагч, бусад ажиллагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах;
- цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн явуулах ажлыг зохион байгуулах;
- гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалахтай холбогдсон асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад мэдээлэл өгч, санал тавих;
- Монгол Улсын цагдаагийн байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах зэрэг.

Цагдан сэргийлэх байгууллагын бүх үүргийг өмнөх хууль тогтоомжид нэг зүйлд “нэрлэх” төдийгөөр нэг дор жагсаан байрлуулсныг өөрчилж, урд нь гүйцэтгэдэг байсан гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалахтай шууд холбоогүй зарим үүргээс чөлөөлж, Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж гарсан энэ хууль нь зөвхөн цагдаагийн байгууллагын тухай биш, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгалсан иргэний нийгмийн монгол цагдаагийн анхны хууль болон үйлчилж эхлэв³³.

Монгол Улсын хувьд цаашид цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн илрүүдэлтийн түвшинг ахиулах чиглэлээр мэдээллийн технологийн ололт амжилтыг ашиглах, мэдээллийн нэгдсэн сан, цагдаагийн байгууллага хоорондын

³³Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл. 1993 он. Дугаар 8.

интернетийн нэгдсэн сүлжээ байгуулах хэрэгтэй байна.

Түүнчлэн эрүүлжүүлэх ажиллагааг цагдаагаас тусгаарлаж хуулийн эмнэлэгийн байгууллагын дэргэд ажиллуулахаар эрүүлжүүлэх болон өөрчилсөн тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хангах бас нэг алхам болж болно.

Эцэст нь дүгнэхэд хэдийгээр цагдаагийн бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо, удирдлагын хэтийн зорилго, харьяалагдах механизм, байнга үйлчилж байгаа зааварчлага улс орон бүрд янз бүр, өөр хоорондоо ялгаатай боловч, бас харьцуулж болох гол үндсэн зарчим, ойлголтууд байгааг үгүйсгэж болохгүй юм. Үүнд: шударга ёс, тайлагнах ёс, ил тод байдал, дэг журамтай байх, тал тохиой татахгүй байх зэргийг хамааруулж болно. Ирээдүйн судалгаа шинжилгээ нь эдгээр адил төстэй ойлголтонд асуудал хандуулж, цагдаагаас өөрийн онцлогт тохируулан түгээмэл хэрэглэгдэх арга хэрэгсэл бүтээхэд оршино.⁴

⁴ Лейвал А. Дясвас. Чешская полиция: принятие принципов демократии. // Материалы симпозиума «Реформа полиции в Центральной и Восточной Европе», организованного при содействии Женевского центра демократического контроля за вооружёнными силами (ЦДКВС) в Праге, столице Чехии, 8-9 ноября 2002 г.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАТ

/“Олон улсын санхүүгийн түрээсийн тухай” Отгавын конвенц /

СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагын тэнхмийн багш Ж.Хулан

Лизинг гэж юу вэ? Эдийн засгийн үг хэллэгэнд энэ үг нь “to lease” гэсэн англи үгнээс гаралтай бөгөөд “түрээслэх” эсвэл “түрээсэлж авах” – ыг хэлдэг. Лизингийн үйл ажиллагааны үүсэл хөгжлийг 150 жилийн өмнөөс авч үздэг. 1877 онд утасны аппарат үйлдвэрлэдэг “Белл” компани нь бүтээгдэхүүнээ худалдаалахын оронд түрээсээр ашиглуулахаар шийдвэрлэсэн түүхтэй. Анх 1952 онд Америкийн Сан-Франциско хотын “Юнайтед стейтс лизинг корпорейшн” компани лизингийн үйл ажиллагааг байгууллагынхаа үндсэн чиглэл болгон ажилласан нь шинэ төрлийн бизнесийн эхлэлийг тавьсан түүхтэй.

Лизинг хөгжсөн Баруун Европ, АНУ, Япон зэрэг орнуудын туршлагаас харахад дараахь дүгнэлтийг хийж болно.

- Лизингийн үйл ажиллагааг зөвхөн арилжааны банкууд бус лизингээр мэргэшсэн компаниуд явуулах боломжтой.

- Лизингийн үйл ажиллагааны зах зээл хөгжих нь аж үйлдвэрийн салбарыг бэхжүүлэх, түүнд хөрөнгө оруулалт хийх, стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн салбарыг хурдацтай хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

- Лизингийн харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, энэ чиглэлийн бизнесийг хөхүүлэн дэмжих зорилгоор хууль тогтоомжинд татварын хөнгөлөлтүүдийг үзүүлдэг байна. /Жишээ нь ашгийн татвар, гаалийн татвар г.м./

Одоо лизингийн тухай ойлголтыг хэрхэн тодорхойлсныг авч үзье.

- Лизинг буюу санхүүгийн түрээс гэдэг нь “түрээслүүлэгч нь

түрээслэгчийн захиалгын дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг ашиглалтын явцад үндсэн шинж чанараа алдаггүй, үндсэн хөрөнгөд хамаарах биет эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх буюу гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх, эсхүл түүнээс худалдан авч гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, төлбөртэйгээр түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөхийг”...хэлнэ. гэж МУ-ын Иргэний хуулийн 3.1-д заасан байна.

- Лизинг гэдэг нь түр хугацаагаар сул байгаа, эдийн засгийн эргэлтэнд ороогүй санхүүгийн эх үүсвэрийг хөрөнгө оруулалтанд чиглүүлдэг бизнесийн үйл ажиллагааны нэг төрөл бөгөөд санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч гэрээнд заасан эд хөрөнгийг тодорхой худалдагчаас өмчлөлдөө худалдан авч, түрээслэгчид төлбөртэйгээр, түр хугацаагаар эзэмшил, ашиглалтад шилжүүлдэг юм.

- Европын холбооны тоног төхөөрөмжийг лизингээр ашиглуулах Үндэсний ассоциацийн (Leaseurope) тодорхойлсноор: “Лизингийн гэрээгээр түрээслүүлэгч нь үйлдвэр, аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах гэж байгаа үл хөдлөх хөрөнгийг худалдан авч түрээслэгчид шилжүүлдэг ба өмчлөх эрх нь түрээслүүлэгчид хадгалагддаг харилцаа юм” гэжээ.

Олон улсын практикт лизингийн олон төрлүүд байдаг.

(1) Үйл ажиллагааны лизинг, санхүүгийн лизинг.

Үйл ажиллагааны лизинг нь үл хэрэглэгдэх эд хөрөнгийг богино хугацаагаар түрээслүүлдэг. Гэрээний хугацаа нь 3-5 жил байх ба эд хөрөнгө нь түрээслэх явцад бүрэн элэгдэлд ордоггүй байна. Гэрээний хугацаа дуусахад эд хөрөнгийг дахин түрээслүүлдэг. Үйл ажиллагааны лизингийн үед гол төлөв барилгын техник (барилгын кран, экскаватор г.м.), тээврийн хэрэгсэл, компьютер тооцоолон бодох машин зэрэг гэрээний зүйл нь болно.

Санхүүгийн лизингийн онцлог нь гэрээг 5-10 жилийн хугацаатай байгуулдаг ба тоног төхөөрөмжийн дийлэнх хувь эсвэл бүхэлдээ элэгдэлд

ордог байна. Оороор хэлбэл, санхүүгийн лизинг нь урт хугацааны зээлээр худалдан авах гэрээний хэлбэртэй төстэй болж ирж байна. Гэрээний хугацаа дуусахад түрээслэгч гэрээний зүйлийг түрээслүүлэгчид буцаах, гэрээний хугацаагааг сунгаж шинээр гэрээ байгуулах, мөн элэгдэл хорогдлыг тооцож худалдан авдаг.

(2) Гэрээний зүйл болох эд хөрөнгийн шинжээр нь хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийн лизинг гэж ангилж болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн лизингийн үед түрээслүүлэгч нь түрээслэгчийн зааврын дагуу үл хөдлөх хөрөнгө шинээр барих эсвэл худалдан авч, түүнд бизнес эрхлэх зориудалтаар шилжүүлдэг.

Хөдлөх эд хөрөнгийн тухайд гэрээний хугацааг гэрээний зүйлийн бүрэн элэгдэлтэй тэнцэх эсвэл арай бага хугацаа тогтоож, түрээслэгч гэрээний хүчинтэй хугацаанд бүх эрсдэл, зардал, татварыг хариуцдаг.

(3) Буцах лизинг (lease-back).

Ийм төрлийн лизингийн гэрээгээр үйлдвэрийн газар өөрийн өмчлөлийн тодорхой хэсгийг лизингийн компанид худалдахдаа давхар энэ хэсгээ түрээсэлж авахаар тохиролцдог. Энэ гэрээнд зөвхөн хоёр оролцогч байна. Нэг тал нь түрээслэгч буюу хуучин үйлдвэрийн газар, нөгөө тал нь шинэ өмчлөгч буюу лизингийн компани. Энэ төрлийн хэлцэлд үйлдвэрийн газар нь худалдсан хэсгээ үргэлжлүүлэн түрээсэлж, ашигласнаар санхүүгийн чадвараа нэмэгдүүлэх боломжтой болдог. Мөн орлого багатай үйлдвэрийн газарт ашигтай юм.

(4) Санхүүгийн давхар түрээс буюу сублизинг (sub-lease).

Анх түрээсээр эд хөрөнгө авсан түрээслэгч түүнийг гуравдагч этгээдэд давхар түрээслэх үйл ажиллагааг хэлнэ.¹ Ингэхдээ анхны түрээслэгч болон түрээслүүлэгчийн хооронд байгуулсан түрээсийн гэрээ хүчинтэй хэвээр байна. Энэ гэрээгээр үндсэн түрээслүүлэгч давуу эрхээр түрүүлж төлбөрийг авах эрхтэй. Мөн давхар түрээслүүлэгч дампуурсан тохиолдолд

¹ Түрээслэгчийн гарын авлага 2005/10 /

түрээсийн төлбөр шууд үндсэн түрээслэгчид очно.

(5) Олон улсын харилцаанд хэрэглэгддэг лизингийн бас нэг төрөл бол “дабл дин” хэлцэл юм.

Энэ хэлцлийн агуулга нь хоёр ба түүнээс дээш тооны орнуудад татварын хөнгөлөлтийг ашиглах арга мэх юм. Жишээбэл, 1980-аад оны эхээр “дабл дин” хэлцлийг АНУ, Англи зэрэг орнууд хэрэгжүүлж байсан. Учир нь Английн хуулиар татварын хөнгөлөлтийг онгоц худалдан авсан өмчлөгч-түрээслүүлэгч эдэлнэ, харин АНУ-ын хуулиар түрээслүүлэгч зөвхөн эзэмшигч байх юм бол дээрх хөнгөлөлтийг эдэлдэг байжээ. Английн лизингийн компани онгоц худалдан авч, америкийн лизингийн компанид түрээслүүлж, тэрээр орон нутгийн нисэх онгоцны компаниудад давхар түрээслүүлж ашигтай ажилладаг байжээ. Энэ төрлийн хэлцэл нь Франц ба ХБНГУ, Франц ба АНУ, Япон ба АНУ хооронд гэх мэт хэрэгжих боломжтой байна.

6. Сүүлийн жилүүдэд техник, тоног төхөрөмж үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчид ба лизингийн компаниудын хооронд гэрээ хийх нь түгээмэл болсон. Энэ гэрээний дагуу үйлдвэрлэгч нь лизингийн компанийн нэрийн өмнөөс үйлчлүүлэгчиддээ өөрийн бүтээгдэхүүнийг лизингээр санхүүжүүлэх санал тавьдаг. Ингэснээр лизингийн компани нь үйлдвэрлэгчийн худалдааны сүлжээг ашиглах, харин үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлээ нэмэгдүүлэх ашигтай байдал үүсдэг байна. Энэ хэлцэл нь “худалдахад, борлуулахад туслах” буюу sales-aid гэсэн нэр авчээ.

1991 онд Монгол Улс Олон улсын санхүүгийн корпорац (IFC) – д гишүүнээр элссэн бөгөөд гишүүн орнуудад үзүүлдэг үйлчилгээг авч байна. Үүний нэг жишээ бол Монголд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг юм. Тус байгууллагаас Монголд лизинг хөгжүүлэх төслийг Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж байна.² Мөн энэ төслийн хүрээнд “Санхүүгийн түрээсийн тухай хууль”-ийг боловсруулж, УИХ-аар 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр батлан

² /Түрээслэгчийн гарын авлага, 2005/10 /

гаргасан юм. /Энэ хуулийг “Төрийн мэдээлэл” № 26, www.mongolialeasing.mn веб хуудаснаас үзэж болно/.

Оноо үед санхүүгийн түрээсийн зах зээл өргөжихийн хирээр компаниуд олон улсын бизнесийн харилцаанд оролцох нь зайлшгүй юм. Тийм ч учраас УНИДРУА (UNIDROIT-Rome International Institute for the Unification of Private Law) –аас 1988 оны 5-р сарын 28-нд батлан гаргасан “Олон улсын санхүүгийн түрээсийн тухай” конвенцийн тухай товч өгүүлье. Энэ конвенци нь 3 бүлэг 25 зүйлтэй, англи, франц хэлээр Канад улсад албан ёсоор нийтлэгдэн гарсан. Тийм ч учраас Оттавын конвенци гэж нэрлэгддэг байна.

I бүлэг нь Конвенцийн үйлчлэх хүрээ ба ерөнхий нөхцөл.

II бүлэг нь Талуудын эрх, үүрэг.

III бүлэг нь Төгсгөлийн хэсэг гэсэн нэртэй байна.

“Олон улсын санхүүгийн түрээсийн тухай” конвенцийн зорилго нь:

- Конвенцийн гишүүн орнууд нь техник, тоног төхөөрөмжийн санхүүгийн лизингийн ач холбогдлыг хүлээн зовшоорч, энэхүү харилцаанд хэрэглэгдэх эрх зүйн зөрчилдөөнийг арилгаснаар хэлцэл хийгч талуудын эрх тэгш байдлыг хангах,

- ОУ-ын санхүүгийн түрээсийг хүртээмжтэй болгох,

- Санхүүгийн түрээсийн гэрээ нь түрээсийн гэрээний институтийн нэг онцгой төрөл бөгөөд бие даасан гурван тал оролцдог харилцааг зохицуулах,

- ОУ-ын Иргэний эрх зүй ба Худалдааны эрх зүйн хүрээнд ОУ-ын санхүүгийн түрээсийн зохицуулалтыг ижилсгэсэн хэм хэмжээ, дүрэм бий болгохыг зорьсон болно.

Энэ конвенциор түрээслэгч нь түрээслүүлэгчтэй болон худалдагч буюу гуравдагч этгээдүүдийн хооронд санхүүгийн түрээсийн гэрээ байгуулагдана. Хэлбэрийн хувьд түрээслүүлэгч ба худалдагч нарын хооронд худалдах, худалдан авах гэрээ, харин түрээслүүлэгч ба түрээслэгч нар нь санхүүгийн түрээсийн гэрээ байгуулна.

Түрээслүүлэгч нь иж бүрэн тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн хэрэгсэл зэргийг түрээслэгчийн тавьсан шаардлагын дагуу, түүний ашиг сонирхолд

нийцүүлэн худалдан авах, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөхөөр тохиролцоно.

ОУ-ын санхүүгийн лизинг нь дараахь шинжүүдийг агуулсан байх ёстой:

(1) Түрээслэгч нь худалдагч ба тоног төхөөрөмжөө түрээслүүлэгчийн урьдын туршлага, санал бодлыг үл харгалзан сонгож авах,

(2) Түрээслүүлэгч тоног төхөөрөмжийг худалдан авахдаа санхүүгийн түрээсийн гэрээний тухай худалдагч буюу 3-дагч этгээдэд заавал мэдээлсэн байх,

(3) Түрээслэгчийн тогтмол төлөх түрээсийн төлбөр нь гэрээний зүйлийн үнийн элэгдэл хорогдлыг тооцсон байх.

Мөн тус конвенци нь давхар санхүүгийн түрээсийн гэрээ тус бүрт нэгэн адил хүчинтэй үйлчилнэ. Харин конвенци нь хувийн, гэр бүлийн болон ахуйн хэрэгцээгээ хангах зорилгоор түрээслэн авсан эд хөрөнгөд хамаарахгүй болно.

Конвенцийн хэрэглэх нөхцөл нь түрээслүүлэгч ба түрээслэгчийн хуулийн этгээд нь өөр өөр улсын нутаг дэвсгэрт оршин байхыг шаарддаг. Үүнд:

(1) Конвенцид нэгдэн орсон талуудын (түрээслүүлэгч, түрээслэгч, худалдагч) нутаг дэвсгэр дээр оршин буй хуулийн этгээдүүдийн хооронд хийгдсэн гэрээнд хэрэглэгдэж болно.

(2) Санхүүгийн түрээсийн гэрээ, худалдах худалдан авах гэрээ нь конвенцид нэгдэн орсон аль нэг орны хуулиар зохицуулагдаж байдаг. Өөрөөр хэлбэл, энэ конвенци нь олон улсын гэрээ болохын хувьд түүнд нэгдэж орсон улсын үндэсний хууль тогтоомжийн бүрэлдэхүүн хэсэг болдог.

Хэрэв гэрээнд оролцогч талууд нь хэд хэдэн улсад үйл ажиллагаагаа явуулдаг бол хуулийн этгээдийн харьяаллыг тогтооход тухайн гэрээний харилцаатай ба гэрээний үүргийн биелэлттэй "илүү нягт холбоотой" (lex causae) хуулийн этгээдийг ойлгоно.

Санхүүгийн түрээсийн гэрээний талууд, худалдах худалдан авах гэрээний талууд тус бүр ОУ-ын санхүүгийн түрээсийн конвенцийг

хэрэглэхгүй байхаар тохиролцсон тохиолдолд тус конвенци нь үйлчлэхгүй болно.

Оттавын конвенцид түрээслүүлэгч нь худалдан авсан эд хөрөнгийн талаар хариуцлага хүлээхгүй гэж заасан байна. Түрээслэгч нь тухайн эд хөрөнгийг өөрөө сонгосон учир түүний шинж чанарын талаар (чанар, иж бүрэн байдал гэх мэт) ямар нэгэн гомдол байвал түрээслүүлэгчид бус худалдагчид хандах ёстой. Гэхдээ дээрх заалт нь түрээслүүлэгчийг гэрээгээр хүлээсэн бусад үүргээс чөлөөллөө гэсэн үг биш юм. Хэрвээ түрээслүүлэгч эд хөрөнгийг хугацаандаа болон хугацаа хожимдож нийлүүлсэн, гэрээний нөхцөлийг зөрчсөн бол түрээслэгч тал: а) санхүүгийн түрээсээр нийлүүлэгдэх эд хөрөнгөөс татгалзах эсвэл гэрээг цуцлах, б) гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлтэл буюу зохих ёсны эд хөрөнгийг хүлээн авах хүртэл тогтмол хугацаанд төлөх ёстой төлбөрөө төлөхгүй байх эрхтэй.

Түрээслэгч тал нь тогтмол хугацаанд гэрээнд заасан төлбөрөө төлөх, тоног төхөөрөмжийг арчлан хамгаалах, ердийн элэгдлийг тооцож, хэвийн байдлаар гэрээнд заасны дагуу ашиглах үүрэгтэй.

Оттавын конвенциор шууд зохицуулаагүй асуудлыг олон улсын хувийн эрх зүйн нийтлэг зарчмын дагуу шийдвэрлэнэ. Харин конвенцид эд хөрөнгийн эрхийн талаар эдлэх эрхийн хувьд зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхээр тусгасан заалтууд конвенцийн 7-дугаар зүйлд байна.

- Санхүүгийн түрээсийн гэрээний зүйл нь газрын бүрдэл хэсэг эсвэл газрын дагалдах зүйл болсон эсэх талаар түрээслүүлэгч ба газар эзэмшигчийн хооронд үүссэн маргааныг тухайн газар байгаа орны хуулиар зохицуулахаар тусгасан байна.

- Түрээслэгчийн дампуурлын хэргийн үед түрээслүүлэгчийн эд хөрөнгийн эрхийг хадгалах талаар дараахь зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхээр заасан:

А. Бүртгэгдсэн усан онгоцны тухайд – усан онгоцны өмчлөгчийг бүртгэсэн орны хуулийг,

Б. “ОУ-ын иргэний агаарын тээврийн тухай” 1944 оны Чикагогийн конвенцийн дагуу бүртгэгдсэн агаарын хөлөг онгоцны тухайд – онгоцыг

бүртгүүлсэн орны хуулийг,

В. Нэг улсаас нөгөө улс руу шилжих боломжтой техник, тоног төхөөрөмжийн хувьд /агаарын хөлөг онгоцны хөдөлгүүр/ - түрээслэгчийн гол буюу үндсэн үйл ажиллагаагаа явуулж байгаа газрын хуулийг,

Г. Бусад техник, тоног төхөөрөмжийн тухайд – техник, тоног төхөөрөмж байгаа орны хуулийг хэрэглэхээр заасан байна.

Санхүүгийн түрээсийн гэрээний талууд Оттавын конвенцийг хэрэглэхгүй байхаар тохиролцож болно. Мөн гэрээний талууд конвенцийг хэрэглэхдээ дараахь заалтуудаас бусад тохиолдолд ишлэл авч болохыг зөвшөөрсөн байна. Үүнд: а) түрээслүүлэгч нь санаатайгаар эсвэл хайнга хандсаны улмаас эрхийн зөрчилтэй эд хөрөнгийг шилжүүлсэн, б) түрээслэгчийн буруутай үйлдлийн улмаас түрээслүүлэгч нь гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлүүлэх эрхтэй.

Манай улсын “Санхүүгийн түрээсийн тухай хууль” –ийн 20-дугаар зүйлд олон улсын санхүүгийн түрээсийн талаар : “ Түрээслэгч, түрээслүүлэгчийн аль нэг нь гадаад улсын хуулийн этгээд, тус улсад оршин суудаггүй гадаад улсын иргэн, гадаад улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Монгол Улсын иргэн байвал санхүүгийн түрээсийн гэрээг олон улсын санхүүгийн түрээсийн гэрээнд тооцно” гэж заасан байна.

Монгол улс нь “Санхүүгийн түрээсийн гэрээний тухай” Оттавын конвенцид нэгдэн орох нь бизнесийн байгууллагуудын гадаад түнштэй харилцах харилцаа, түүнтэй энэ төрлийн гэрээ байгуулахад асуудлыг хөнгөвчлөх ач холбогдолтой юм.

ADR БУЮУ МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА.



Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гэгүүн,
IGL төвийн өмгөөлөгч М.Алтан-Олзий

ADR гэдэг нь Alternative Dispute Resolution гэсэн үгийн товчлол бөгөөд “Шүүхээс гадуур маргааныг эцэслэн шийдвэрлэх” гэж орчуулж болно. Ерөнхийд нь ADR гэдгийг аливаа маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа гэж ойлгогддог.

ADR нь дэлхийд тэргүүлэгч улс орнуудад ихээхэн хөгжсөн, тухайн улс орны хууль, эрх зүйн тогтолцоонд бүрэн төлөвшсөн ажиллагаа байхын зэрэгцээ улам боловсронгуй болгож хөгжүүлэх талаар төрийн бодлого хэрэгжүүлж ажилладаг байна. Үүний тод жишээ болсон Япон дахь ADR-ын тухай товч хэлэхийг зорив.

Японд ADR-ыг доорхи гурван хэлбэрээр хэрэгжүүлж байна. Үүнд:

-шүүхийг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

-захиргааны байгууллагыг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

-хувийн болон олон нийтийн байгууллагыг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа.

Шүүхийг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь шүүхийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хийгддэг ба олон нийтэд танигдсан төрийн байгууллага хэрэгжүүлж байгаа гэдгээр нь олон нийт итгэж, хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхээр ихээхэн хэрэглэдэг хэлбэр болно. Энэ нь монголын шүүхийн практикт байдаг шүүх хурлаас өмнөх шатанд талуудын эвлэрлийг баталж, захирамж гаргахтэй төстэй боловч эвлэрүүлэх ажиллагаанд оролцож байгаа шүүгч-зуучлагчийн хувьд талуудыг эвлэрүүлэх тал дээр идэвтэй байр суурь баримталж хандлагаараа ялгаатай байх юм. Энэ ажиллагаа нь Японы шүүхийн тухай хуулиар зохицуулагдсан байдаг

юм байна. Ийм учраас одоогоор Монгол улсын шүүхийн практикт хэрэгжүүлэх боломж байхгүй юм.

Захиргааны байгууллагыг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь Японы засгийн газрын байгууллага болох Яам, агентлагууд дээрээ явагддаг бөгөөд мөн л салбарынхаа хуулиар зохицуулагддаг.

Хувийн болон олон нийтийн байгууллагыг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь тухайн хуулийн этгээд, олон нийтийн байгууллагыг түшиглэхээс гадна өмгөөлөгчийг, өмгөөлөх байгууллагыг түшиглэсэн хэлбэр Япон улсад нийтлэг байна. Жишээ нь: аж үйлдвэрийн салбар бүрт, олон нийтийн байгууллага, холбоодын дэргэдэх г.м. Үүний нэг томоохон хэлбэр нь Японы өмгөөлөх байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүд юм.

Япон улсад шүүхийн ADR, хувийн хэвшлийн ADR-ийг түлхүү хөгжүүлэх бодлого барьж байгаа юм байна. Энэ хоёр хэвшлийг өрсөлдөхүйц түвшинд зэрэгцүүлж хөгжүүлэхийн тулд ADR-ийн тухай хууль баталж 2007 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх гэж байна. Өөрөөр хэлбэл энэ хуулийн ач холбогдол нь хувийн хэвшлийн ADR-ийг төрийн зүгээс баталгаажуулж, хуулийн зохицуулалттай болгож шүүхийн ADR-тай зохих түвшинд өрсөлдөхүйц, олон нийт хүлээн зөвшөөрч хэрэглэх, итгэх боломжийг бий болгож байгаад оршиж байна. Энэ нь Япон дахь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа ажлын нэг юм байна.

ADR-ын давуу тал гэвэл:

- уян хатан, өөрөөр хэлбэл талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны аль ч үед зуучлалаас татгалзах, өөр зуучлагч сонгох, шүүх, арбитраж болон өөр зуучлах төвд хандах,
- талууд цаг, хугацаа хэмнэх
- мөнгө, санхүүгийн хувьд хэмнэлттэй байж, зардал бага гаргах боломжтой байх
- нууцыг хадгалах бүрэн боломжтой байх Ж: хувь хүний нууцлахыг хүссэн бүх нөхцөл байдлыг олон нийтэд задруулахгүй байх, компаний

бизнесийн нууцыг задруулахгүй байх, ерөөсөө тухайн маргааныг нууцлах гэх мэт. Харин шүүхийн ажиллагаа нь олон нийтэд ил байх зарчимд тулгуурладаг учраас нууцлал бол хязгаарлагдмал. Өөрөөр хэлбэл компанид хамааралтай маргаан олон нийтэд ил болвол компаний үйл ажиллагаанд шууд утгаараа нөлөөлөхгүй ч гэсэн тухайн компаний хувьцаа буурах, бизнесийн нэр хүнд унах гэх мэт эрсдэл тулгардаг байна.

- тухайн салбарын өндөр түвшинд мэргэшсэн хүн зуучлагчаар ажиллах боломжтой

- талуудын идэвхтэй байр суурь, санаачлагад тулгуурлах, ингэснээрээ эвлэрлийн үр дүн ямар нэг албадлагагүйгээр хэрэгжих боломжтой байх, талууд харилцан сэтгэл ханамжтай байх.

- талуудын ажил хэргийн эерэг харьцаа хэвээр хадгалагдан үлдэх боломжтой байх. Таагүй болсон, бие биеэ үл ойлгох болсон харьцааг эергээр сэргээх, хэвийн байдалд оруулах боломжтой байх

- талууд асуудлыг өөрсдөө хэлэлцэн шийдвэрлэх, өөрөөр хэлбэл өөрсдөө шийдэлд хүрэх, харин үүнд зуучлагч дэмжиж оролцох г.м.

Монгол улсын хувьд Монголын Өмгөөлөгчдийн Холбоог түшиглэж эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах төвүүдийг байгуулах, өмгөөлөгчдийг зохих сургалтанд хамруулж үүний үндсэн дээр ADR-ийг төлөвшүүлэх, хөгжүүлэх ихээхэн боломжтой юм.

ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ЭЧНЭЭ АНГИД ХИЙХ ЛЕКЦЫН АГУУЛГА

*ЖАЙКА-ийн Эрх зүйн шинэгэл туслалцаа
төслийн мэргэжилтэн Миха, Йэка*

1. Танилцуулга

Миний бие Японы Токио хотын Васэдагийн Их сургуулийн хуулийн ангийг дүүргэсэн өмгөөлөгч байна. Японд хуульчдын сонгон шалгаруулалтыг шүүгч, өмгөөлөгч, прокурор болох хүмүүс л өгнө. Хуулийн сургуульд үндсэн хууль, иргэн, эрүү, худалдаа, эрүү, иргэний байцаан шийтгэх хуулиуд, бусад хуулиас нэгийг сонгон шалгалт өгөх ба би олон улсын хувийн эрх зүйн чиглэлээр суралцаж төгссөн.

Японд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэх хувь харьцангуй бага буюу 3-4% байх тул ихэнх нь хэд хэдэн жил дараалан өгөх нь элбэг. Би гэхэд 3 жил дараалан шалгалт өгч байж тэнцэн, 2 жилийн дадлагажилтыг дуусгаад өмгөөлөгч болсон байх жишээтэй.

2. Япон дахь хуульчдын дадлагажилтын тухай

Дадлагыг дээд шүүхийнхээ харьяа судалгааны товд хийх ба 2 жилийн эхний 4 сар ба сүүлийн 4 сард танхимын сургалтад хамрагдаж хуулийг хэрэглэх арга барил, шүүх үйл ажиллагааны практикаас суралцана. Сургагч багш нар нь шүүгч, прокурор, өмгөөлөгчид байна. Үлдэх дадлагажилтын хугацаанд шүүхийн эрүү, иргэний тэнхим, прокурорын байгууллага, өмгөөлөгчдийн товчоод болон орон нутагт ажиллана.

3. Японы өмгөөлөгч ба өмгөөлөгчдийн холбоо

Онөөдрийн байдлаар Японд 30,000 гаруй өмгөөлөгчид үйл ажиллагаа явуулж байна. Намайг шалгалт өгч байх үед ойролцоогоор 700-аад хүмүүс шалгалтанд тэнцсэн ба үүнээс 200-аад нь шүүгч, прокурор үлдсэн 500-аад нь өмгөөлөгчид болж байлаа. Сүүлийн үед хуульчдийг бэлтгэх боловсролын тогтолцоонд өөрчлөлт орж хуульчдын тоог жил бүр 2000-3000 хүн болгон нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Хуульчдын сонгон шалгаруулалтад

тэнцэн өмгөөлөгч болсноороо өмгөөлөгчдийн холбоонд заавал бүртгүүлднэ. Японд өнөөдөр 50 гаруй бүс мужид өмгөөлөгчдийн холбоо үйл ажиллагаагаа явуулж байгаагын дээр орон нутаг бүр өмгөөлөгчдийн зөвлөлтэй. Өмгөөлөгчид өөрсдийнхөө ажиллаж байгаа орон нутгийн зөвлөлд бүртгүүлэхээс гадна Японы өмгөөлөгчдийн Нэгдсэн холбоонд давхар бүртгэл хийлгэнэ. Бүртгэл хийлгээгүй тохиолдолд өмгөөллийн эрх олгогдохгүй, шүүхийн үйл ажиллагаанд оролцох эрхгүй болно. Тухайн орон нутаг бүр өмгөөлөгчдийн зөвлөлтэй байх ба Токио хот гэхэд 3 зөвлөлтэй. Энэ нь Токиод 10,000 гаруй өмгөөлөгчид үйл ажиллагаа явуулж байгаагаар холбоотой юм. Нэг дор олон зөвлөлтэй байх нь үйлчлүүлэгчдэд төвөгтэй, зарлага ихтэй, үйл ажиллагаа нь саармагжина гэх шүүмжлэлүүд гарах нь байдаг. Японд хамгийн олон 5000 гишүүнтэй Токиогийн өмгөөлөгчдийн зөвлөл, хамгийн бага 30 гишүүнтэй орон нутгийн зөвлөл үйл ажиллагаагаа явуулж байна. Японы өмгөөлөгчид сар бүр нэгдсэн холбоондоо 200ам.долларын татвар, харьяалагддаг зөвлөлдөө 300-500ам.долларын татварыг төлөх ба холбоо, зөвлөлүүд нь өмгөөлөгчидтэйгөө шуудан, факсын маш сайн харилцаа холбоотой байж чаддаг.

Монголын өмгөөлөгчдийн холбоог өмгөөлөгчидтэйгөө харилцаа холбоо сайтай байлгахын тулд өмгөөлөгчдийн хаягийн лавлагааг ЖАЙКА-ийн Эрх зүйн шинэтгэл, туслалцаа төслийн санхүүжилтээр хэвлэн гаргаад байна.

4. Өмгөөлөгчдийн холбооны үйл ажиллагааны тухайд

(1) Өмгөөлөгчдийн бүртгэл, сахилгын шийтгэл

Японд жил бүр өмгөөлөгчдийн хаягийн лавлагааг хэвлэн бүх гишүүд болон шүүхүүдэд үнэ төлбөргүй тараана. Сахилгын шийтгэл оногдуулах эрх нь тухайн зөвлөлд байх ба шийдэж чадахгүй тохиолдолд нэгдсэн холбоондоо шилжүүлднэ. Тэндээс шүүхэд нэхэмжлэл гаргах нь нээлттэй. Сахилгын шийтгэл сануулах, үйл ажиллагааг зогсоох, холбооноос хасах, өмгөөлөх эрхийг хасах гэсэн төрлүүдтэй.

(2) Олон нийтэд зориулсан үйл ажиллагаа

Өмгөөлөгчдийн холбоо, зөвлөл нь олон нийтийг өмгөөлөгчтэй холбох

гол үүргийг гүйцэтгэнэ. Зөвлөлөөс олон нийтэд хандан хууль зүйн зөвлөгөөг төлбөртэй болон төлбөргүй явуулах, шүүхэд төлөөлөл хэрэгтэй хүмүүст зуучлах, төлбөргүй үйлчилгээ явуулсан тохиолдолд өмгөөлөгчиддөө урамшуулал олгох, төлбөртэй үйлчилгээг тарифын дагуу харилцан тохиролцоо, шинээр гарсан хууль тогтоомжуудыг сурталчилах, нийгэмд үүсэж байгаа асуудлуудтай холбогдуулан эрдэмтэн судлаачдыг олон нийттэй уулзуулах, шүүхтэй хамтран шүүхийн үйл ажиллагааг танилцуулах нээлттэй өдөрлөг зохион байгуулах зэргээр ажиллана.

Мөн өмгөөлөгчдийн холбооны дэргэд хэрэг маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн-зуучлах төв үйл ажиллагаа явуулна. Шүүхээс ялгаатай нь маргалдагч талуудын яриаг сайтар сонссоноор эвлэрүүлэн-зуучлах явдал юм. Энэ тухай дараа тодорхой өгүүлье.

(3) Судалгаа ба сургалт

Өмгөөлөгчдийн холбоо нь дотроо хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хороо, эрүүгийн, насанд хүрээгүй хүүхдийн хэрэгтэй ажиллах хороо, байгаль орчны асуудал хариуцсан хороо, жендэрийн асуудал хариуцсан хороо, бүлэглэлийн гэмт хэрэгтэй тэмцэх хороод г.м байх ба тухайн салбараараа сургалт, судалгааны ажил хийнэ. Жишээ нь, аливаа нэг үйлдвэр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас болж хэрэглэгчид хохирох тохиолдолд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хороо эсвэл байгаль хамгаалах хорооноос хохирогчдыг зохион байгуулан шүүхдэх тохиолдол ч байдаг. Тухайн хороод маань шүүх, прокурор, цагдаагын байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажлыг мөн хийдэг.

(4) Бодлогын чанартай төсөл боловсруулах

Хуулинд өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах үед дээрхи өмгөөлөгчдийн холбоо, зөвлөл дэх хороодын гишүүд өөрсдийнхөө саналыг боловсруулан өргөн барина. Тухайн хуулийн өөрчлөлттэй холбогдуулж асуудлыг өөрийн биеэрээ мэдэрсэн өмгөөлөгчдийн туршлагыг ихэд хүндэтгэн авч үздэг. Японд эрх зүйн шинэтгэл явагдаж байгаатай холбогдон хуулийн шинэчлэлт, өөрчлөлтөд өмгөөлөгчдийн саналыг ихээхэн хүлээн авч байна.

(5) Хүний нөөцийн асуудал

Шинэ өмгөөлөгчдийг ахмад туршлагатай өмгөөлөгчдөд дагалдуулан хууль зүйн зөвлөгөөнд оролцуулах, эрүүгийн хэргийн үнэ төлбөргүй зөвлөгөөнд оролцуулах зэргээр дадлагажуулна.

5. Эвлэрүүлэл-зуучлалын тогтолцоо

(1) Япон улсад энэхүү тогтолцоо нь нилээд өндөр хэмжээнд хөгжсөн.

(2) Эвлэрүүлэл-зуучлал нь зохигч талуудын маргаан дунд орж шудрага байр сууринаас талуудын яриаг сонсох аргаар шийдвэрлэх явдал юм. Шүүхэд аль нэг тал ялдаг бол зуучлалд талууд харилцан ярилцсанаараа ойлголцолд хүрч, хоёулаа сэтгэл ханамжтай үлддэгээрээ онцлог.

Монголд шүүхэд хэрэг маргааныг хялбаршуулсан аргаар шийдвэрлэх явдал хөдөө орон нутагт ихээхэн байдаг байна. Японд ихэнхдээ шүүхээс илүүгээр юуны түрүүнд эвлэрүүлэл-зуучлалын төвд хандах нь элбэг.

(3) Эвлэрүүлэл-зуучлал явагдах хэргийн төрлүүд

Харилцан ярилцсанаар шийдэлд хүрч болохуйц доорхи жишээг үзнэ үү. Эгч дүү хоёр явж байтал эгч нь эхлээд хардаа тэнд нэг жүрж байна гэжээ. Дүү нь харин очоод авсан байна. Энэ жүрж хэнийх болох дээр маргалдаж гэнэ. Хэрэв, энэ хэргийг шүүхэд олон талаас нь авч үзсэний үндсэн дээр эхэлж харснаараа эгч нь авна гэх эсвэл гар хүрч авсанаараа дүү нь авна гэж шийдэх байх. Шүүхэд хэнийх нь эрх ихээр хөндөгдөж байна түүн дээр тулгуурлан мэтгэлзэнэ. Харин эвлэрүүлэл-зуучлалд хэрхэн шийдэх бол. Юуны түрүүнд зуучлагч маань талуудын яриаг сайтар сонсоод эгч нь жүржийн доторхи жимсээр шүүс хийх хүсэлтэйг, дүү нь гадна хальсаар чанамал хийх хүсэлтэйг мэдэж чадсанаар талуудыг сэтгэл ханамжтай үлдээж шийдвэрлэнэ.

Жишээ нь, Б-ийн эзэмшлийн байрны 3-р давхарт А-сарын 200 ам.доллараар өрөө түрээслэдэг. 4-р давхарт С- байр түрээслэдэг. Гэтэл, 4-р давхраас ус алдан эд хогшилд нь хохирол учруулсан тохиолдолд А-нь хэнд хандан гомдол гаргах вэ. Энэ тохиолдолд олон аргаар авч үзэж болох ба ус алдсан нь С-ийн буруутай үйл ажиллагааных уу, барилгын баригдсан чанартай холбоотой юу, С болон Б-ээр эд хөгшлийнхоо төлбөрийг гаргуулахаар зогсохгүй Б-ээр засвар хийлгүүлэх үү, эсвэл бүр байрнаас

нүүх нүүдэл суудлын төлбөр ч нэхэмжлэх г.м. Энэхүү маргалдагч 3 хүний дунд эвлүүрэн-зуучлагч орвол нилээд хамгийн боломжтой шийдвэр гаргана.

(4) Эвлэрүүлэл-зуучлалын давуу тал (сэтгэл ханамж-түргэн шуурхай-хямд-хаалттай-нууц хадгалах явдал)

Нэг талд шийдвэр гарахгүй, зохигч талууд хоёулаа сэтгэл ханамжтай үлдэх, цаг хугацаа алдахгүйгээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх бүрэн боломжтой. Шүүхэд бол 1 сараас 2 жил хүртэл хугацаа зарцуулах нь элбэг байдаг. Мөн зуучлал хямд зардалтай. Учир нь шүүхэд бичиг баримтын бүрдүүлэлт, өмгөөлөгчийн хөлс зэрэгт зардал их гардаг бол зуучлалд заавал өмгөөлөгч авах шаардлагагүйгээр харилцан ярилцсаны үндсэн дээр зуучлагчаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэн нэг л удаа төлбөр төлөхөд хангалттай. Шүүх нь үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцоор хүлээн зөвшөөрөгдсөн эрхээрээ нээлттэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Энэ нь төрийн эрх мэдлээр шудрага зөв шүүх ажиллагааг явуулж чадаж байгаа эсэхэд хяналттай байх үүднээсээ тун чухал хэрэг. Харин гэр бүл, хуулийн этгээдэд үзүүлэх итгэлтэй холбогдох хэрэг маргаанд зохигчид хаалттайгаар үйл ажиллагаа явуулах хүсэл сонирхолтой байдаг тул үүнд эвлэрүүлэл-зуучлал хамгийн тохиромжтой байдаг байна. Зуучлалд тухайн мэргэжлийн зуучлагч ажиллах, түүнийг талууд сонгох давуу талтай байдаг. Жишээ нь, эмч-зуучлагч, архитектор-зуучлагч г.м

Японд эвлэрүүлэл-зуучлалын тогтолцоог 3 хуваан үзэж болно.

а/ Хөнгөн хэргийн шүүх дэх эвлэрүүлэл-зуучлалын төв. Шүүхэд хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхээс илүүтэйгээр зуучлалд хандах нь элбэг. Зуучлагч 2 хүн байх ба тэд өмгөөлөгч, шүүгч байсан хуульчидаас гадна их сургуулийн багш, эмч зэрэг туршлагатай хүмүүс байна. Шүүхийн дэргэдэх зуучлалын төв учраас шүүхэд хандахтай адил хандах ба эцсийн дүнд харилцан ярилцсаны үндсэн дээр талууд шийдвэр гаргана. Шүүгч түүнд нь хяналт тавина.

б/ Гэр бүлийн шүүх дэх эвлэрүүлэл-зуучлалын үйл явц гэж байна. Гэр бүлийн хэрэг маргаанд шүүхэд орохоос өмнө заавал зуучлалд орсон байх үүрэгтэй. Ингээд харилцан ярилцаад шийдэлд хүрч чадаагүй тохиолдолд гэр бүлийн шүүгч шийдвэр гаргана. Зөвхөн гэр бүл салах асуудлаар бус

хүүхдийн боловсролд зориулах хөрөнгийг хэн нь хариуцах, эд хөрөнгийг хэрхэн хувиарлах зэрэг олон олон асуудлуудыг шийддэг. Гэр бүлийн шүүх дэх зуучлагч нь эрэгтэй, эмэгтэй 2 хүн байна.

в/ өмгөөлөгчийн холбооны дэргэдэх зуулалын төв. Тухайн орон нутгийн өмгөөллийн холбоодод байх ба эрх зүйн зөвлөгөө авахаар ирэх үед, харилцан ярилцан хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтэй байгаа хүмүүст зуучлалыг явуулна.

(5) Өмгөөлөгч ба эвлэрүүлэл-зуучлал

Өмгөөлөгчид холбооныхоо дэргэдэх зуучлалын төв болон шүүхийн зуучлалын төвүүдэд зохигч талуудын дунд төвийг баримтлан үйл ажиллагаагаа явуулна. Харамсалтай нь Монголд зохигч талууддаа зэрэг үйлчлэн хоёулангаас нь хөлс авах тохиолдол байдаг байна. Энэ нь ёс зүйн маш том алдаа бөгөөд үйлчлүүлэгчдийн итгэлийг, өөрсдийнхөө байр суурийг алдаж байгаа хэрэг юм. Мэдээж өмгөөлөгч хүн өөрийнхөө үйлчлүүлэгчийн төлөө ажиллах ч шудрага байр сууриас хандах ёстой. Үйлчлүүлэгч нь шудрага бус үйлдэл хийвэл түүнд ойлгуулах, талуудтай харилцан ярилцсанаар хэрэг маргааныг шийдвэрлэх туршлага сууна. Энэ мэтчилэн өмгөөлөгч хүнд байх онцлог ёс зүйн талаар манай төслийн хүрээнд Японы мэргэжилтэн багш нарыг урьж сургалт, семинар зохион байгуулсаар ирсэн ба ирэх жилүүдэд ч үргэлжлүүлэн явуулах болно.

Өмгөөлөгч нь зуучлалд хандаж байгаа үйлчлүүлэгчийнхээ төлөөлөл болохоос гадна нөгөө талынх нь төлөөлөл эсвэл зуучлагч ч болж болно. Нилээд төвөгтэй хэрэг маргаанд бүх төлөөлөл, зуучлагч нар хамтран ярилцсанаар маш зөв шийдэлд хүрэх нь бий.

6 ДҮГНЭЛТ

Нийгмийг өөрчлөх хүч нь өмгөөлөгчдөд байдаг юм шүү. Мэдээж шүүгчид, прокуроруудын үүрэг хариуцлага чухал ч олон нийттэй хамгийн ойр байж тэдний дуу хоолойг төлөөлж байдаг нь өмгөөлөгчид юм.

Та бүхэнд амжилт хүсье.

ШИХИХУТУГААР ОВОГЛОСОН ЭРДМИЙН ӨРГӨӨ 15 ЖИЛИЙН ОЙН БАЯРАА ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ТЭМДЭГЛЭВ

Манай хамт олон Монгол Улсын Шинжлэх ухаан, боловсролын сайдын зөвлөлийн /хуучин нэрээр/ 1991 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрээр сургалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсанаас хойш 15 дахь жилтэйгээ золгоод байна.

Шихихутуг ХЗДС-ийн 15 жилийн ой Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээтэй давхцаж байсан нь түүхээ үнэлэн, уламжлан шинэтгэдэг ёсон нэгэн байгууллагаас нэгэн улс гүрэн хүртэл үелэн тогтсоны илрэл бас нөгөөтэйгүүр ахин давтагдашгүй их тохиол, бахархам үйл явдал боллоо.

Эрдэмтэн багш нарын эрдмийн хур, оюутан залуусын сэтгэлийн хур буусан ойн баярын өдрүүдийг Шихихутугчууд ажлын их амжилт, бүтээлээр угтан, алдаа оноогоо дэнслэн өнгөрүүлэв.

Ойн арга хэмжээний үеэр зорилго нэгт, ой чацуу хувийн их, дээд сургуулиудтайгаа хамтран баярын хурал, оюутнуудын урлагийн тоглолт зохион байгуулсан бөгөөд энэ арга хэмжээнд Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр оролцож хүндэтгэл үзүүлэн боловсролын салбарт хувийн их, дээд сургуулиудын оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлсэн юм.

Ойн арга хэмжээ нь дараах онцлог үйл явдлаар дүүрэн байлаа.

- 15 жилийн ойн өмнөхөн сургууль хоёр дахь удаагийн ахисан түвшний магадлан итгэмжлэлд амжилттай шалгарсан нь хамт олон төдийгүй, хамтран ажиллагч байгууллага, оюутан суралцагчдын хувьд тэдний нэр их хөдөлмөр, хичээл зүтгэлийг үнэлэн итгэмжилсэн хэрэг болов.

- Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээнд зориулсан “Их Монгол-800” санд байгууллагаараа хандив өргөв.

- “МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ОРЧИН ҮЕ” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан нь энэ ойд зориулсан “Хамгийн шилдэг” арга хэмжээгээр шалгарав. Тус хуралд гадаад, дотоодын олон эрдэмтэн судлаачид илтгэл тавьсаны дотор

Эрхүүгийн Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн факультетийн декан, доктор /Ph/, О.М.Толстикова, Овөр Монголын Их сургуулийн багш, доктор /Ph/, дэд профессор О.Хайтан, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ю.П.Гармаев, Эрхүүгийн УИС-ийн Хууль зүйн сургуулийн иргэний эрх зүйн тэнхмийн багш, А.Ю.Каткова, Хууль зүйн ухааны доктор /Ph/ А.Т.Тумурова нар сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлэв.

- Монголын төр, хууль цаазын сэцэн билигт зүтгэлтэн Шихихутугийн амьдрал, үйл ажиллагаа, түүнчлэн Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн амьдралыг өнгөрсөн, эдүгээ, ирээдүй гурван цагийн хэлхээ холбоонд өгүүлсэн “Шихихутугаар овоглосон эрдмийн өргөө” эмхтгэлийг ойн арга хэмжээнд зориулан олны хүртээл болголоо.

- Хувийн их, дээд сургууль үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээнд зориулсан сагсан бөмбөгийн тэмцээнд манай сургуулийн оюутнууд амжилттай оролцон шагналт байрт шалгаран спортын авъяастай болохоо харууллаа.

- Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой, Шихихутуг Хууль зүйн дээд сургууль байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан манай сургуулийн хамт олны ажил хөдөлмөрийг төр засгаас өндрөөр үнэлсний дотор тус сургуулийг үүсгэн байгуулагч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан Монгол Улсын гавъяат хуульч цол хүртэн, тус сургуулийн багш, дэд профессор Г.Уламбаяр, нягтлан бодогч И.Дугарсүрэн нар Алтан гадас одонгоор энгэрээ мялаав. Мөн Сургалтын албаны дарга, магистр багш Д.Отгонтуяа, докторант багш Ч.Нямсүрэн нар Боловсролын тэргүүний ажилтан цол, тэмдгээр, магистр багш Г.Амаржаргалан Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны “Хүндэт жуух бичиг” -ээр тус тус шагнагдав.

Шихихутугаар овоглосон эрдмийн өргөө ийнхүү арвин баялаг түүхийн хуудсаа нэмэн зузаатгасаар явна.

Бэлтгэсэн: Г.Амаржаргалан

О.АМАРХҮҮ ХҮНДЭТГЭЛИЙН ЛЕКЦ УНШИВ

Шихихутуг ХЗДС-ийн Төр, эрх зүйн тэнхмийн эрхлэгч, хууль зүйн



шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Осорын Амархүү “Монголын байгаль-хойч үе” (өнгөрсөн, өдгөө ирээдүй) сэдвээр 2007 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Хууль зүйн үндэсний төвд хүндэтгэлийн лекц уншив.

Энэ лекцийг Хууль зүйн үндэсний төвөөс санаачлан Шихихутуг ХЗДС-тай хамтран зохион байгуулсан юм. Ер нь Хууль зүйн үндэсний төв нь эрх

зүйн шинжлэх ухааны нэр хүндтэй, өндөр зэрэг цолтой эрдэмтэн нарынхаа хөдөлмөр, бүтээлийг сурталчлах, залуу үедээ туршлага сургамж болгох, алдар хүндийг нь мөнхжүүлэх зорилгоор “Хүндэтгэлийн лекц” нэртэй томоохон арга хэмжээ зохион явуулдаг уламжлал тогтоогоод байгаа юм.

О.Амархүүгийн хүдэтгэлийн лекцийн арга хэмжээг ХЗҮТ-ийн захирал, Академич, Монгол Улсын гавьяат хуульч Ж.Амарсанаа нээж үг хэлэв. Уг арга хэмжээтэй холбогдуулан Шихихутуг ХЗДС-ийн захирал, дэд профессор Д.Оюунцэцэг, Монгол Улсын Их Сургуулийн Хуулийн

сургуулийн дэд захирал, философийн доктор, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж нар илтгэл тавив.

О.Амархүүгийн уншсан сонирхолтой бөгөөд цаг үеийн тулгамдсан сэдэвт лекцийн судалгаа, дүгнэлт, онол практик, чанар чансаа, ач холбогдол болон уг эрдэмтний ажил хөдөлмөр, зүтгэл, бүтээл, зан чанарын талаар Академич С.Нарангэрэл, Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ж.Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэд сайд Ш.Сүхбаатар, Байгаль орчны яамны газрын дарга Т.Эрдэнэбилэг, Ардын жүжигчин Б.Зангад нарын 10 гаруй хүн үг хэлж, үнэлэлт дүгнэлт, санал бодлоо илэрхийлж, мэндчилгээ дэвшүүлж, бэлэг дурсгалын зүйлс, амьд цэцгийн баглаа гардуулан баяр хүргэв.

Мөн Шихихутуг ХЗДС-ийн багш, ажилтан нар болон оюутан, магистр нарын төлөөлөл багшдаа амьд цэцгийн баглаа барьж, талархал илэрхийлэн мэндчилгээ дэвшүүлэв.

Төгсгөлд нь Академич, Монгол Улсны гавьяат хуульч Ж.Амарсанаа уг арга хэмжээг дүгнэж үг хэлээд О.Амархүүгийн хүндэтгэлийн гэрэл зургийг Хууль зүйн үндэсний төвийн лекцийн танхимын хананд байрлуулав.

Энэхүү арга хэмжээний үеэр О.Амархүүгийн эрдэм шинжилгээний бүтээл, номын үзэсгэлэн гаргаж сурталчилав.

Манай сурвалжлагч

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ
ДОКТОР, ПРОФЕССОР О.АМАРХҮҮГИЙН АЖИЛ АМЬДРАЛЫН
ТҮҮХЭН ЗАМНАЛААС

Шинихутуг ХЗДС-ийн захирал, дэд профессор Д.Оюунцэцэг

Нэгэн хүмүүний тэр тусмаа хийж бүтээсэн их зүйлтэй, ажил амьдралын чигч зорилготой амьдралыг зөв байр суурьтай хүний туулж ирсэн замналын тухай маш их зүйл багтааж ярихыг хүссэн боловч цаг хугацаанд шахагдан илтгэлээ товчилсон тул та бүхнээс хүлцэл өчье

Увс аймгийн нутаг дэвсгэрт багтдаг Хан хөхийн нурууны шувтарга, зүүн үзүүр орчмоор нутагтай Зүүнхангай суманд малчины гэрт мэндэлсэн тэр нэгэн хүү өдгөө 70 насыг зооголжээ. Саяхан мэндэлсэн хүүдээ Амархүү гэсэн нэгэн сайхан монгол нэрийг аав ээж нь эрдэм номтой, түвшин амгалан хүн болохыг бэлэгдэн хайрласан гэдэг.

Арван нэгэн настайдаа сумынхаа бага сургуульд шинэ үсгийн цагаан толгойг анх заалгаж, бичиг үсэг, номын мөрд орсноос эхлэн тусгай мэргэжлийн дунд сургууль, Улсын их сургууль, Москва хотод аспирантурт суралцаж, хуульч мэргэжлийг эзэмшин улмаар **Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор** болтлоо боловсрол, өсөлт хөгжлийн замналыг туулсан байна.

Ажил амьдралын өсөлт хөгжлийн хувьд О.Амархүү багш бас л сонирхолтой түүхтэй хүн, 15 настайдаа бага сургуулийг төгсөн, сумынхаа захиргаанд сарын 70 тогрогний цалинтай галч -бичээчийн ажлаар төрийн албанд ажиллах гараагаа эхэлж байжээ. Сонгуулийн насанд хүрч сумынхаа сонгуульд оролцож, сумын депутатаар сонгогдон, улмаар сумын Гүйцэтгэх захиргааны нарийн бичгийн даргын албанд томилогдож 3 жил үр бүтээлтэй ажиллаад Улаанбаатар хотын Хууль цаазын дунд сургуульд сонгон шалгаруулалтаар элсэн суралцаж амжилттай төгссөн байна. Энэ бол 1962 он ажээ.

Дунд мэргэжлийн хуульчийг тэр үеийн Сайд нарын Зөвлөлийн Хэрэг

эрхлэх газрын Хуулийн хороонд зөвлөх, удалгүй ахлах зөвлөхийн ажилд томилон ажиллуулсан байна. Хуулийн хороо Шүүх Яам болж өөрчлөгдөн байгуулагдахад Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын хуулийн тасгийн даргаар томилон жил гаруй ажиллуулаад, хуучнаар ЗХУ-д аспирантурт суралцах уралдаант шалгаруулалтанд орохыг нь зөвшөөрч, улмаар шалгалтандаа тэнцэн эрдмийн их ажилд шамдан суралцахаар Москва хотын зүг хөлгийн жолоог залжээ. Гурван жилийн дараа дэд эрдэмтний зэргийг амжилттай хамгаалаад ирэхэд нь Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын хуулийн тасгийг хэлтэс болгон өргөтгөж, хэлтсийн дарга бөгөөд ХЭГ-ын орлогч даргын албанд томилон ажиллуулсан бөгөөд Засгийн газарт, нийтдээ 28 жил тасралтгүй хариуцлагатай ажил хийжээ. Үүний дараа тэр үеийн Шүүх яамны нэгдүгээр орлогч сайд, орлогч сайдаар томилогдожш тэнд 2 жил ажиллаж байгаад Монголын байгаль орчныг хамгаалах холбоо хэмээх олон нийтийн байгууллагын орон тооны ерөнхийлөгчөөр 1990-2000 он хүртэл хоёр удаа сонгогдон ажилласан байна.

О.Амархүү багш үндсэн ажлынхаа хажуугаар Улсын Их Сургуулийн Хуулийн оройн ангид суралцан хууль зүйн дээд боловсрол эзэмшжээ. Их сургуулиа төгсөөд төрөлх сургуульдаа болон 2000 оноос хойш Шихихутуг Хууль зүйн дээд сургуульд багшилсаар байгааг оролцуулан тооцоход тэрээр төр засаг, олон нийт, сургалтын байгууллагад 52 дахь жилдээ хүчин зүтгэж, мэдлэг мэргэжлээ дайчлан ажиллаж байгаа манай ахмад, тэргүүний сэхээтний нэг билээ.

Тавь гаруй жилд хийсэн бүтээснийг нь нэг бүрчлэн тоочих юм бол уртын урт жагсаалт болж, их цаг гарна. Тиймээс онцлох хэдэн зүйлийг товчлон хэлмээр санагдаж байна. Үүнд:

1. Монголын эрх зүйн системчлэлийн ажлыг онол, арга зүй, практик хэрэглээ талаас нь хамтран ажиллаж байсан монгол, орос нөхдийнхээ хамт Монголдоо анх удаа боловсруулан хэрэгжүүлэх ажлын эхэн болон дунд шатыг хийж дуусгалцсан.
2. Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хууль зүйн албыг бэхжүүлэхэд гар бие оролцон амжилтад хүргэсэн.
3. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах ажилд олон

жил уйгагүй хөдөлмөрлөж, өч төчнөөн хоногийн нойр, хоолоо хугасалж үр бүтээлтэй ажилласан

4. Засгийн газрын тогтоол шийдвэрийг хуульд нийцүүлэх, өөр хоорондоо зөрчилдөхгүй, давхардахгүй, бас хийлэл цоорхой гаргахгүй байлгахын төлөө цаг ямагт анхаарал, хүчээ төвлөрүүлж ажиллаж ирсэн

5. Монгол орондоо устаж үгүй болсон, монголын унаган амьтан тахийг уугуул нутагт нь сэргээн нутагшуулах судалгаа, шинжилгээ, практик ажлын олон улсын төслийг өөрийн орны болон гадаадын эрдэмтэн мэрэгжилтний оролцоотойгоор Засгийн газрын шийдвэрээр удирдан зохион байгуулж амжилттай хэрэгжүүлсэн нь дэлхий дахины анхаарал татсан содон соргог ажил болсон.

6. Олон зуун шавьтай болж, мэргэжилтэн, судлаач, эрдэмтэн төрүүлэх ажилд өөрийн бүхий л хүч хөдөлмөрөө дайчилж яваа зэргийг дурдахад сэтгэл хангалуун байна.

О.Амархүү багш үндсэн ажлынхаа зэрэгцээ төрийн болон сургалтын хэд хэдэн байгууллагад хариуцлагатай ажил үүргийг хавсран гүйцэтгэж ирснийг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Тухайлбал:

- Улаанбаатар хотын АДХ-ын /хуучин нэрээр/ депутатаар 1981-1990 оны 7 дугаар сар хүртэл 3 удаа сонгогдож, Хурлын байнгын хорооны дарга, улмаар хотын Хурлын Тэргүүлэгчдийн даргаар /орон тооны бус/ сонгогдон ажиллаж байжээ.

- Төрийн Хянан Шалгах хороо анх байгуулагдахад тус хорооны анхны гишүүдийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлаас томилогдож, 1995-2001 онуудад 6 жил ажилласан байна.

- Шүүхийн сахилгын хороог анх байгуулагдахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр 2002 онд томилогдож, 2005 он хүртэл ажиллажээ.

- Одоо Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх эрдэмтэн мэргэжилтнүүдийн зөвлөлийн хууль зүйн бодлогын салбар зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна

- Мөн холбогдох байгууллагын шийдвэрээр Улсын их сурууль, тухайн үеийн Намын дээд сургууль, Удирдах ажилтын мэргэжил дээшлүүлэх

институтуудад цагийн багшаар ажиллаж байжээ.

- “Улаанбаатар-эрдэм судлал” дээд сургуулийн хүндэт профессор цолоор шагнагдаж, тус сургуулийн болон Эко Ази дээд суруулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, тэдгээр сургуульд 1999 оноос 2004 онуудад Экологийн эрх зүйн хичээлийн бүрэн курсыг заасан байна.

О.Амархүү багш Шихихутуг ХЗДС-д Төр, эрх зүйн тэнхимийн эрхлэгч, “Шихихутуг” онол, арга зүй, мэдээлэл сэтгүүлийн ерөнхий редакторын ажлыг хавсран гүйцэтгэж байгаагаас гадна тус сургуульд магистрын сургалтын албыг шинээр байгуулж, даргаар нь амжилттай ажиллаж байна. Дэлхийн банкны Шүүх эрх мэдлийн шинэчлэл төслийн хүрээнд хууль зүйн сургалтын агуулга, арга зүй, хэлбэрт шинэтгэл хийх ажилд Амархүү багш бусад багш нар болон гадаадын зөвлөхүүдтэй хамтарч олон шинэ зүйл хийснийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

О.Амархүү багшийн эрдэм шинжилгээ судалгаа, хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийн асуудлаар хууль зүйн шинжлэх ухааны доктор, /Sc.D/, профессор багш Н.Лүндэндорж жич илтгэх учир би энд давхардуулан яримааргүй байна.

Амархүү багшийн ажил үйлс, хөдөлмөр зүтгэл, үр бүтээлийг төр засаг ондор үнэлж, түүнд Монгол Улсын гавьяат хуульч цол олгож, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадагс одонгоор 2 удаа, Хөдөлмөрийн хүндэт медаль, Ардын хувьсгалын 50, 60, 70, 80 жилийн ойн медаль, мөн Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медалиар тус тус шагнажээ. үүнээс гадна Амархүү багш “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан”, “Байгаль орчны тэргүүний ажилтан”, “Төрийн хяналтын байгууллагын тэргүүний ажилтан”, “Тэргүүний төмөр замчин” цол тэмдгээр шагнагдсан байна.

Огно өгүүлсэнээ нэгтгэн дүгнэвэл О.Амархүү багш ажилласан салбар болгондоо оайнга шинийг эхлүүлж, амжилтанд хүргэсэн байдаг нь манай багшийн цаг үеэ зөв мэдэрдэг, уйгагүй хөдөлмөрч, нягт нямбай, хариуцлагатай чанартай холбоотой юм. Хүний хувьд их өрөвч зоолон, хүнлэг, хамтран ажиллагсаддаа түшигтэй, өмөг түшиг болсон сайхан ханьтай, 5 сайхан хүүтэй өнөр өтгөн айлын өрхийн тэргүүн хүн юм.

Амархүү багшийн ажил амьдралын энэ гайхамшигтай замналыг өнөөдрийн энэ өндөрлөгөөс харахад төрийн зүтгэлтэн, нэрт эрдэмтэн хуульч, ардын багшийн цогц дүр нэгэн биед цогцолсныг харж болно.

Ингээд багцдаа сургуулийнхаа нийт хамт олны өмнөөс халуун байр хүргэж, эрдмийн их ажилд тань амжилт хүсч, эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Мөн энэ завшааныг ашиглан хуульч эрдэмтдийнхээ хүндэтгэлийн лекцийг ард түмний хүртээл болгож, мөнхжүүлж байгаа ХЗҮТ-ийн хамт олон, онцлон Монгол Улсын гавьяат хуульч, академич Ж.Амарсанаа таньд талархалаа илэрхийлье.

ПРОФ. О. АМАРХҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНД ОРУУЛСАН ХУВЬ НЭМРИЙН ТУХАЙ

Эрдэмтэн хүний шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг үнэлэх асуудал үнэлж байгаа хүнийхээ чадал тэнхээнээс хамаарсан хүнд хэцүү ажлаа. Хэрхэн үнэлж, дүгнэдэгийг сонирхоход нэлээд нарийн төвөгтэй, амар хялбар ажил биш байдаг юм байна. Хамгийн наад зах нь байгаль, нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаан өөр өөрийн онцлог, шалгууртай байх жишээтэй. Тухайлбал, байгалийн шинжлэлд хувь нэмэр оруулах, түүний үнэлгээний шалгуурыг тогтооход нэлээд хялбар байдаг бол нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах, түүнийг үнэлэх асуудал маш хэцүү байдаг юм байна. Мөн шинжлэх ухааны ололтыг дэлхийн төвшинд болон үндэсний хэмжээнд үнэлэх шинжлэх ухааны хил хязгаарын асуудал ч мөн нарийн ээдрээтэй зүйл байсаар байна.

Шинжлэх ухаанд нээлт хийх, шинэ зүй тогтол, давтамж, чиглэл олж тогтоохоос эхлэн шинжлэх ухааны ололтыг түгээн дэлгэрүүлж байгаа нь ч бас тухайн шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр гэнэ.

Мөн өмнөх судалгааны үр дүнг өнөөдрийн шалгуураар үнэлэх бус, харин тухайн үедээ юу хэлж чадсанаар нь үнэлэх ёстой ч гэж үздэг юм байна.

Доктор О.Амархүү 40-д жил төрийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлдэг зарим институцыг судалсан, одоо ч судалсаар байгаа монголын эрх зүй судлалын ерөнхий онолын салбарын төлөөлөгч юм.

Тэрээр ХХ зууны 70-д оны сүүлчээр “Хүрээлэн байгаа орчныг хамгаалах төр, эрхийн онолын зарим асуудал” сэдвээр хууль зүйн докторын судалгааны ажил хийж, хүрээлэн байгаа орчныг хамгаалах нь төрийн нэг бие дасан чиг үүрэг мөн гэдгийг нотолсон нь монголын судлаачийн төр судлалд оруулсан зүй ёсны хувь нэмэр мөн. Түүний энэ судалгаанаас өмнө социалист тогтолцооны орнуудын хууль зүйн шинжлэх ухаанд төрийн чиг үүргийг эдийн засаг, нийгэм, улс төр, үзэл суртлын хэмээн ангилахаас хэтрээгүй байсан юм. Тэгэхлээр, түүний энэ судалгаа

эрх зүйн онолын сэтгэлгээг урагшлуулах зохих хувь нэмэр болсон нь эргэлзээгүй юм.

Профессор О.Амархүү ХХ зууны 80-д оны дундуур төрийн захиргааны дээд байгууллага- Сайд нарын зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн асуудлыг судалгааны бие даасан объект болгон судалсан нь монголын эрх зүйн шинжлэх ухаанд төрийн байгууллагыг институцилен судлах шинэ хандлагыг төлөвшүүлэхэд чухал түлхэц болсон байна. Судалгааны энэ бүтээл нь өдгөө монголын гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын түүхэн хөгжлийн нэгэн зурвас үеийн шинж төлөв, хөгжлийн хандлагыг тодорхойлох судалгааны эх сурвалж болсоор байна.

Доктор О.Амархүү монголд төрийн дэглэм өөрчлөгдөж, ардчилсан үзэл санаа нэвтэрсний дараа социализмын үеийн судалгааны онол, арга зүйгээ түргэн өөрчилж, нийгмийн хөгжлийг шинээр үнэлэх парадигм-тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үүднээс монголчууд байгагч орчноо хэрхэн хамгаалж ирсэн уламжлалт зан заншил, хууль цаазыг монголын байгаль цаг агаарын онцлог түүгээр нөхцөлдсөн аж төрөх ёс, сэтгэлгээний хэв шинжтэй холбон монголын төр ёсны түүхийн бүхэл бүтэн үеийг хамруулан хийсэн судалгаа нь монголчуудын байгалиа хамгаалж ирсэн зан заншил, хууль цаазын сэтгэлгээний соёл, онцлог, түүний уламжлал, шинэчлэлийн чиг хандлагыг тодорхойлсноороо монголын эрх зүйн шинжлэх ухаанд судалгааны шинэ чиглэл бий болгосон байна. Энэ судалгааны явцад эрх зүйн болон түүхийн судалгааны олон эх сурвалжуудыг нэхэн судалж, монголын эрх зүйн түүхийн эх сурвалжийг өргөжүүлж, цаашид судалгааны эргэлтэд орох бололцоог нээж өгсөн байна.

Монголчуудын байгаль орчноо хамгаалах хууль цаазын соёл, сэтгэлгээг нэхэн судалсны үр дүнд тэрээр монголчууд бол дэлхийн улс орнуудаас байгаль хамгаалах хууль цаазыг анх бүтээж бий болгосон улс мөн гэсэн судлагааны таамаглал дэвшүүлснийг нь профессор Галдангийн Совд агсан “**цоо шинэ дүгнэлт**”, монголчуудын байгаль орчиндоо харьцаж ирсэн уламжлалт зан заншил нь байгаль хамгаалах сонгомол загвар гэдгийг нотолсон нь “**олон улсын ач холбогдолтой**” хэмээн ондөр үнэлж байсан байна.

Профессор О.Амархүү монголд газрыг хувьд өмчилж байсан эсэх талаар сүүлийн жарны турш манай болон монгол судлаачдын дунд өрнөсөн маргааныг хагалахад хамгийн жинтэй судалгааны үндэслэл дэвшүүлсэн цөөн эрдэмтдийн нэг мөн. Тэрээр монголчууд газрыг хувьд өмчилж байсан эсэхийг түүхийн эх сурвалжуудад тулгуурлан нягт нямбай судлахын хамт энэ маргаанд оролцож ирсэн судлаачдын судалгааны дүгнэлт таамаглалуудыг харьцуулан судалж, нягтлан шалгаж, монголд газар бүхий л түүхийн туршид улсын өмч байсан гэсэн судалгааны таамаглалын үндэслэлийг хамгийн ултай боловсруулсан эрдэмтэн юм. Монголд газрыг хувьд өмчлүүлдэггүй зөвхөн улс өмчилж байсан учир шалтгааныг “азийн үйлдвэрлэлийн арга”-аас үүдэлтэй төрийн удирдлага, оролцооны хэрэгцээ, шаардлага, газрыг улс өмчилж байх эдийн засгийн шалтгаан, онцлогоор нотолж, үүнийг бас давхар эрх зүйн эх сурвалжийн судалгаагаар нотолж чадсан билээ. Энэ асуудалд монголын янз бүрийн салбарын олон эрдэмтэд санал, үндэслэл дэвшүүлж, онохоосоо илүү алдсан нь олонтаа байлаа. Бас олон эрдэмтэн улс өмчилж байсан гэж хэлж, бичиж байсан хэдий ч доктор О.Амархүү шиг үндэслэл, нотолгоогоо тал бүрээс нь гаргаагүй юм. Энэ бол түүний зөвхөн монголны эрх зүйн шинжлэх ухаанд төдийгүй нийгмийн бусад шинжлэх ухаанд нийтлэг ач холбогдолтой хувь нэмэр юм.

Доктор О.Амархүү монгол дахь орчин цагийн экологийн эрх зүйг шинээр төлөвшүүлэн хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр ч багагүй бий.

Эцэст тэмдэглэхэд эрдэмтэн хүний аливаа шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг тоогоор бус харин чансаагаар хэмждэг жишиг байдгийг бодож, эрх зүйн шинжлэх ухааны доктор, профессор Осорын Амархүү гуайн монголын эрх зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг энэхэн хэдхэн зүйлээр хэлэхэд хангалттай болов уу гэж найдаж байна.

Дутуу дулимаг ухаарсанаас болоод алдаж оносон, гээж орхигдуулсан зүйл лавтай байгаа байхаа. О.Амархүү доктороос уучлал хүсэж байна.

Философийн доктор, зүйн шинжлэх ухааны доктор, проф. Н.Лүндэндорж

ШИНЭ НОМ

2006 онд хууль зүйн салбарын эрдэмтэд, судлаачид дараах ном бүтээлийг та бүхний хэрэгцээнд зориулан гаргасныг товчлон хүргэе.



◆ Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор, профессор Б.Чимэд багшийн “Оноогийн улс төр хуульчийн нүдээр” ном хэвлэгдэн таны гарт очиж байна. Нийгмийн олон талт улс төрийн асуудлыг онцолж хуульчийн үзэл бодлын үүднээс тайлбарласан энэхүү ном нь хууль зүйн нарийн нэр томъёо, хатуу үг аль болох хэрэглээгүй энгийн үгээр гэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалгаанд тулгуурлан тайлбарлан бичжээ. Энэхүү ном нь хуульч, улс төр судлаачид төдийгүй энгийн иргэдийн улс төрийн мэдлэгт чухал хувь нэмэр оруулах нь



дамжиггүй. Доктор, профессор Б.Чимэд багшийн 2006 онд хэвлэгдэж гарсан “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” ном та бүхний ширээн дээр очиж байна. Үндсэн хуулийн үзэл санааг амьдралд хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан тушаалтан юу хийх, иргэн нийгмийн амьдралд оролцох эрхээ эдлэх, хамгаалуулах боломж, бололцоо, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон бичсэн энэхүү номыг оюутан,



багш, судлаачдад төдийгүй төрийн албан хаагчид улс төрчлөд зорилан гаргажээ.

◆ МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор Т.Мөнхжаргал багш “Монгол Улсын иргэний цаазын товчоон” нэг сэдэвт бүтээл туурвиж, Монголын эртний үеийн иргэний цаазаас шинэ үеийн иргэний хуулийн хөгжил хүртэлх иргэний хууль-цааз, эрх зүйн хөгжлийн түүхэн уламжлал, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлагыг судлан бичсэн нь шинжлэх ухааны үнэ цэнэтэй бүтээл болсон байна. Т.Мөнхжаргал багшийн энэхүү ном нь



хуульч судлаачдын эрэл хайгуулд оюуны урам хайрласан бүтээл юм.

◆ Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан, судлаач хууль зүйн ухааны магистр П.Ихбая, магистр Б.Мөнхдорж нарын хамтын бүтээл болох “Гэмт хэргийн статистик” нэг сэдэвт бүтээл 2007 он гарангуут хэвлэгдэн гарлаа. Энэхүү бүтээлийг зохиогчид ЦЕГ-ын мэдээлэл судалгааны төв үүсч байгуулагдсаны 40 жилийн ойд зориулсан бөгөөд гол онцлог нь гэмт хэргийн статистикийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулсан иж бүрэн программаар гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдэгчийн талаархи тоо мэдээллийг цуглуулан боловсруулах, статистикийн аргаар судалгаа шинжилгээ хийж түүний шалтгаан нөхцөлтэй холбоотойгоор орон зай, цаг хугацаанд судлах онолын ойлголтыг боловсруулан судалсанд оршино.

Бэлтгэсэн: Б.Бат-Ерөөлт